

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ

Бат-Очирын Мөнхтуяа

**Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмж
илэрснийг судалсан нь**

(Монгол уран сайхны эхийн жишээн дээр)

Мэргэшил : Монгол хэлшинжлэл

Индекс: F221300

Хэлбичгийн ухаанаар
доктор (Ph.D) –ын зэрэг
горилсон диссертаци

Эрдэм шинжилгээний удирдагч:
Монгол Улсын Шинжлэх Ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх
ухааны доктор, профессор Бямбажавын Пүрэв-Очир

Улаанбаатар хот
2012 он

Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмж илэрснийг судалсан нь

0. Удиртгал

0.1.	Эрдэм шинжилгээний ажлын онолын үндэслэл	3
0.2.	Сэдвийг судлахын учир, шинэлэг тал	6
0.3.	Сэдвийн судлагдсан байдал	8
0.4.	Судалгааны ажилд дэвшүүлсэн таамаглал	17
0.5.	Судалгааны ажлын зорилго, зорилт	17
0.6.	Судалгааны арга	18
0.7.	Судалгааны ажлын ач холбогдол	19
0.8.	Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн	19
0.9.	Судалгааны ажлын агуулга, бүтэц	19

1. Нэгдүгээр бүлэг: Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

1.1.	Үнэлэмж, өгүүлэгчийн эерэг үнэлэмж	20
1.2.	Чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь	29
1.3.	Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь	56
1.4.	Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь	64
1.5.	Амьдчилалт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь	75
1.6.	Хэтрүүлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь	82

2. Хоёрдугаар бүлэг: Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

2.1.	Үнэлэмж, өгүүлэгчийн сөрөг үнэлэмж	88
2.2.	Чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь	90
2.3.	Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь	104
2.4.	Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь	107
2.5.	Амьдчилалт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь	112

3.	Дүгнэлт	117
-----------	----------------------	------------

4.	Хураангуй	118
-----------	------------------------	------------

5.	Номзүй	122
-----------	---------------------	------------

0. Удиртгал

0.1. Эрдэм шинжилгээний ажлын онолын үндэслэл

Монгол хэлэнд тодотгол гишүүн нь утгазүйн хувьд юмын шинжийг зааж, тодотгогч-тодотгуулагчийн холбоо харьцаанд түшиглэн илэрч, тухайн өгүүлбэрийн нэр гишүүний тоо чанар, хэмжээ, хамаа харьяа, орон цаг, жиших, адилтгах зэрэг аль нэг тусгай шинжийг нь тодотгон зааж дэлгэрүүлдэг.

Монгол хэлний төрөл бүрийн эх, цогцолбор, нийлмэл өгүүлбэр, нийлэмж үг, хэлц гэх мэт төгс ба төгс бус аль нэг нэгжийн бүтцэд тодотгогч-тодотгуулагчийн харьцаа холбоог үзүүлж, утгазүйн хувьд, өгүүлбэрзүйн айн утга болон янз бүрийн шилжсэн утгыг илтгэх нь зохих учир шалтгаантай, өвөрмөц зүй тогтолтой байдаг сонин үзэгдэл юм.

Нэгдүгээрт, Ямар аймгийн үг, ямар аймгийн үгтэй хэлзүйн зүй тогтлоор холбогдож, тодотгогч-тодотгуулагчийн харьцаанд орох эсэх нь уг чанартаа учирзүйн зүй тогтлоор хязгаарлагдаж байдаг. Өөрөөр хэлбэл нэг үг, нөгөө үгтэй өгүүлбэр ба эхийн дотор холбогдож нийлэмж үг үүсгэхэд хэлний ба хэлний бус хүчин зүйлийн нөлөө байдаг гэсэн үг юм. Иймээс хэлшинжлэлд тэмдэглэгдэхүүн ба тэмдэглэхүүний харьцаанд нэг үгийн нөгөөг нэгдүүлэх чадамж нь байгаль, нийгмийн юм, үзэгдлийн харилцан шүтэлцээ, бэлгэдэл, сэтгэхүйн хийсвэрлэл зэрэгтэй холбоотой байдаг. Жишээлбэл, Монгол хэлний “амуу” гэдэг нэр үг, ”эрдэм” гэдэг нэр үгтэй холбогдож тодотгох тохиолдол байдаг. Энэ нь “амуу” гэдэг үгэнд бага, жижиг, өчүүхэн бас өсөж үрждэг, урган төлжиж арвиждаг гэх мэт салаа утга, бэлгэдэл байдагтай холбоотой. Улмаар энэ нь сэтгэхүйн хийсвэрлэл ба бэлгэдэлтэй нөхцөлдөж, “амууны төдий эрдмийг амиа гартал сахих” (Лу.Алтан товч) гэх мэтээр “амууны төдий эрдэм” гэсэн нийлэмж үүссэн байдаг нь ”өчүүхэн эрдэм” гэсэн ойролцоо утга илэрхийлэх юм.

Хоёрдугаарт, Тодотгогч-тодотгуулагч бүхий нийлэмжийг судлахдаа зөвхөн холбоо үгийн түвшинд задлан үздэг хандлага нь учир дутагдалтай болж байна. Яагаад гэвэл, холбоо үг, хэлц үг нь хам ба цуваа цагт өгүүлбэрийн ч бүрдэл хэсэг, цогцолборын ч бүрдэл хэсэг, эхийн ч бүрдэл хэсэг байдаг бөгөөд эцсийн эцэст харилцах мэдээлэх үүрэг бүхий эхийн дэвсгэр дээр цуваа бүтцэд утга нь илэрч тайлагддаг гэж үзэж болно. “Бүхлээс нэгжийг гаргах буюу дедукцийн арга нь нэгжийг нэгтгэн дүгнэх индукцийн эсрэг

хандсан байдаг. Хэлшинжлэлийн уламжлалт судалгаа нь ерөнхийдөө авианаас авиалбар, түүний айд, нэгжийн утгаас утгын бүлэглэлд тулгуурладаг.

Дедукцийн арга нь бүхлээс түүний бүрдүүлэгч махбод руу чиглэдэг”.¹ гэснээс үзэхэд бид ч аливаа нийлэмж үгийн задаргааг хийхдээ хэлний хамгийн дээд төвшний төгс нэгж ”эх”-ийн дэвсгэр дээр хийвэл илүү ач холбогдолтой байна. Тиймээс ямар аймгийн үг, ямар аймгийн үгтэй холбогдож, ямар утга үзүүлэх нь тухайн эхийн ерөнхий ба тусгай шинж, өгүүлэмжийн онцлог, агуулгын тал, чөлөөт найруулгын эх үү, чөлөөт бус найруулгын эх үү, сонин нийтлэлийн найруулгын эх үү, эрдэм шинжилгээний найруулгын эх үү, аль эсвэл албан хэргийн найруулгын эх үү гэдгээс шалтгаална гэсэн үг. Тухайлбал, ”усан нүд”, ”усан тэнэг” гэх мэт нийлэмжүүд гол төлөв ярианы найруулгатай эхэд тохиолдож байх жишээтэй. Зохиолч Л.Ванган ”Жож Сэрээнэн” өгүүллэгтээ Сэрээнэн өвгөний гадаад төрх, алиа хошин, хоргүй, хөнгөн шогч зантайг ”усан алиа” хэмээн дүрсэлсэн байдаг. Түүнчлэн ямар үг, ямар үгтэй холбогдож, шууд ба шууд бус нэрлэлт бүхий нийлэмж үүсгэх нь уг бичвэр нь найруулгын төрөл, хэв маягаас хамаарч болох талтай. Энэ нь цаанаа тухайн эхэд үг, нийлэмж үг, өвөрмөц ба хэвшмэл хэлц, мөн тэрчлэн өгүүлбэрийг сонгосон эх зохиогчийн найруулах эрдэм, аргазүй, туршлагатай холбоотой юм. Тухайлбал, сонин нийтлэлийн найруулгатай тайлбарламж эхэд ”хөлчүү” гэдэг тэмдэг үг ”эр”, ”хүн” гэх мэт үгийг тодотгон нэгдэж, ”хөлчүү эр”, ”хөлчүү хүн” гэх мэт нийлэмж үүссэн байх хэлзүй, учирзүйн эх бичвэрийн зүй тогтолтой. Тэгвэл, ”хөлчүү” гэдэг тэмдэг үг ”зэрэглээ” гэдэг нэр үгтэй нэгдэж, тодотгогч-тодотгуулагчийн харьцаагаар холбогдох нь гагцхүү урансайхны зүйрлэл бүхий дүрсэлсэн эхэд хийсвэрлэлийн үр дүнд л үүссэн байх боломжтой.

Иймээс ”Завхан гол” дууны шүлэгт

Хөлчүү зэрэглээг сандаасан

Хөлөрсөн манхныг сэрүүцүүлсэн...(Н.Л) гэх мэтээр ”хөлчүү зэрэглээ” гэсэн шууд бус нэрлэлтийн үг үүссэн байдаг баримт бий.

¹Равдан Э., Бүтэц хэлшинжлэл,Уб.,1998.25-р тал.

Гуравдугаарт, Утга судлалын талаасаа, эх бичвэрт ямар үг, ямар үгтэй холбогдож, тодотгогч-тодотгуулагч харьцаанд орох нь хэлний ба хэлний бус орчин, хам нөхцөл, өгүүлэгчийн үнэлэмж, дотоод яриа, дүрслэх ба яруу хэрэглүүрийг хэрхэн ашиглах аргатай холбоотой. Эрдэмтэн Д.Бадамдорж: “Үгийн сангийн тухайн нэгжийн анхны гол (цөм) утга нь хэрэглээний явцад гол төлөв зүйрлэх, адилтгах байдлаар өөрчлөгдөхийг утга шилжих гэнэ. ...Үгийн цөм утгаас гадна, хүний хийсвэрлэн сэтгэх үйлийн үр дүнд үүссэн салаа олон утга гэж бий. Үгийн салаа утга гэдэг бол үгийн цөм утгаас салбарласан, ухагдахууны багтаамж тэлснээс үүссэн утга юм”² гэх мэтээр тэмдэглэсэн байхад, эрдэмтэн Ж.Төмөрцэрэн: “Үгийн салаа утга хэдий олон боловч тэр үгийнхээ үндсэн утгатай хэлхээ холбоо нь тасраагүй байдаг.”³ гэжээ. Чухам тиймээс ч “усан судал”, “усан зэрэглээ”, “усан болор”, “усан хээ”, “усан хаван”, “усан тарга”, “усан алиа” гэх мэт шууд бус нэрлэлтийн холбоо үгийн утгаас шилжсэн утга, зүйрлэл, хам нөхцөл хэрэглээний онцлогоор тайлбарлах учиртай.

Хэлшинжлэл, уран зохиол хоёр салшгүй холбоонд байх төдийгүй хэлний хөгжил, хэрэглээний илэрхийлэл нь уран зохиол болж байдаг. Хэлний баримтад туссан үндэстний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, соёл, зан заншил зэргийг дүрслэлт чимэг тодотгол буюу тодотгогч-тодотгуулагчийн харьцаа талаас харвал, өгүүлэгчийн зориуд оруулсан үнэлэмжийн янз бүрийн өнгө аясаар арвин байдаг.

...Холоос хүүгээ хүлээсэн

Хайрын тэнгэр ижий минь (Л.Мөнхтөр, “Хулстайн гурван даваа”)

...Хазайхад минь тулдаг

Хэлтийхэд минь түшдэг

Ачит сайхан аав

(Д.Гомбожав, “Ачит сайхан аав”)

гэх мэт эцэг, эхийн ачлахуйн олон зүйл үйл, хувиршгүй их хайрын тухай сэтгэл хөдлөм магтан дуулсан эерэг үнэлэмжийн бахархан хүндэтгэсэн өнгө аястай дүрслэлт чимэг тодотгол олон бий.

Баймгай хар хорвоод нь, хөөрхий

Байгаа бүгд худал шиг

²Бадамдорж Д., Монгол хэлний утга судлалын үндэс, Уб.,1998.34-60-р тал.

³Төмөрцэрэн Ж., Монгол хэлний үгийн сан судлал,Уб.,1975.28-р тал.

Байзнас гээд нэг бодохноо

Өөрийн бие ч хуурмаг шиг... (Д.Урианхай, “Гуниглахуйн гэгээ”)

гэх мэт хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл нь өгүүлэгчид заримдаа таагүй сэтгэгдэл төрүүлж байдгийг илэрхийлсэн сөрөг үнэлэмжийн жишээ бас цөөнгүй байдаг. Тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай дүрслэлт чимэг тодотгол нь хэлц ба хэлц бус нэгжээр илэрсэн уран тодотголын үүрэгтэй байхын зэрэгцээ өгүүлэгчийн үнэлэмж, үндэстний соёл, сэтгэлгээ танин мэдэхүйн онцлог шинжийг илэрхийлнэ.

0.2 Сэдвийг судлахын учир, шинэлэг тал:

Монгол хэлний өгүүлбэрийн хэлзүйн тодотгол гишүүний илрэх, хэлбэржих, харьцаа холбоо, арга хэрэглүүр, хэлзүйн утга, байр, ангиллын талаас нь голлон судалж иржээ. Орчин цагийн хэлшинжлэл, соёл судлал, утга зохиолыг үзэх үзэл, философи сэтгэлгээ тэргүүтэн нь эдүгээ бичиг соёлын “цөм” асуудал болох эхийн судалгаанд онцгой анхаарал хандуулах болсон байна.

Уран сайхны эхийн түвшний хураангуй ба дэлгэрэнгүй олон янз чимэг тодотгол ба тодруулагчийн найруулгын үүрэг, өнгө аяс, түүний утга соёл зэрэг нь тусгайлан судалмаар сонин сэдэв. Ялангуяа, тодотгогч-тодотгуулагчийн харьцаа хамаарал, хэвшинж, утга, захирах холбоог монгол хэлний дүрслэх ур маяг, үндэстний соёл, сэтгэлгээ, өгүүлэгчийн үнэлэмжтэй холбон авч үзэх нь орчин цагийн туурвилзүй, найруулгазүй, үгээр урлах эрдэм, эхийн судлал болоод өгүүлбэр судлалд олон талаар хамаатай асуудал юм.

Өнөөдөр хэл-соёл судлал (лингвокультурология), танин мэдэхүйн хэлшинжлэл (когнитивная лингвистика), хэлэхийн хэлшинжлэл (лингвистика речи) зэрэг хэлний утга ба хэрэглээний талыг чухалчилсан шинэ шинэ чиглэл бий болсноор хэлний зогсонги шинжийг төдийгүй, хөдлөнгө шинжийг чухалд үзэж байна.

Хатуу логикт шүтэн хэлийг ангилах, баримт тоочихоос цэцэн мэргэн өгүүлэх, сэтгэл зүрхнээсээ бичихэд шилжих нь хэлийг “прагматикчилах” гол хандлага болж байна.”⁴ Орчин цагийн хэлшинжлэл хэлний бүтэц зохион байгуулалтыг дан ганцаар чухалчлалгүй, хэлний нэгжийн хэрэглээг өргөн хам

⁴Базаррагчаа М., Монгол хэлний өгүүлбэр судлал, УБ., 2005. 410-р тал.

хүрээнд хэлийг хэрэглэгч, бүтээгч хүний хүчин зүйлтэй нь нягт шүтэлцээнд судлах болсон нь хэлшинжлэлийн өнөөгийн чиг хандлага, гол онцлог болж байна.”⁵

“Хэл зөвхөн текстийн түвшинд, тэр тусмаа уран сайхны эхийн түвшинд л соёл иргэншлийн болоод оюун санаа ахуйн үнэмлэхүй дүр, сэтгэхүйн буюу танин мэдэхүйн дамжиггүй бодот байдал болох үндсэн оршихуй (эксистенци), танин мэдэхүйн ач холбогдлоо илэрхийлдгийг орчин цагийн томоохон сэтгэгчид, уран бүтээлчид онцгойлон тэмдэглэдэг болсон нь жир хэрэг биш билээ.”⁶

Тиймээс монгол хэлний тодотгол гишүүнийг өгүүлбэр судлалын судлагдахуун болгон хэлбэр, бүтцийн талыг нь голчлон судлахаас гадна өгүүлбэр-эх судлалын судлагдахуун болгон утга, хэрэглээг нь чухалчлан судлах шаардлагатай.

Монгол хэлний уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотгол (образное определение) –ын утга, үүрэг, хэрэглээг мэдэгдэхүүн-хэлэгдэхүүн-хэлэхүүн-мэдэхүүн гэсэн хослог дөрвөлсөн ангиллын үүднээс авч үзвэл:

Загвар№1



гэсэн хэлний гадаад ба дотоод тал, хэлний хөдлөнгө ба зогсонги талыг хамарсан судлагдахуун болж байна.

⁵Нансалмаа Н., Хэлшинжлэлийн судалгааны аргазүй,Уб.,2011.13-р тал.

⁶Энхбаяр С., Утга зохиолын онол,Уб.,2011.303-р тал.

Шинэлэг тал:

Тодотгогч-тодотгуулагчийн харьцаа бүхий нийлэмжийг судлахдаа зөвхөн холбоо үгийн түвшинд задлан үздэг хандлага нь учир дутагдалтай болж байна. Учир нь, холбоо үг, хэлц үг нь хам ба цуваа цагт өгүүлбэрийн ч бүрдэл хэсэг, цогцолборын ч бүрдэл хэсэг, түүнчлэн эхийн ч бүрдэл хэсэг байдаг бөгөөд эцсийн эцэст харилцах мэдээлэх үүрэг бүхий эхийн дэвсгэр дээр цуваа бүтцэд утга нь илэрч тайлагддаг гэж үзэж болно.

Дүрслэлт чимэг тодотгол (образное определение)-ын утга, үүрэг, хэрэглээг хүний танин мэдэхүй, сэтгэлгээний үйл явц, үр дүн талаас нь шинжилсэн судалгаа ховор бөгөөд монгол уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголыг орчин үеийн хэлшинжлэлийн нэгэн чиглэлийг тодорхойлогч танихуйн хэлшинжлэл ба хэлэхийн хэлшинжлэлийн үүднээс судалснаар дүрслэлт чимэг тодотголын “утга-хэлбэр-үүрэг-хэрэглээ”-ний онцлогийг “цогц” байдлаар тодорхойлоход чиглэсэн, шинэлэг ажил болно.

Дүрслэлт чимэг тодотголын зарим жишээг юуны өмнө “танихуйн хэлшинжлэлийн багц мэдлэг гэх ойлголт, багц мэдлэг нь сэтгэлгээний цогц болохын хувьд утгын агуулгаасаа гадна үнэлэлт үнэлэмж хүний ямар нэг юманд хандаж буй харьцааг багтаадаг”⁷ гэдэг үндэслэлтэй холбон судлах нь бидний энэхүү ажлын **шинэлэг тал** юм.

0.3. Сэдвийн судлагдсан байдал:

0.3.1 Монгол хэлний өгүүлбэрийн хэлзүйн тодотгол гишүүний хэлбэр, утга, үгийн айгаар илрүүлэх хийгээд холбоо харьцаа, байр, ангиллын талаас мөн хэлзүйн болон мэдэгдлийн үүргийн талаас нь зохих түвшинд судалж иржээ.

Профессор Г.Д.Санжеев “Буриад-монгол хэлнийзүй” (1941), “Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй” (1953), профессор Т.А.Бертегаев “Өгүүлбэрзүй” (1964), академич Ш.Лувсанвандан 1939, 1951,1956 оны сурах бичгүүд болон “Орчин цагийн монгол хэл” (1962), эрдэмтэн Э.Вандуй “Тодотголын тухай” (1958), Ш.Барайшир “Өгүүлбэрийн гишүүн” (1980), Ц.Өлзийхутаг “Тодотгол гишүүн”, “Орчин цагийн монгол хэлзүй” (1962),

⁷ Маслова В.А, Введение в когнитивную лингвистику,М., 2008.с.54.

Б.Пүрэв-Очир "Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй" (1997), "Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй" (2001), "Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ 6" (2007), М.Базаррагчаа "Монгол хэлний өгүүлбэр" (1987), "Өгүүлбэр судлал" (2005), зэрэг бүтээлд монгол хэлний тодотгол гишүүнийг хэл, хэлэхүйн тал, хэлбэр, бүтцээс нь хөндөж сонирхолтой ажиглалт, дүгнэлт хийсэн байдаг.

Монгол хэлшинжлэлд харилцахуйн төгс санаа болох эх, ялангуяа уран сайхны эхийн утга, бүтэц хувиргал, найруулга соёлын талаас нь судлах хандлага өргөжин тэлж, тодотгогч-тодотгуулагчийн харьцаа, утга, үүрэг, хэрэглээг уран сайхны эхийн түвшинд авч үзэж судлах болжээ. Эрдэмтэн Б.Пүрэв-Очир "Монгол хэлний эх задлалын асуудлууд" (2002), "Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй" (2005), "Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ" (2009), "Үг, өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ" (2011) бүтээлд "Монгол хэлний тодотголын найруулгын утга, үүргийн талаарх ажиглалт", "Монгол хэлний тодотгол харьцаа ба тонгоргон хувиргах аргын шүтэлцээ", "Монгол хэлний "эх, ээж" гэдэг үгийг тодотгосон дүрслэлт чимэг тодотголын хэвшинж, утга үүргийн талаар хийсэн ажиглалт", "Монгол хэлний "эх" гэдэг үг эрхэм сайхан тодотголтой", "монгол хэлний "-хан"⁴ бүтээвэр бүхий үгсийн өгүүлбэрзүйн байр, утга, үүрэг, хэрэглээ" (тодотгогчийн байранд тохиолдох "-хан" бүтээвэр бүхий үгсийн утга, хэрэглээ)", "салхи хийгээд салхилах ("салхин"-нд ямар тодотгол хүртээж хэрэглэв)" зэрэг сонирхолтой судалгааны өгүүллүүд нийтэлжээ.

Тодотгол гишүүний судалгааг үзэхэд тодотголыг хэлбэр хэлзүйн талаас судалсан нь өргөн хүрээтэй байгаа боловч найруулгазүйн шинжтэй уран найруулгын тодотголын утга руу орж судалсан нь ховор байна. Иймээс тодотголын судалгаанд судлалгүй орхисон зүйл их бөгөөд шинэлэг судалгаа хэрэгтэй байна.

0.3.2. Тодотголыг уран зохиол, найруулгазүйн талаас авч үзвэл, дүрслэлт чимэг тодотгол, чимэг үг, яруу дүрслэх ур маягтэй холбон судалж иржээ. Зохиолч дүрсэлж байгаа үнэн байдлын чухам ямар талыг онц чухалд үзэж байгааг илтгэхэд дүрслэх ур маяг (тропа) чухал үүрэгтэй бөгөөд чимэг, адилтгал, зүйрлэл, тойруулал, ихэсгэл, багасгал, ёгтлол, егөөдөл, төлөөлөл,

хүншүүлэл, юмшуулал зэрэг нь үгийн утга шилжүүлэн хэрэглэж бүтдэг гэж үздэг байна.

Чимэг үг (эпитет-epithet) грек хэлний хавсрах, тодруулах гэсэн утга бүхий үгээс гаралтай нэртомъёо болно. Чимэг үг (эпитет-epithet) буюу уран тодотгол гэсэн ойлголтыг уран зохиол шинжлэлд хэрхэн тодорхойлж тайлбарласныг авч үзэх нь уг судалгааны ажил болоод сэдвийн үндэс, онол практикийн ач холбогдлыг илрүүлэх чухал суурь болох юм.

Чухам хэлбэр хэлзүйн тодотгол, чимэг үг (эпитеты) буюу дүрслэх чимэг үг (изобразительные эпитеты)-ээр илэрсэн урансайхан тодотголууд (красочные определения)-ын ялгаа, онцлогийн талаар зохист аялгууч Дандин “Зохист аялгууг үзэсгэлэн болгогч аргуудыг чимэг хэмээн сайтар нэрлэхүй”⁸ хэмээн тэмдэглэсэн бол Жамъянгарав ... дууны болон утгын чимгийг юуны өмнө тодорхойлохдоо: Номнуудын (юмсын) мөн чанар хийгээд орон ялгалын ёсыг шулуун (бодитой байгаа байдлаар нь) ба гажуу (хэтийдүүлсэн байдлаар нь) алин нэгний нь үүднээс, гол зонхид өгүүлэгдэхүүний утгын зохист байдлын үлэмж хэтэрхий ялгалыг өгүүлсэн, өгүүлэгчийн үг элдэв (зүйл) дүр (дүрслэл) лүгээ төгөлдрөөр машид ялгаран нэгэн язгуур зүйлд багтаж орсон, үгийн найруулга хотол чуулган төгссөнийг сайтар бүрэн төгс боловсорсон утгын чимэг гэнэ. Гол зонхид үг найруулгад өөрийн өгүүлэгчийн дууны (хэлний) зохист байдлын үлэмж хэтэрхий ялгалт зохиолын үг (хэл) нь хос төгөлдөрийн элдэв (зүйл) дүр (дүрслэл) төгөлдрөөр машид ялгаран нэгэн язгуур зүйлд багтан орсон үгийн найруулга хотол чуулган төгссөнийг дууны чимэг гэнэ.” (“Жамъянгарав,х.25бб-26а3) гэж мөн чанарын гол тодорхойлолтыг өгчээ. “Утгын чимэгт” өгүүлэгдэхүүний утгын үзэсгэлэнтэй сайхныг голлох боловч, өгүүлэгчийн үгийн тансаг сайхнаас огт хамаагүй бус, “дууны чимэгт” өгүүлэгчийн үгийн үзэсгэлэнтэй сайхныг голлох боловч өгүүлэгдэхүүний утгын тансаг сайхнаас огт хамаагүй бус, чухамдаа нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй харилцан шүтэлцсэн шинж чанартай зүйл болохыг өгүүлжээ. Ингэснээрээ зохиолын уран сайхан, зохиолчийн хэлтэй, зохиолчийн хэл

⁸Гаадан Х., Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл,Уб.,1986.15-р тал.

зохиолын уран сайхантай ямар холбоо хамааралтай болохыг авч үзсэн хэрэг юм”.⁹

Эрдэмтэн Х.Гаадан: Чимэг үг бол Дандины толинд гардаг уран дүрслэлийн нэг түгээмэл хэрэглүүр мөн. Юмны бүхэл шинжийг (өөрөөр, энэ зохиолд гардаг нэртомъёогоор хэлбэл) нь бусдаас онцгой болгон харуулахад чимэг үг хэрэглэсэн байдлыг дараах жишээнээс үзэж болно.

Үүнд: “Үүрийн гэгээний улаан шаргал өнгөтэй үүрд залуу насан идэр цогтой” гэж хүнийг магтан өгүүлсэн байна. Энэ бол хүний язгуурыг гаргахдаа жавхланг нь хүний сэтгэлд сайхан гэж ойлгогдох түгээмэл өнгө, байдал хоёроор тодотгож чимэглэн харуулсан байна. Энэ нь зүгээр нэг улаан өнгөтэй, залуу настай гэсэн тодотгол бус сэтгэлд сайхныг нэвтрүүлж чадах онцлогийг гаргасан чимэг үг юм. Мөн магтах юмныхаа үйлс эрдэм тэргүүтнийг бас чимэг үгээр гаргаж болдог байна.”¹⁰ гэж тайлбарлажээ.

Эрдэмтэн Ш.Гаадамба: “Чимэг үг (эпитет) гэж дүрсэлж байгаа зүйлийн чухал онцлогийг тэмдэглэх зорилгоор хэрэглэсэн онцгой тодотголыг хэлнэ.

Жишээлбэл, Хүрэн дээлтэй хүн ирлээ. гэвэл тэр хүний дээл улаан биш, цагаан биш, харин хүрэн байв гэж өнгийг ялгасан тул жирийн тодотгол болно. Гэтэл, “Үүрийн туяа” романы тэргүүн дэвтрийн 27 дугаар талд “...гүрэмч, чийрэг хүрэн гартаа сор бариад... гэх зэргээр бичсэн нь гүрэмчийн гар шар буюу хар байсангүй, харин “хүрэн” байв гэсэн өнгийг заах гэсэн санаа биш, харин “булиа чадалтай байв” гэсэн утгыг гаргасан чимэг үг бололтой.

Гэсэрийн туужид “Арван зүгийн эзэн Чингис хаан билгийн хээр морио унав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт хүхэр хар хуягаа өмсөв” гэх зэргээр бичжээ. “Арван зүгийн Гэсэр хааны тууж оршив” (дэд дэвтэр 95 дугаар тал) Үүнд: “билгийн хээр морь”, “шүүдрийн гилбэлгээн өнгөт”, “манлай цагаан дуулга” гэх зэрэг нь зөвхөн өнгө шинжийг ялгах зорилгоор хэрэглэгдээгүй, харин хүний сэтгэлд уран тод буухаар хэрэглэсэн тодотгол мөн учир дүрслэх чимэг үг мөн байна.

Яргачин та нарын хар цус

Яруу шүлэгч Пушкиний

⁹Хүрэлбаатар Л., Эсэруагийн эгшиг дуун,Уб.,1999.151-р тал.

¹⁰Гаадан Х., Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл,Уб.,1986.16-р тал.

Ариун үнэнч цусыг

Арилган угааж чадахгүй. (М.Ю.Лермонтов,"Шүлэгчийн үхэл")

(Утга зохиолын бичиг, хоёрдугаар дэвтэр 212 дугаар тал) гэсэнд "хар цус", "ариун үнэнч цус" гэсэн нь тэдний цусыг хар буюу улаан гэж ялгах гэсэн хэрэг биш, шүлэгч Лермонтов, Пушкинд дайсагнасан этгээдийг жигшиж, Пушкинийг хайрлан талархсан сэтгэлээ хамт илэрхийлсэн учир уянгын буюу зохиолчийн сэтгэлийг илтгэх чимэг гэж нэрлэж болох байна. Мөн дүрслэх, зохиолчийн сэтгэлийг илтгэх хоёр үүргийг нэг зэрэг гүйцэтгэсэн уянга туулсийн чимэг гэж бас байдаг. "Ачлалт элбэрэлт Хонгорзулын заяа маш өндөр. Алс бодлогот Алтаншагайн үгс үнэхээр нийцнэ. (Инжинаш, "Хөх судар " тэргүүн дэвтрийн 414 дүгээр талд) гэх зэргээр зохиолын хоёр баатрын тухай тэмдэглэжээ. Энд "ачлалт элбэрэлт", "алс бодлогот" гэх мэт чимэг үг бол зөвхөн тэр хоёр баатрын байдлыг гарган дүрслээд зогсоогүй, бас зохиолч Ванчинбал, Инжинаш нар тэр хоёр баатартаа ямар их сайн хандлагатай байгааг гаргасан болохоор уянга туульсийн чимэг шиг санагдана.

Нэг үзэгдэлд байдаг үндсэн онцлогийг нь товойлгох чанартай ямагт ярианд хэрэглэгддэг чимгийг тогтмол чимэг гэнэ. Жишээлбэл, Монголчууд "хөх тэнгэр, хөрст дэлхий", "гэгээн цагаан өдөр гэрэлт нарны доор" гэх мэтийн тогтмол чимгийг хэрэглэж ярилцдаг.

Чимэг үг гэдэг бол жирийн тодотголыг хэлдэг биш, харин хүний сэтгэлд юмын дүрийг тодорхой амьд юм шиг тодруулж чадах тодотголыг хэлнэ. Өөрөөр хэлбэл уран тодотголыг хэлнэ"¹¹ гэж тодорхойлжээ.

Эрдэмтэн Д.Отгонсүрэн: "Аливаа чимэг үг нь юм үзэгдлийн байнгын онцлог шинжийг товойлгон тодруулж, зохиолчийн хувийн үнэлэлт хандлагыг илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн өвөрмөц тодотгол мөн боловч чимэг үг бүрийн илэрхийлэх утгын цар хэмжээ, хүч чадал, уран сайхны нээлт харилцан адилгүйн дээр чимэг дотроо олон хэлбэртэй, тодорхой зааг ялгаатай байдаг нь тодорхой байна." гэжээ.¹² Эрдэмтэн Ц.Сүхбаатар: "Аливаа зүйлийн утга шинжийг маш тодорхой чихнээ чимэгтэй болгох зорилгоор хэрэглэдэг онцгой маягийн уран яруу тодотголыг чимэг үг гэдэг. Чимэг үгийг өгүүлбэрзүйн үүднээс авч үзэхэд тодотгол мөн боловч аливаа

¹¹ Гаадамба Ш., Утга зохиолын онолын товч, Уб.,1958.103 -р тал.

¹² Отгонсүрэн Д., Монгол хэлний найруулгазүй, Уб.,1975.16-р тал.

тодотгол бүхэн чимэг үг болдоггүй. Учир нь тодотгол бол үгсийн өгүүлбэрт гүйцэтгэх үүргээр тодорхойлогдох өгүүлбэрзүйн ухагдахуун, чимэг үг бол дүрслэх, үнэлэлт өгөх яруу хэрэглүүрийн үүргээр тодорхойлогдох найруулгазүйн ухагдахуун юм.

-хүрэн дээлтэй хүн (тодотгол)

-чийрэг хүрэн гартаа болд царил атгаад (чимэг үг)

“хүрэн дээлтэй хүн” гэдгийн “хүрэн” нь дээлийн өнгө заасан шууд утгаараа, “хүрэн гартаа” гэдгийн “хүрэн” нь чийрэгтэй адилтган зүйрлэж, утга шилжүүлсэн чимэг үг болно. Төстэй юм, үзэгдлийн илэрхийлэх үгийг уг зүйлийн шинж болгон утга шилжүүлэн хэрэглэснийг зүйрлэлт чимэг үг гэдэг. Тухайлбал, ган зориг, номин огторгуй, мөнгөн сар, алтан нар гэх мэт.

Мөн өөр юм үзэгдлийг нэрлэх биш, тухайн тэр юм үзэгдэлд үргэлж байх нь үгүй боловч гол шинжийг илэрхийлэх чимэг үг байж болно. Жишээлбэл, алд бие, эмээлт морь, тоонот гэр, ургах нар гэх мэт.

Чимэг үгийг уран зохиол, уран нийтлэл, сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэхэд элбэг хэрэглэнэ.

Гэсэр ламын дэргэд ламын биеийг шинжлэн үзээд, ламын ширээний гадуур гурван үе эргэж үзвэл, ламын үе гишүүн нь чичирч, үе яс нь ширвээтэн, бор зүрх нь булгилж, богино хавирга нь шархирч байна. “Гэсэр”

Өнгө зүс нь бадмаараг улаан

Үс ноос нь мяндас зөөлөн

Том биетэнд заяамааргүй номхон

Тормогор нүд нь зүйрлэшгүй амгалан

Бөх гэдэг нь хөлгийн дарвуул

Бяр гэдэг нь далайн онгоц

Мөрөөсөж буйлах нь морин хуур

Мөр нь хүртэл унасан навч (Б.Явуухулан, “Тэмээ”)¹³ гэжээ.

Эрдэмтэн Д.Галбаатар: “Чимэг үг бол юм үзэгдэл, үйл явдлын гол шинжийг нээн гаргахад тусалдаг уран сайхны тодорхойлол мөн. Жишээ нь:

Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө, би.

Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт

¹³Сүхбаатар Ц., Монгол хэлний найруулгазүй, Уб., 2007.319-р тал.

Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
Хоёр нүдний үзүүрт цэнхэртэх төдий тэртээд
Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө, би.

(Б.Явуухулан, “Би хаана төрөв”) гэсэн бадагт “хөх манхан” тэнгэр, “хөмсгөн” сар, “холын хоёр од”, “хоёр нүдний үзүүр” зэрэг уран тодотгол нь уг дүрслэгдэхүүнээ чимэглэх үүргээр оржээ.”¹⁴ гэж тэмдэглэсэн бол, эрдэмтэн Д.Бадамдорж: “Чимэг үг бол ямар нэг санааг тодотгон илэрхийлсэн утгатай байна. Тухайлбал, Монгол хэлний алтан хэмээх үг үнэ цэнэтэй гэх утгаараа чимэг үг болно. Жишээ нь. Алтан ураг, алтан үе, алтан намар, алтан нар, алтан гар, алтан шар зам, алтан дэлхий, алтан амь, алтан соёмбо гэх мэт”¹⁵ Эрдэмтэн Ш.Гаадамба: “Дүрсэлж байгаа зүйлийн чухал онцлогийг онцгой хурцаар сэтгэл хөдөлгөхүйц илтгэх уран тодотгол үгийг чимэг (эпитеть) гэнэ”.¹⁶

Эрдэмтэн Г.Галбаяр: “Аливаа чимэг үг нь юм үзэгдлийн байнгын онцлог шинжийг товойлгон тодруулж, зохиолчийн хувийн үнэлэлт хандлагыг илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн өвөрмөц тодотгол мөн боловч чимэг үг бүрийн илэрхийлэх утгын цар хэмжээ, хүч чадал, уран сайхны нээлт харилцан адилгүйн дээр чимэг дотроо олон хэлбэртэй, тодорхой зааг ялгаатай байдаг нь тодорхой байна.”¹⁷

Эрдэмтэн Д.Отгонсүрэн: “Чимэг үг нь уран зохиолын хэлний утга шилжүүлэх ёсны хамгийн түгээмэл хэсэг юм. Чимэг үг гэдэг ямар нэгэн юмс үзэгдлийн нэгэн онцгой шинж чанарыг уншигчдын таашаалд хүрэхээр дүрслэн тусгахыг хэлдэг байна. Түүнийг адилтгалт чимэг үг, төлөөлөлт чимэг үг гэж ялган үзэж байна.”¹⁸ хэмээн тус тус тодорхойлсон байна.

Эрдэмтэн О.С.Ахманова: “Энгийн тодорхойлолтоос өөрийн илтгэх хүч, шилжсэн (хоёрдогч) утгаараа ялгардаг үгийг чимэг үг гэнэ. Жишээ нь: серебряные седины (мөнгөн буурал), шелковые кудри (торгон үс), бродяго-

¹⁴Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь, Токио., 2002. 388-р тал.

¹⁵Бадамдорж Д., Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс, УБ., 1997. 208-р тал.

¹⁶Гаадамба Ш., Утга зохиолын онолын үндэс, УБ., 1989. 122-р тал.

¹⁷Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн үүд, УБ., 2003. 95-р тал.

¹⁸Отгонсүрэн Д., Монгол хэлний найруулгазүй, УБ., 1975. 16-р тал.

ветер (тэнүүлч салхи) гэх мэт.”¹⁹ хэмээн чимэг үг буюу чимэг тодотголыг “дүрсэлж байгаа зүйлийнхээ аль нэг шинжийг тодотгох, тодорхойлох үүрэгтэй дүрслэх ур маяг” гэдэг талаас авч үзэж, тайлбарлаж ирсэн уламжлал байна.

Уран зохиол шинжлэл ба найруулгазүйн судалгаанаас харахад яруу хэрэглүүр (тропа)-ийг тухайн зохиолчийн уран сайхны сэтгэлгээний илэрхийлэл, уран яруу дүрслэл зохиох найруулах ур маяг болох талаас ажиглан тодорхойлж, тайлбарлах төдийгөөр хязгаарлаж ирсэн гэж үзэж болохоор байна.

Саяхныг хүртэл манай хэлшинжлэлд зүйрлэл, адилтгал, хэтрүүлэл, төлөөлөл, тойруулал, егөөдөл зэргийг уран зохиолын асуудалд хамруулан уран найруулгын дүрслэх ур маяг гэж үзэх мөртлөө өвөрмөц хэллэг, хэлц, хэвшмэл хэллэг, зүйр цэцэн үг зэргийг хэлшинжлэлийн асуудалд хамруулан судалдаг байсан билээ. Шууд бус нэрлэлтийг танин мэдэхүйн хэлшинжлэлд “метафор” гэсэн нэртомъёо, ухагдахууны дор судалж байна.²⁰

Когнитив хэлшинжлэл манай оронд хөгжих болсноор дүрслэлт чимэг тодотгол буюу уран тодотголыг метафорын хүрээнд онцлон авч, судлах болсон байна.

“Орчин үеийн когнитив хэлшинжлэл метафорыг дүрийг тодотгогч, хэл яриаг чимэглэгч утга тонгоргосон хэллэг бус харин сэтгэхүйн хэлбэр гэж үздэг”.²¹ бөгөөд Ж.Лакоф, М.Жонсон нар метафорын тогтолцоо нь когнитив механизм мөн гээд “Хүний сэтгэхүйн явц нь олонх тохиолдолд метафорлаг”²² гэж үзсэн.

Н.Д.Арутюнова: “Метафор бидний өдөр тутмын амьдралд нэвтрэн орж зөвхөн хэлэнд бус бидний оюун санаа, үйл хөдлөлд биелэлээ олдог. Метафор хэрэглэх болсон нь хүний сэтгэхүйн гайхамшигт ялалт юм.”²³

А.Ричардс “Бодол санаа өөрөө метафорлаг ба хэлэн дэх метафорын эх үүсвэр болдог.”²⁴

¹⁹Ахманова О.С.,Словарь лингвистических терминов,М.,1966.с.32.

²⁰Тогтуун Э.,Метафор ба когнитив хэлшинжлэл,МУИС,МХСС,Монгол судлал,Уб.,2010.329-р тал.

²¹Төмөрхуяг Б., Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэлшинжлэлийн үүднээс судалсан нь, Уб.,2011.8-р тал..

²²Лакофф.Дж.,Джонсон.М., Метафоры, которыми мы живем, УРСС.,2004.с.24.

²³Арутюнова Н.Д., Метафора и дискурс,М.,1990.с.105.

²⁴Ричардс А., Философия риторики, Теория метафоры,Прогресс,М.,1990.с.47.

Э.Маккормак “Метофорын когнитив онол” бүтээлдээ метафорыг сэтгэхүйн арга хэмээн үзээд танин мэдэхүйн явц гэж тодорхойлсон. “...метафор өөр шинэ утгыг урин дууддаг”²⁵ гэж тайлбарласан байдаг.

Н.Караулов: “Метафор аяндаа үүсдэггүй харин тодорхой нийгмийн бүлэглэл, хамт олны сонирхлоор тухайн үйл явдлын концептуаль дүрээр үүсдэг. Сонгодог когнитив хэлшинжээчдийн тэмдэглэснээр “метафор бодит байдлыг хүлээн авах загвар үүсгэдэг, түүнд яг л толинд харж буй мэт субъектийн үйлдэл, байрлал, үүрэг, төсөөлөл тусгагддаг ажээ.”²⁶

Ийнхүү метафорын судалгаа өргөжин тэлж байгаа боловч дүрслэлт чимэг тодотгол буюу дүрслэх ур маягийг бүхэлд нь авч үзэж, хүний танин мэдэхүй, сэтгэлгээний онцлог, өгүүлэгчийн үнэлэмжийг илэрхийлсэн “хэлний нэгж” гэдэг талаас нь шинжилсэн дорвитой судалгаа ховор билээ.

Эрдэмтэн Ж. Баянсан: “Сэтгэлгээний тогтсон хэвшинж, тогтсон хэмжүүр нь тухайн соёл-хэлтэн юм үзэгдэл, үйл явдал, байдал нөхцөл, шинж чанарыг үнэлсэн үнэлэмж нь байдаг. Энэ үнэлэмж нь адилтгал, зүйрлэлээр илэрнэ.”²⁷ гэсэн бол эрдэмтэн Б.Чулуундорж: “Бодот байдлыг хэлээр илэрхийлэх, категорчлах бүх арга нь метафорын шинжтэй гэж тархийг судалсан эрдэмтэд үздэг. Бодит байдлыг дүрслэх (дескрипц хийх) арга нь субъектив шинжтэй болохын хирээр метафорчлах үйл явц хүчтэй болдог”²⁸ хэмээжээ.

Иймд, уран сайхны эхийн найруулгын хүрээнд тодотгогч ба тодотгуулагч, дүрслэлт чимэг тодотгол ба тодотгуулагч, дүрслэлт чимэг тодотгол ба өгүүлэгчийн үнэлэмж гэсэн уялдаа холбоонд авч үзэж, эх задлалын түвшинд “чимэг тодотгол-үг”, “чимэг тодотгол-нийлэмж үг”, “чимэг тодотгол-өгүүлбэр” “чимэг тодотгол-цогцолбор” гэсэн шаталсан тогтолцоонд тусгайлан судлах нь нэн сонирхолтой бас ач холбогдолтой юм.

Бид, энэ удаад дүрслэлт чимэг тодотголын хэвшинж, утга, найруулгын үүргийг, зөвхөн уран сайхны “эх” текстийн баримт жишээнд тулгуурлан тодотгогч-тодотгуулагчийн загвартай нийлэмжийн хүрээнд хэл соёл, үндэстний сэтгэлгээний онцлог, өгүүлэгчийн үнэлэмжтэй холбон сонирхон

²⁵Маккормак Э., Когнитивная теория метафоры, Теория метафоры, Прогресс, М., 1990. с. 78.

²⁶Баранов А.Н., Караулов Ю.Н., Русская политических метафора, М., 1991. с. 14.

²⁷Баянсан Ж., Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002. 31-р тал.

²⁸Чулуундорж Б., Когниц: сэтгэл судлал-хэлшинжлэл-мэдлэгийн онол, Уб., 2001. 7-р тал.

судалж, ажиглалт судалгаа хийхийг оролдлоо. Уран сайхны эхээс түүсэн уран тодотголоо дүрслэх ур маягт үндэслэн чимэг тодотгол, адилтгалт чимэг тодотгол, зүйрлэлт чимэг тодотгол, амьдчилалт чимэг тодотгол, хэтрүүлэлт чимэг тодотгол гэж утга үүрэг, хэрэглээний онцлогоор нь бүлэглэн хувааж, зарим ажиглалт, дүгнэлт хийхийг гол болгож байгаа билээ.

0.4. Судалгааны ажилд дэвшүүлсэн таамаглал:

Уран сайхны эхийн найруулгад дүрсэлж байгаа зүйлийн чухал онцлогийг илэрхийлэх гол хэлбэр нь дүрслэх чимэг үг (изобразительные эпитеты) болдог бөгөөд эхийн өгүүлбэрзүй талаас нь авч үзвэл уран сайхны дүрслэлт чимэг тодотголоор (образное определение) дамжин хэрэгждэг гэж үздэг.

Уран сайхны эхийн найруулгаас ажиглахад, уран тодотгол нь уг дүрслэгдэхүүнээ чимэглэх, дүрийг тодотгох үүргээр ордог төдийгүй

- Өгүүлэгчийн (рефенция) өөрөөр хэлбэл өгүүлэгчийн санаа зорилгоос үүдэлтэй бодит байдлын юмсад өгөх үнэлэмж утга²⁹ илтгэнэ.
- Ертөнцийг танин мэдэх, тайлбарлах үндэстний сэтгэлгээний онцлогийг тээж байдаг.
- Тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай дүрслэлт чимэг тодотголын илрэх хэмжээ урт нь янз бүр байна.
- Дүрслэх ур маягийн төрлүүдээс чимэг үг, адилтгал, зүйрлэл, амьдчилал, хэтрүүлэл зэрэг нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаанд суурилан илрэх боломжтой.

0.5. Судалгааны ажлын зорилго, зорилт:

Зорилго:

Судалгааны ажлаараа монгол уран сайхны эхийн найруулгад түшиглэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай уран найруулгын дүрслэх ур маяг бүхий чимэг тодотголоор дамжин илрэх соёл, үндэстний сэтгэлгээний онцлог, танин мэдэхүйн үр дүн, өгүүлэгчийн үнэлэмж зэргийг судлан тайлбарлахыг гол зорилго болгосон. Уран найруулгын дүрслэх ур маяг буюу дүрслэлт чимэг тодотголыг өгүүлбэр судлалын судлагдахуун болгон хэлбэр,

²⁹Зэгиймаа Ч., Прагматик хэлшинжлэл, Уб., 2010. 14-р тал.

бүтцийн талыг нь судлахаас гадна танин мэдэхүйн хэлшинжлэл, хэлэхийн хэлшинжлэл чиглэлийг баримтлан, өгүүлбэр-эх судлалын судлагдахуун болгон “хэлний утга-хэлний хэлбэр-хэлний хэрэглээ” гэсэн шүтэлцээнд, хэлний бодитой ба хийсвэр, зогсонги ба хөдлөнгө шинжид тулгуурлан судлахыг зорив.

Зорилт:

- Ертөнцийг танин мэдэх, ухаарах, тайлбарлах боломж, соёл, үндэстний сэтгэлгээний онцлог нь чимэг тодотголоор дамжин илэрдэг болохыг уран сайхны эхийн баримтад түшиглэн тайлбарлах
- Тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай дүрслэлт чимэг тодотголоор дамжин өгүүлэгчийн санаа зорилгоос үүдэлтэй, бодот байдлын юмсад өгөх үнэлэмж утга илэрдгийг уран сайхны эхийн баримтад түшиглэн тайлбарлах
- Тодотгогч-тодотгуулагчийн загвартай, дүрслэлт чимэг тодотголын хэвшинж, утга, найруулгын үүрэг, захирах холбоог эхийн түвшинд судлах
- Тодотгогчийн байранд тохиолдох дүрслэх ур маяг (тропа), тэдгээрийн хэвшинж, утга, үүрэг, хэрэглээг мэдэгдэхүүн-хэл-хэлэхүүн-мэдэхүүний талаас авч үзэх
- Уран сайхны дүрслэлт чимэг тодотголын илрэх хэмжээ, уртыг монгол хэлний өгүүлбэр ба эхийн шаталсан тогтолцоот нэгжийн түвшинд авч үзэж, хэлний утга-хэлний хэлбэр-хэлний хэрэглээ талаас судлан тайлбарлах

0.6. Судалгааны арга:

- Ажиглалтын арга (Хэлний нэгжийн хэрэглээг уран сайхны эхийн түвшинд ажиглаж, тэмдэглэх. Ажиглалтын үр дүнд бүрдүүлсэн хэрэглэгдэхүүнийг нэгтгэж, тэдгээрийн утга, хэрэглээний тухайд дүгнэлт гаргах)
- Индукци, дедукци (Ажиглалтын үр дүнд бий болсон судалгааны хэрэглэгдэхүүнийг нэгтгэх, ангилах, журамлах)
- Анализ, синтез (Хэлний баримтад задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх)
- Загварчлах арга (Судлахууны чухал шинжүүдийг тусган харуулах)

- Хам бичвэрийн арга (Эхийн түвшний шаталсан тогтолцоот нэгжийн утгыг хам бичвэрт түшиглэн тайлбарлах)
- Утгын туршилтын үр дүнг танихуйн үүднээс тайлбарлах арга (Хэлний баримтыг танихуйн баримт болгон хөрвүүлж, хэлний нэгжийн утгын тайлбарыг танин мэдэхүйн онцлогтой холбон авч үзэх)

0.7. Судалгааны ажлын ач холбогдол:

Орчин үеийн хэлшинжлэлийн судалгааны чиг хандлага хэлний хэрэглээний тал, эхийн судалгаанд анхаарлаа хандуулж байна.

Бид, монгол уран сайхны эхийн баримтад түшиглэн, янз бүрийн утга, үүрэг бүхий дүрслэлт чимэг тодотгол ба тодотгогч, тодотгуулагчийн харьцаа, дүрслэлт чимэг тодотгол ба өгүүлэгчийн үнэлэмж, дүрслэлт чимэг тодотгол ба сэтгэлгээний онцлог, дүрслэлт чимэг тодотгол ба хэлний нэгж гэсэн ойлголтуудыг цогц байдлаар авч үзэж, тодотголын үүрэг, утга, хэрэглээг тодруулан, дүрслэлт чимэг тодотгол нь уран зохиол шинжлэлийн төдийгүй хэл, хэлэх, танихуйн хэлшинжлэлийн хүрээнд судлах нийлмэл судлагдахуун болохыг тодорхойлсонд онолын ач холбогдол оршино.

Дүрслэлт чимэг тодотгол нь танихуйн хэлшинжлэлийн багц мэдлэг сэтгэлгээний цогц болохын хувьд утга агуулгаас гадна үнэлэмж, хүний ямар нэг юманд хандаж буй харьцааг багтаадаг тул үнэлэмжийг багц мэдлэг буюу концептийн хүрээнд авч судлах нь цаашлаад монгол хэл соёлын багц мэдлэгийн хүрээг тодруулан тогтооход ч чухал хувь нэмэр болно.

0.8. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн:

Дүрслэлт чимэг тодотгол болон өгүүлэгчийн үнэлэмжийн талаар уламжлалт хэлшинжлэл ба орчин үеийн хэлшинжлэлийн чиглэлээр эрдэмтэд судлаачдын туурвисан бүтээл, судалгааны материал, 200 гаруй зохиолчийн яруу найраг, хүүрнэл зохиолын 580 орчим бүтээлээс судалгааны сан бүрдүүлж хэрэглэгдэхүүн болголоо.

0.9. Судалгааны ажлын бүтэц:

Уг диссертаци нь 0. Удиртгал, 1. Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь гэсэн нэгдүгээр бүлэг, 2. Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь гэсэн хоёрдугаар бүлэг, 3. Дүгнэлт, 4. Хураангуй (орос хэлээр), 5. Номзүйгээс бүрдэнэ. Хэмжээ 125 хуудас.

Нэгдүгээр бүлэг: Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн зэрэг үнэлэмж илэрсэн нь (Монгол уран сайхны эхийн жишээн дээр)

1.1.1. Үнэлэмж, өгүүлэгчийн зэрэг үнэлэмж

Үнэлэмж гэдэг үг нь эртний грекийн “axia” (үнэт зүйл) гэсэн үгнээс үүдэлтэй бөгөөд орос хэлний “ценность”, англи хэлний “value” гэсэн үгтэй утга дүйдэг ажээ. Хүмүүнлэгийн ухааны судалгаа нь үнэлэмж ойлгохуйг чухалчлан үзэх болсон, үнэлэмж эрмэлзэл нь уламжлалт мэдлэгийн хүрээнээс илүү анхааралд өртөх болсон зэрэг нь үнэлэмжийн хамрах хүрээ хэр хэмжээнд өргөн байгааг харуулж байна.

Үнэлэмжийн тухай онол нь орчин үеийн философийн салбарууд дотор үүссэн хугацаагаараа харьцангуй залууд нь ордог боловч байр суурь нөлөөгөөрөө тэргүүн эгнээнд байдаг салбаруудын нэг ажээ. Германы философич Рудольф Херман Лотце үнэлэмжийн тухай онолыг философийн бие даасан салбар болгох эхлэлийг тавигч юм. Тэрээр 60-аад оны гол бүтээл болох “Практик философийн үндэслэгээнүүд” зохиолдоо “Бодот байдлыг зөвхөн онтологи утгаар ойлговол өрөөсгөл бөгөөд учир нь ахуйд (буянтай, сайхан, шударга гэх мэт) үнэлэмжийн илэрлүүд байдаг. Үнэлэмжүүд бол бидний хүсэл эрмэлзлэлээс огт хамааралгүй байдаг боловч бидний мэдрэмж рүү хандаж, тухайн тодорхой мэдрэмж нь янз бүрийн үнэлэмжийн зохих хязгаарыг тогтоож байдаг” гээд “Бичил орчлон” хэмээх бүтээлдээ оюуны амьдралын “дотоод үнэлэмж”, “мэдрэгдэгч сэтгэгдлийн үнэлэмж”, “хүний хөгжлийн үнэлэмж”, “түүхийн үнэлэмж” зэргийн тухай өгүүлсэн байдаг.³⁰ Философич В.А.Канке “Үнэлэмжийг тойрсон асуудлыг судалж үзэх нь хүсэл зориг, сэтгэл хөдлөл, сүсэг бишрэл, зорилго, чин эрмэлзэл гэж юу болохыг ойлгох боломж олгодог... Үнэлэмжийн үзэгдэл болох сүсэг итгэл нь өөрийн зэрэглэлтэй ба түүний хамгийн дээд илрэл нь чин эрхэмнэл (идеал) юм. Чин эрхэмнэлийн өнгө төрх бидний бүх амьдралд шингэмэл байдаг. Чин эрхэмнэл (идеал) бол хүсэн хүлээж буй ирээдүйг дээд зэргээр, бүхэл бүтэн байдлаар мэдэрсэн дүр (эйдос) юм.”³¹ гэж үзсэн бол, Б.С.Ерасов³² үнэлэмжийг аж

³⁰Гомбосүрэн Ц., Философи, Уб., 2008. 357-358-р тал.

³¹Канке В.А., Философи, Уб., 2001.с.226.

байдлын, нийгмийн, улс төрийн, ёс суртахууны, шашны, гоо сайхны гэж ангилсан байдаг.

Манайд үнэлэмжийн тухай асуудлыг харьцангуй хожуу авч үзсэн байдаг хэдий ч үндэстний эрдэмтэд шаргуу судлан, цөөнгүй судлаачид түүгээр эрдмийн зэрэг хамгаалсан байна. Зарим нэг тодорхойлолтыг авч үзье.

Судлаач Ц.Цэцэнбилэг: “Үнэлэмж бол хувь хүн өөртэйгөө адилтгадаг (харьцуулдаг) нийгэмлэгт болон өөрт нь ач холбогдол (утга) бүхий зан үйлийн эрхэмлэх зорилго хийгээд аргын тухай түүний төсөөллүүд юм.

Судлаач Ц.Гомбосүрэн: “Үнэлэмж бол тухайн субъектээс байгалийн юм уу, нийгмийн тодорхой үзэгдэлд бурхан тэнгэрлэгээр юм уу, бурхан тэнгэрлэг бишээр төсөөлөгддөг, ямар нэг далдлаг хүчинд өгч буй үнэлгээ мөн.

Судлаач Г.Чулуунбаатар: “Байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно.”³³ гэх мэтээр тодорхойлжээ.

Эрдэмтэн Т.Дорждагва: “Хүмүүн хүссэн хүсээгүй үнэлэмжийн ертөнцөд оршин байх болно. Өдөр тутмын ердийн амьдарлаас авхуулаад төрийн болон олон улсын аливаа үйл ажиллагаанд хүртэл, ер нь алхам бүртээ хүмүүс сонголт хийж, аливаад үнэлгээ өгч, хүссэн рүү гээ тэмүүлж, түүнийгээ хэрэгжүүлж, үл хүссэнээсээ дөлж, хагацаж байдаг. Тийм учраас үнэлэмжийг эерэг, сөрөг үнэлэмж гэж ялган хувааж үзэх боломжтой юм. Сайн, сайхан, үнэн, тааламжтай, хэрэгтэй, ашигтай, дэвшилттэй гэх үнэлэмжүүд нь эерэг, муу муухай, худлаа, тааламжгүй, хэрэггүй, ашиггүй, харгис гэх үнэлэмжүүд нь сөрөг үнэлэмжийн жишээ болно.”³⁴ гэж үзсэн байна. Судлаач Д.Мандах: “Үнэлэмж бол субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн.”³⁵, судлаач Л. Одонтуяа: “Үнэлэмж нь субъектийн оюуны үйл ажиллагаа мөн бөгөөд түүний хүсэл хийгээд үл хүсэхийн утгыг илэрхийлэх

³²Ерасов Б.С., Социальная культурология, М., 1998.с., 115-116.

³³Дорждагва Т., Соёл судлал, УБ., 2010.86-87-р тал.

³⁴Дорждагва Т., Соёл судлал, УБ., 2010.89-р тал.

³⁵Одонтуяа Л., Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог, Докторын(Ph,D) зэрэг горилсон бүтээл, УБ., 2004.16-р тал.

үнэлгээ мөн.”³⁶, судлаач Ц.Баатартогтох: “Англи хэлэнд “value” хэмээх үг нь үнэтэй, эрхэмлэдэг гэдгээс гадна “хямд төсөр” гэсэн утгыг давхар илэрхийлдэг учир “үнэт зүйлс” гэхээсээ илүү “үнэлэмж” гэж үзэх нь үгийн үндсэн болон шилжсэн утга талаасаа зохимжтой”³⁷ хэмээн “оюуны үйлдэл, үгийн үндсэн ба шилжсэн утгатай холбон тус тус тайлбарлажээ.

Үнэлэмжийг уран зохиол шинжээч, хэл шинжээч эрдэмтэд дараах байдлаар тодорхойлон тайлбарлаж байна.

Эрдэмтэн С.Энхбаяр: Үнэлэмж бол логик бүтцээрээ 3 чухал элементтэй.

Үүнд:

1. Үнэлэгч субъект. Энэ бол тухайн бодгаль буюу бүлэг хүн, байгууллага, эсвэл улс орон бүр цаашилбал хэд хэдэн улс, ард түмэн, нийт хүн төрөлхтөн гэх мэт мөн.
2. Үнэлэгдэгч объект. Энэ бол материаллаг ба санаалаг, бодитой ба уран сэтгэмжийн, ерийн ба ер бусын гэх мэт зүйл мөн.
3. Үнэлгээ. Энэ бол холбогдох тодорхой объектийн талаар тухайн субъектэд төрж буй сэтгэгдэл, бишрэл юм уу жигшил, дүгнэлт, цэгнэлт зэрэг мөн.

Үнэлэмжийн үр дүнд бий болдог онолын гол категорууд нь сайн ба муухай, буян ба нүгэл, ашигтай ба ашиггүй, ёстой ба ёстой биш, шударга ба шударга бус, үнэн ба худлаа гэх мэт ойлголт мөн”³⁸ хэмээн тайлбарласан бол,

Эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан: “Үнэлэмж нь ихэвчлэн хувь хүний үзэл баримтлалтай холбоотой боловч тухайн ард түмний аж төрөл, сэтгэлзүй, сэтгэхүйн онцлог, гоозүйн үнэлгээний хэвшин тогтсон хэм хэмжээгээр зохицуулагдан норматив үнэлэмжийн зохих түвшинд заавал байх учиртай юм. Нэмэлт баймж чанарт холбогдох хамгийн гол харьцаа бол өгүүлэгчийн үнэлэмж заасан утга болно. Өгүүлэгчийн сэтгэлийн байдал илэрхийлэх үнэлэх баймж чанарыг эерэг буюу нааштай сайн талын, сөрөг буюу

³⁶Одонтуяа Л., Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог, Докторын(Ph,D) зэрэг горилсон бүтээл, Уб.,2004.96-р тал.

³⁷Баатартогтох Ц.,Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал, Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл,Уб.,2000.11-р тал.

³⁸Энхбаяр С.,Утга зохиолын онол,Уб.,2011.312-р тал.

тааламжгүй муу талын шинжээр нь хоёрчлон хувааж болно. Тэрчлэн нэмэлт баймж чанар, нэн ялангуяа өгүүлэгчийн сэтгэлийн байдал илэрхийлэх баймж утгатай холбогдох нэгэн зүйл өгүүлэгчийн хувийн санал илэрхийлэх харьцаа юм.”³⁹ гэж үнэлэмжийг нэмэлт баймж чанарт багтаан авч үзжээ.

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир: ”Монгол хэлний аялга үг өгүүлбэр нь холбосон орчны дотор өгүүлэгчээс тухайн юм үзэгдэл, орон цагт хандах хандлага, өгүүлэгчийн мэдрэхүйн олон янз шинж түүний илрэл, сэтгэлийн хөдөлгөөний өнгө, уриалах хөг аялга, баймж үнэлгээ зэргийг илэрхийлж харилцах түвшинд чухал үүрэг гүйцэтгэдэг.”⁴⁰

Эрдэмтэн Ц.Өнөрбаян: “Монгол хэлний –хан (хэн,хон,хөн) бүтээвэр тэмдэг нэрийн утгыг бууруулах үүрэггүй бөгөөд харин өгүүлэгч этгээд тухайн шинж чанарыг хэрхэн үнэлж байгаа сэтгэлийн өнгө аяс илтгэдэг байна. Жишээ нь: хархан нүд, цагаахан сэтгэл, борхон ботго, аятайхан санаа гэх мэт эдгээр жишээнээс үзвэл хар, бор, цагаан, аятай гэсэн тэмдэг нэрээр илэрч байгаа шинж чанар өгүүлэгчид таатай санагдсан сэтгэлийн аяс илэрч байна.”⁴¹

Эрдэмтэн П.Бямбасан: “-дуу(-дүү), -втор (-втэр,-втор) нь үгсийн хоорондын харьцаа, орон цагийн харьцаа заахгүй, тухайн тэмдэг нэрээр илэрч байгаа шинж тэмдгийг өгүүлэгч этгээд тийм ч хангалттай бус гэж үзэж байгааг илэрхийлсэн утгын нэмэлт өнгийг оруулдаг байна. –дуу (-дүү), -втор (-втэр, -втор) морфемоор илэрч байгаа утгын өнгө нь өгүүлэгч этгээдийн хэлний хэрэгцээнд өртөж байгаа тухайн шинж чанарыг агуулсан юмын шинж тэмдгийн хэр хэмжээг өгүүлэгч этгээд хэрхэн үзэж байгааг харуулж байна. Энэ нь өгүүлэгч этгээд бодот байдалд хандаж байгаа хандлага харьцаа юм.”⁴²

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир: ”Монгол хэлний энэхүү -хан, -хэн, -хон, -хөн бүтээврийн байр, утга, үүрэг, хэрэглээг ажиглахад, тэмдэг нэр+хан⁴, дүрслэх ба дуурайх үг+хан⁴, жинхэнэ нэр+хан⁴, хам нөхцөл үйл+хан⁴, тооны нэр+хан⁴, орон цагийн нэр+хан⁴,... гэсэн байрлалтай, гол төлөв хэлэх өгүүлэхүйн

³⁹ Мөнх–Амгалан Ю., Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб., 1998. 224-317-р тал.

⁴⁰ Пүрэв-Очир Б., Гулираанз.З., Монгол хэлний өгүүлбэрзүйн онол – практикийн зарим асуудал, Уб., 1993.7-р тал.

⁴¹ Өнөрбаян Ц., Орчин цагийн монгол хэлний үгзүй, Уб., 2004.236-р тал.

⁴² Бямбасан П., Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг, Уб., 1975.69 -р тал.

түвшинд үг ба өгүүлбэрийн утгыг эрчимжүүлсэн, утгыг багасгасан, өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөний эерэг үнэлэмжийг илтгэн хайрлаж өхөөрдсөн, бахархсан, дотночилсон, сөрөг үнэлэмжийг илтгэн чамласан, хязгаарласан зэрэг өнгө аясыг илтгэдэг зүй тогтолтой нь ажиглагдав.”⁴³ хэмээн үнэлэмжийг бүтээвэртэй холбон авч үзэж тайлбарласан байна.

Эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан: “Үнэлэмжийн ай нь хэлний янз бүрийн түвшний олон хэрэглүүрээр илэрдэг утгазүйн нэлээд сонирхолтой ай бөгөөд үнэлэмжийн чанар агуулга нь эерэг ба сөрөг үнэлэмж, сайшаасан ба эс сайшаасан, зөвшөөрсөн ба эс зөвшөөрсөн, зэмлэсэн, гайхсан, эргэлзсэн, өгөөдсөн зэрэг баймж утга байх бөгөөд эдгээр нь өгүүлэгчийн сэтгэлийн байдал, сэтгэлийн хөдөлгөөн, яруу илтгэх өнгө аясыг давхар илэрхийлсэн байж болно”⁴⁴ гэж тэмдэглэсэн бол, эрдэмтэн Ж.Баянсан: “Бидний бодоход юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарын мөн чанарыг бүрэн дүүрэн таньж мэдэхийн хамт түүнийг хүн өөрийнхөө хэрэгцээ хүслийн үүднээс сайн-муу, сайхан-муухай, хэрэгтэй-хэрэггүй, таатай-таагүй, чухал-чухал биш гэх зэрэг эсрэгцсэн харьцаанд тунгаан бодож үнэлэмж өгдөг байна. Аливаа хүн ертөнцийн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг таньж мэдэх болгондоо түүнд ямар нэг үнэлэмж өгдөг нь зайлшгүй юм. Энэ үнэлэмж нь эерэг сөрөг гэсэн ерөнхий хоёр талтай байх боловч эерэг сөрөг тал бүр нь дотроо ашигтай-ашиггүй, зохистой-зохисгүй, таатай-таагүй гэх зэрэг дэд эсрэгцэлтэй байх болно.”⁴⁵

Эрдэмтэн Н.Нансалмаа: “Хүн ертөнцийн бодот юм үзэгдэл, үйлийг хүлээж авахдаа <<сайн, муу>>, <<сайхан, муухай>> ухагдахуунаар дамжуулан үнэлгээгээ илэрхийлдэг. Үнэлгээ бол хүн, хүндээ хийгээд юм үзэгдэл, үйлд хандах хандлага тул тэрээр хэлний хэрэглүүрээр дамжиж, хэлний нэгжүүдийн үнэлэх чанар буюу үнэлэмж болж хувирна. Үнэлэмж нь сэтгэл хөдлөлийн утгаас үүдсэн яруу үгийн утгын бүрдүүлбэр мөн бөгөөд сэтгэл хөдлөл үнэлгээний чанаргүй байж болно, харин үнэлэмж нь сэтгэл хөдлөлийн

⁴³Пүрэв-Очир Б.,Үг, өгүүлбэрийн амь амьдрал,эрчим долгион,соёл хэрэглээ, УБ., 2011. 63-р тал.

⁴⁴Мөнх-Амгалан Ю., Орчин цагийн монгол хэлний баймжийн ай,УБ., 1998.222-р тал.

⁴⁵Баянсан Ж.,Соёл, хэл,үндэстний сэтгэлгээ,УБ., 2002.45 -100-р тал.

хавсаргагүй байж болно.”⁴⁶ хэмээн үнэлэмжийн тухай асуудлыг өгүүлэгчийн сэтгэл хөдлөлтэй холбон тайлбарласан байна.

Судалгааны ном зохиолоос үзвэл, монгол хэлний зарим тэмдэг нэр өгүүлэгчийн сэтгэл хөдлөл, хувийн хандлага, үнэлэмжийг илэрхийлдэг тухай дурдсан байдаг. Тухайлбал, эрдэмтэн Б.Чулуундорж: “Орос, монгол хэлэнд хүн, юмс үзэгдлийн талаарх өгүүлэгч хүний үнэлэлт дүгнэлтийг дайвар үг, тэмдэг нэрээр ... илэрхийлэх явдал бий.”⁴⁷

Эрдэмтэн Э.Равдан: “Хөөрхий, муу, муухай, жаахан гэх мэтийн хэв маяг бүхий тэмдэг нэр нь монгол хэлэнд баймж утга илэрхийлдэг.”⁴⁸

Эрдэмтэн Д. Бадамдорж: “Сайн муу, муу сайн, сайхан муухай, муухай сайхан, хол ойр, ойр хол, жаргал зовлон, зовлон жаргал, буян нүгэл, нүгэл буян, авах өгөх, наана цаана, зөв буруу, үнэн худал, худал үнэн гэх мэтээр монгол хүнээс аливаа зүйлийг үнэлэх үнэлэмжийг илэрхийлдэг. Монголчууд эрхэм дээд, сайн сайхан, бишрэл хүндэтгэлийн зүйлээ эн тэргүүнээ айлдаж тахидаг учраас таашаасан үнэлэмж бүхий утга чанартай хоршоо үгийн эхний үг эерэг сайн утга өнгөтэй байх учир холбогдол бий. Жишээ нь: сайн муу, сайхан муухай, зөв буруу, үнэн зөв гэх мэт. Монгол хүн муу муухай, ёс бус юмыг эрхэмлэхгүй учраас эс таашаасан хоршоо үгийн эхний үг сөрөг муу утгатай байх учир холбогдол бий. Жишээ нь: муу сайн, муухай сайхан, нүгэл буян.”⁴⁹

Эрдэмтэн Ж.Төмөрцэрэн: “Хэлцийн олонхи нь шилжмэл утгатай бөгөөд хүний санал сэтгэлийн хөдөлгөөн, найруулгын өнгө аясыг илтгэсэн байдгийг тэмдэглэх нь зүйтэй.”⁵⁰

Эрдэмтэн Ц.Сүхбаатар: “Хэлц үгийн ихэнх нь шилжсэн утгатай бөгөөд хүний санаа сэтгэлийн байдлыг тусган илтгэдэг. Жишээ нь: “далайд дусал нэмэр” гэхэд далайн усанд ус нэмэх гэсэн утгатай бус хүнд ямар нэг тус дэм болсныг хэлж утга нь шилжсэн байна. Хэлц үгийн зүйл баярлан бахдах, инээн

⁴⁶Нансалмаа Н., Үгийн сан судлал, Уб., 2005.37-р тал.

⁴⁷Чулуундорж Б., Орос хэлний утгазүйн тайлбар бичиг, Уб.,1985.51-р тал.

⁴⁸Равдан Э., Сопоставительная стилистика русской и монгольской художественной речи, часть1. Уб.,1994.с.,88-89.

⁴⁹Бадамдорж Д.,Монгол хэлний утга судлалын үндэс,Уб.,1997.239-р тал.

⁵⁰Төмөрцэрэн Ж., Монгол хэлний үгийн сангийн судлал,Уб.,2001.137-р тал.

хөгжих, муушаан жигших.. зэрэг хүний сэтгэлийн мянга түмэн өнгө аясыг тусгадгийн хувьд уран зохиолын найруулгад үлэмж хэрэгцээтэй.”⁵¹

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир: “...нэг сартай, нэг нартай, нэг тэнгэртэй, нэг агаар салхитай, даяаршиж буй энэ дэлхий ертөнцийн хүмүүс, онд ондоо хэл, өөр өөр соёл заншил, шашин шүтлэг, утга соёлтой байдаг ч сайн/муу, сайхан/муухай, хэрэгтэй/хэрэггүй, үнэтэй/үнэгүй, эерэг/сөрөг-ийн тухай ойлголт, үнэлэмж нь өөр өөр байдаг нь жам ёсны зүйл бөгөөд олон соёлын харилцааны онцлог юм.”⁵² хэмээн үгийн утга, хэл соёлын онцлогтой холбон тодорхойлон тайлбарлажээ.

Эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан: “Тэмдэг нэрийн утгазүйг ерөнхийд нь ажиглахад, өгүүлэгчийн үнэлэмжийг ямар нэг байдлаар илэрхийлсэн нийтлэг талтай юм. Жишээлбэл,

А) Юм үзэгдлийн шинж чанар, үйл хөдлөл, гүйцэтгэх байдал төлөвийг үнэлсэн. Жишээлбэл, амар, хялбар, хөнгөн, хүнд, хэцүү, төвөгтэй

Б) Таатай, таагүй үнэлгээний үүднээс юм үзэгдлийн шинж чанарыг илэрхийлсэн. Жишээлбэл, сайхан, үзэсгэлэнтэй, аятайхан, аймшигтай, аймаар

В) Бололцоот байдлын үүднээс юм, үзэгдэл, үйл хөдлөлийн болц явц, байдлыг үнэлсэн. Жишээлбэл, боломжийн, аюулын, гайгүй гэх мэт.”⁵³ гэжээ.

Эрдэмтэн Ш.Гаадамба: “Өгүүлэгчийн өгүүлэмжээр зохиолын дотор гарах байгалийн байдал, эд юмс, хүний нүүр царай зэрэг зүйлийг тоочин бичих, баатруудын байдал, санаа сэтгэлийг үнэлэх зэргээр зохиогчийн буюу өгүүлэгчийн зүгээс уншигчдад тайлбарлан заах бүх зүйлийг өгүүлдэг.”⁵⁴ гэсэн бол, эрдэмтэн М.Базаррагчаа: Үнэлэмжийг өгүүлбэрийн утгын бүтэцтэй холбон авч үзээд, “Үнэлэмж нь бодит агуулгыг ялгаруулан онцлох, хийсвэр агуулга (бодит зайлшгүй, бололцоот, үүрэгт баймж) нэмэх”⁵⁵ гэж тайлбарласан байна. Судлаач Л.Цэрэнчимэд: “Үнэлэмж гэдэг бол байгаль ертөнцийн болоод хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанар,

⁵¹Сүхбаатар Ц., Монгол хэлний найруулгазүй, Уб., 2007. 293-р тал.

⁵²Пүрэв-Очир Б.,Үг,өгүүлбэрийн амь амьдрал,эрчим долгион, соёл хэрэглээ,Уб., 2011. 102-р тал.

⁵³Мөнх-Амгалан Ю.,Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб.,1998. 223-р тал.

⁵⁴Гаадамба Ш.,Утга зохиолын онолын үндэс, Уб.,1989.108-р тал.

⁵⁵Базаррагчаа М.,Монгол хэлний өгүүлбэр судлал,Уб.,2005. 94-р тал.

тэдгээрийн цаг хугацаа-орон зайн дотор орших хувьсал өөрчлөлт зэрэгт өгүүлэгч этгээдээс өгч байгаа үнэлэлт дүгнэлт, хандлагыг адилтгал зүйрлэлийн дүнд илрүүлэх явдал юм.” хэмээн тодорхойлжээ.⁵⁶

Эрдэмтэн О.С.Ахманова: “Үнэлэмж (оценка-evaluation) нь өгүүлэгчийн бодол эрэгцүүлэл, түүнийг сайшаан зөвших ба үл сайшаан, үл ойшоосон үзэл, хандлага. Мөн энэ нь найруулгазүйн үндсэн хэсгийн нэг юм. Үнэлэмж нь: чанарын үнэлэмж (оценка качественная), найруулгазүйн үнэлэмж (оценка стилистическая), хувь хүний үнэлэмж (оценка субъективная), гоо зүйн үнэлэмж (оценка экспрессивно-модальная), сэтгэл хөдлөлийн үнэлэмж (оценка экспрессивно-эмоциональная) гэж ангилжээ.⁵⁷

Эрдэмтэн Шарль Балли: “Объектив болон субъектив үнэлэмж байна” гэж тодорхойлсон бол эрдэмтэн Н.Д.Арутюнова, Е.М Вольф нар “Ерөнхий ба тусгай үнэлэмжийн хэлбэрүүд байна.” гээд тусгай үнэлэмжийг (частооценочные) сэтгэл хөдлөл, гоозүй, ёсзүй, тоо хэмжээ, өнгөний⁵⁸ гэх зэргээр ангилан үзжээ.

Эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан: “Тухайн өгүүлэмжийн агуулга нь уг өгүүлэгч этгээдэд тааламжтай зохистой байгаа шинжийг энэхүү баймж утгаар илэрхийлнэ. Өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утгыг үүрэг-утгазүй, хэрэглээний талаас нь дараах маягаар тодруулан ангилж болно.” гээд өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утгыг баярлах утга, зөвшөөрөх утга, бахархах утга, магтан сайшаах утга, ерөөх утга, хайрлан өрөвдөх утга...”⁵⁹ гэж ангилсан байдаг.

Ийнхүү үнэлэмжийн тухай асуудлыг объект, субъект, оюуны үйлдэл, сэтгэл хөдлөл, аялга, баймж болон үг, бүтээврийн утга зэрэгтэй холбон тайлбарлаж ирсэн байна.

Үнэлэмж гэдэг бол байгаль ертөнцийн болоод хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанар тэдгээрийн хувьсал өөрчлөлт зэрэгт өгүүлэгчийн зүгээс өгч байгаа үнэлэлт дүгнэлтийг дүрслэлт чимэг тодотголын үр дүнд илрүүлж буй хэрэг юм.

⁵⁶Цэрэнчимэд Л,Уран сайхны эхийн найруулгад илэрсэн онцлог хэрэглээ,УБ.,2010.138-р тал.

⁵⁷Ахманова О.С,Словарь лингвистических терминов,М.,1966.с.30.

⁵⁸Папина А.Ф,Текст его единицы и глобальные категории,М., 2004.с.269.

⁵⁹Мөнх-Амгалан Ю, Орчин цагийн монгол хэлний баймжийн ай,УБ.,1998. 228-238-р тал.

Ерөөс, уран сайхны эхийн найруулгад зохиогч буюу өгүүлэгчийн тухайн агшин дахь торгон мэдрэмж, сэтгэл хөдлөл, бодот байдалд харьцах харьцаа нь найруулгазүйн өнгө ялгарааг илэрхийлэх ур чадвартай салшгүй холбоотой бөгөөд тухайн өгүүлэмжийн агуулгад өгүүлэгчийн зүгээс зориуд оруулсан хувийн хандлага, үнэлэмж, санал дүгнэлтийн янз бүрийн утга өнгө аясаар арвин байдаг. Хэлний баримтад туссан эдгээр онцлогууд өгүүлэгчийн зүгээс өгч буй үнэлэмж (оценка-value)-ээр илэрч байдгийг дүрслэлт чимэг тодотгол бүхий “хэлний нэгж” буюу тодотгогч-тодотгуулагчийн харьцаа талаас харвал сонирхолтой мэт санагдана.

1.1.2. Дүрслэх ур маяг (тропа), түүний ангилал

Эрдэмтэн В.Н.Ярцева: “Дүрслэх ур маяг гэдэг нь дүрсэлж байгаа зүйлийнхээ хэл найруулгыг утга төгөлдөр, санааг нь улам тод болгох зорилгоор үгийг шилжсэн утгаар хэрэглэхэд суурилсан хэллэгүүдийг тэмдэглэдэг найруулгазүйн ойлголт юм. Дүрслэх ур маягт эхлээд зүйрлэл, төлөөлөл, адилтгал орж байснаа хожим нь чимэг үг, хэтрүүлэл зэрэг цөм орох болсон.”⁶⁰ хэмээн тайлбарласан бол эрдэмтэн Д.Э.Розенталь: “Хэлний янз бүрийн найруулгад, ялангуяа уран сайхны зохиол, нийтлэл, ярианы хэл зэргийн найруулгад өгүүлж буй зүйлийн чухал онцлогийг тодруулах хэлний дүрслэх ур маяг (тропа) өргөн хэрэглэгддэг ба тэдгээр нь өгүүлж буй зүйлийн агуулга дээр уран яруу, сэтгэл хөдлөлийн өнгө аяс нэмж өгдөг.” гээд дүрслэх ур маяг (тропа) –ийн төрлүүдийг чимэг үг (эпитет), зүйрлэл (сравнение), адилтгал (метафора), төлөөлөл (метонимия), тооны төлөөлөл (синокдоха), тойруулал (перифраза), егөөдөл (ирония), хэтрүүлэл (гипербола и литота)⁶¹ гэж ангилжээ. Эрдэмтэн Ш.Гаадамба: “Үгийг шууд утгаар нь хослон хэрэглэх, утгыг шилжүүлэн хэрэглэх хоёр ялгаа байдаг. Үгийг шууд утгаар нь хэрэглэн дүрийг бүтээх тусгай арга гэвэл чимэг, адилтгал зэрэг болно. Нөгөө утга шилжүүлэн хэрэглэсэн тусгай аргууд гэвэл зүйрлэл, егөөдөл, ихэсгэл, багасгал, төлөөлөл, тайлбарлал, амьдчилал гэх мэт олон зүйл бий.”⁶² гэж

⁶⁰Ярцева В.А., Большой энциклопедический словарь языкознание, М., 1998.с.520.

⁶¹Розенталь Д.Э., Практическая стилистика русского языка, М., 1968.с.399.

⁶²Гаадамба Ш., Утга зохиолын онолын товч, Уб., 1958.101-р тал.

үзсэн бол, эрдэмтэн С.Дулам, Ц.Хасбаатар: "Зохиолын хэлний уран яруу хэрэглүүрийн нэг гол зүйл нь үгийн утга шилжүүлэх ёс юм. Үгийн утга шилжүүлэх ёс бол уран сайхнаар танин мэдүүлэх учир холбогдолтой зүйл юм."⁶³ гээд, уран яруу хэрэглүүр буюу утга шилжүүлэх ёсыг зүйрлэл, адилтгал, төлөөлөл, хэтрүүлэл, чимэг үг, бэлгэдэл, егөөдөл гэж ангилжээ. Эрдэмтэн Г.Галбаяр: "Хэлний уран яруу хэрэглүүрийг бүтээх нэгэн гол зүйл болох утга шилжүүлэх ёс гэдэг нь грек хэлний "tropos" (утга тонгоруулах) гэсэн үгнээс үүсэлтэй. Уран сайхны дүр бүтээхэд үг, өгүүлбэр, хэллэгийг шууд биш шилжсэн утгаар нь ашигласныг үгийн утга шилжүүлэх ёс гэдэг. Утга шилжүүлэх ёс нь дотроо шинж чанарын хувьд олон ангилагддаг".⁶⁴ гэж тодорхойлоод, адилтгал, зүйрлэл, төлөөлөл, ихэсгэл, багасгал, чимэг үг, бэлгэдэл гэж зүйлчилсэн бол, эрдэмтэн Ц.Сүхбаатар: "Орчин цагийн утга шилжүүлэн дүрсэлж байгаа байдлыг ерөнхий шинжээр нь авч үзвэл, зүйрлэсэн болон төлөөлсөн байх бөгөөд дотроо тус тус онцлог бүхий олон ур маяг болдог"⁶⁵ гээд дараах байдлаар ангилжээ.

- Зүйрлэсэн ур маягууд: адилтгал, зүйрлэл, чимэг үг, хүншүүлэл, ёгтлол, хэтрүүлэл
- Төлөөлсөн ур маягууд: төлөөлөл, тойруулал, зөөлрүүлэл, егөөдөл гэжээ.

Дүрслэх ур маягийн эдгээр төрлүүдээс чимэг үг, адилтгал, зүйрлэл, хэтрүүлэл, амьдчилал зэрэг нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаанд суурилсан чимэг тодотголын үүрэгтэй байдаг тул монгол уран сайхны эхийн найруулга дахь дүрслэх ур маяг (тропа) бүхий чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн байдлыг дараах байдлаар ангилан авч үзэж байна.

- Чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь
- Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь
- Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

⁶³ Дулам С, Хасбаатар Ц, Уран зохиолын онолын үүд, Уб., 1980. 149-р тал.

⁶⁴ Галбаяр Г, Уран зохиол шинжлэлийн лекц, Уб., 2002. 91-р тал.

⁶⁵ Сүхбаатар Ц, Монгол хэлний найруулгазүй, Уб., 2007. 305-р тал.

- Амьдчилалт (хүншүүлэл) чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь
- Хэтрүүлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

1.2. Чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

Чимэг үг (эпитет- epithet)-ийг найруулгазүйн онолын бүтээлүүдэд, байнгын чимэг үг (постоянные эпитеты), дүрслэх чимэг үг (изобразительные эпитеты), сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн чимэг үг (эмоциональные эпитеты) гэж ангилдаг ажээ.

Дээрх ангиллаас уран сайхны эхийн найруулгад өгүүлэгчийн үнэлэмжийг илрүүлэх гол хэлбэр нь сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн чимэг үг, дүрслэх чимэг үг болдог бөгөөд эхийн өгүүлбэрзүй талаас нь авч үзвэл, уран сайхны дүрслэлт чимэг тодотголоор (образное определение) дамжин хэрэгждэг байна.

Уран зохиолын онолын бүтээлүүдээс үзэхэд, чимэг тодотголыг жирийн тодотголоос ялган “чимэг үг гэдэг нь онцгой тодотгол”, “чимэг үг гэдэг бол уран тодотгол”, “чимэг үг бол уран сайхны тодорхойлол”, “чимэг үг бол тодотгон илэрхийлсэн утга”, “чимэг үг уран яруу тодотгол” гэх мэтээр томъёолон тодорхойлжээ.

Чимэг үг (эпитет) нь уг дүрслэгдэхүүнээ чимэглэх үүрэгтэй уран тодотгол бөгөөд уран тодотголоор дамжин өгүүлэгчийн эерэг үнэлэмж, үндэстний ахуй, соёл сэтгэлгээний өвөрмөц онцлог илэрдэг байна.

Уран сайхны эхийн баримтат түшиглэн, дүрслэлт чимэг тодотголоор илрэх үнэлэмжийг:

- Байгаль ертөнц
- Хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд
- Аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэл, тэдгээрт өгсөн үнэлэмж гэсэн ерөнхий зүйлээр бүлэглэн авч үзэв.

1.2.1. Нүүдлийн соёл иргэншилд байгалийг дээдэлж, анхдагчийн хэмжээнд өргөмжилж, шүтэн биширч, сүслэн залбирах сэтгэлгээ, зан заншил уламжилж ирсэн. Энэхүү чин эрхэмнэл, дээд хүслэн нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай чимэг тодотголоор илэрдэг зүй тогтолтой байна.

Монгол ардын үлгэрт “хурмаст тэнгэр, дээд тэнгэр, хан тэнгэр” хэмээх ойлголт нэртомъёо олонтоо дүрслэгддэг. Энэ дүрслэл нь хүн байгаль хоёрын зохицол, байгаль дэлхий, газар нутаг, уул усаа хайрлан хамгаалах үзэл болон өргөжиж, байгаль дэлхий, эх нутаг, уул усандаа залбиран шүтэж, түүнд хувь заяагаа даатган залбирах зан үйл болон өргөжсөн байдаг. Иймд “өлгий нутаг”, “эх орон”, “уул ус” гэсэн тодотгуулагч нь эерэг үнэлэмж бүхий чимэг тодотголыг захирах нь харьцангуй түгээмэл байна. Үүнд:

... Намайг элээгээд үлдэх *тэнгэрийн заяат* **нутаг**

Насны хайраа дээжилсэн Монголын сайхан өргөө

(Ш.Сүрэнжав, “Сонет цэцгэн эрих”)

(*тэнгэрийн заяат*^{тодотгогч} ← **нутаг**^{тодотгуулагч})

...Ивээл хайрын тэнгэр, энэ насны *шүтээн-эх орон* **минь**

Эгчийн илгээсэн эзгийтэй уутан дотроос

Идээний тавганд инээд алдах шиг торр-хийн унасан

Эрхний шүр шиг бяцхан шар чулууг

Эрхэм нандины дээд мэт сүсэглэн авч үзлээ, би

(Д.Бямбаа, “Намайг эргэж ирсэн нутгийн бяцхан чулуу”)

(*ивээл хайрын тэнгэр*^{тодотгогч})

(**эх орон минь**^{тодотгуулагч})

(энэ насны *шүтээн*^{тодотгогч})

гэсэн тодотгогч-

тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор дамжин өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн шүтэн бишрэх, бахархан дээдлэх өнгө аяс, байгаль ертөнц, нутаг орноо тэнгэрчлэн шүтэх, өргөмжлөн дээдлэх монгол зан заншил, соёл сэтгэлгээний өвөрмөц онцлог илэрсэн байна.

Монголчууд байгаль ертөнц, нутаг орноо “ариун, арилсан орон” буюу “бурхны дээд орон” хэмээн эрхэмлэн шүтдэг ард түмэн. Энэ сүсэг бишрэл, эерэг үнэлэмж нь уран сайхны эхийн найруулга дахь чимэг тодотголд тусгалаа олсон байдаг. Тухайлбал,

Умар зүг дэх газрын *их буянт*^{тодотгогч} **монгол орон**^{тодотгуулагч}

Олон түмнээ өлзий бэлгэс бүхэн бүрдсэн^{тодотгогч} **бүх хүслийн газар**^{тодотгуулагч}

Ой шугуй их орон, тэнд мэргэн хүн, ажнай морины сүрэг

Олон түмний манлай дүүрэн **орон**

(Г.Ролбидорж, “Монгол орон”)

...Сам шимийн ертөнцөд ийм *ариун дагшин, гэгээн эрхэмсэг*^{тодотгогч} ←
газар^{тодотгуулагч} аль орон дэлхийд байдгийг би мэдэхгүй.

(С.Пүрэв, "Ихсийн газар")

Тэгвэл, дараах эхэд:

Дээдсийн заяатай **нутаг**

Дэлхийд ганцхан эх орон ...

(Ч.Содномдорж, "Дэлхийд ганцхан эх орон")

(дээдсийн заяатай^{тодотгогч} ← **нутаг**^{тодотгуулагч})

...Цэнхэр тэнгэрийн **эх орон**

Цэцэн мэргэдийн **өлгий минь**

Таныгаа хайрлахгүй юм бол

Өөр юугаа хайрлах билээ дээ, эх орон минь

(Д.Цэнджав, "Таныгаа шүтэхгүй бол юугаа шүтэх вэ")

(цэцэн мэргэдийн^{тодотгогч} ← **өлгий минь**^{тодотгуулагч})

...Өр зүрхэнд уянга хайрлах

Өвгөдийн заяатай амгалан **хөдөө нутаг**

(И. Алтантүлхүүр, "Сэтгэл даллах нутаг")

(өвгөдийн заяатай^{тодотгогч} ← **хөдөө нутаг**^{тодотгуулагч}) **гэх мэт**

"чимэг тодотгол-нийлэмж"-ээс манай ард түмний эх нутаг, газар шороогоо хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээж ирсэн уламжлал, ёс жаяг, соёл сэтгэлгээ, сайхан монгол нутгийнхаа эзэн нь болно гэдэг "зол баяр" юм хэмээн бэлгэшээн бахархсан иргэн хүний бардамналыг харж болно.

...Алтай, Хянганы завсарт атар баялаг **орон**

Аав ээжийн минь оршсон ашдын заяасан **нутаг**

(Д.Нацагдорж, "Миний нутаг")

(Аав ээжийн минь оршсон ашдын заяасан^{тодотгогч} ← **нутаг**^{тодотгуулагч})

...Аав, ээжийн ерөөл *шингэсэн*

Ашид оршихын хүчин бүрдсэн...

Эх орон минь залуужиж байна. (Ч.Лхамсүрэн, "Эх орон")

(Аав, ээжийн ерөөл шингэсэн^{тодотгогч} ← **эх орон минь**^{тодотгуулагч})

хэмээн "чимэг тодотгол-өгүүлбэр" -ээр байгаль ертөнц, унасан газар, угаасан ус нь өвөг дээдэс, аав ээжийн ачлал буян, хайр энэрлийг үзүүлдэг, юугаар

ч сольшгүй “үнэт зүйл” хэмээн үеэс үед дээдэлдэг соёл сэтгэлгээ, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлжээ.

Дараах уран сайхны эхийн чимэг тодотголын хэвшинж, утга, хэрэглээг ажиглавал:

...Ертөнцийн үзэсгэлэн гоо

Ерөөлөөр учирсан нутаг (Л.Хуушаан, “Нарлаг монгол орон”)

... Аяа, Алтай минь Алтай минь

Азаар заяасан нутаг аа

Тэвэрч таныгаа даахгүй ч гэлээ

Тээж явдаг шүү, сэтгэлдээ. (З.Гүнсэн, “Зулай цагаан Алтай”)

(ерөөлөөр учирсан^{тодотгогч} ← нутаг^{тодотгуулагч}),

(азаар заяасан^{тодотгогч} ← нутаг аа^{тодотгуулагч}) гэж ийм сайхан “хөдөө газар”, “эх нутаг”-ийнхаа эзэн нь болж төрсөн нь “учрал тохиол” хэмээн бахархсан сэтгэлийн омогшил, бардамналаа өгүүлэгч чимэг тодотгол-өгүүлбэрээр дүрслэн гаргажээ.

Нөгөө талаар эх орон, газар нутгийг шүтээн, тэнгэр, хайр, ерөөл аз, заяа буян, өлзий бэлгэс, ариун дагшин, гэгээн эрхэмсэг гэсэн шашин шүтлэг, оюун сэтгэхүй санааны агуулгатай чимэг тодотголоор тодотгож байгаа нь газар шороог сүнсжүүлэн тэнгэржүүлэх эртний тэнгэр шүтлэг бөөгийн ёсны ухагдахуун ойлголт, үнэлэмж, хэлээр илэрч байгаагийн жишээ болохоос гадна төр улсыг санаалаг ариун (сакр) гэж үздэг эртний буюу уламжлалт ойлголт монгол сэтгэлгээ одоо ч хүчтэй хадгалагддагийг харуулах хэл соёлын баримт мөн билээ.

Бас зарим эх бичвэрт хүн байгалийн хүйн холбоо, монгол хүн, монгол хүлэг морь хоёр “нутаг амьтай” –н учир эх нутагтайгаа ямар нэг сэжмээр холбоотой байдаг олон зүйл утгыг илтгэсэн дүрслэлт чимэг тодотголууд шууд ба дам харьцаагаар илэрч, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэж байдаг. Үүнд:

Хангал сайхан хүлэг шөнөдөөн гүйдэг нутаг минь

Ханагар дэлхийн уудмаас энэхэн биенд заяасан

Хаа ч явсан зүүдлэгдээд байдаг

Хайрыг булаасан нутаг минь ээ.

(Б.Цэдэндамба, “Хайрыг булаасан нутаг”)

(хангал сайхан хүлэг шөнөдөөн гүйдэг^{тодотгогч} ← **нутаг минь**^{тодотгуулагч})

(хаа ч явсан зүүдлэгдээд байдаг^{тодотгогч}

↗ **нутаг минь**^{тодотгуулагч})

(хайрыг булаасан^{тодотгогч}

...Унтах нойронд үзэгдээд байдаг

Усыг нь уусан **нутаг минь** ээ хө.

(Б.Түвшинжаргал, "Цэнхэр хангай нутаг")

(унтах нойронд үзэгдээд байдаг^{тодотгогч} ← **нутаг минь**^{тодотгуулагч}) хэмээн цаг ямагт эх орноо санагалзан, төрж өссөн нутаг усандаа сэтгэл тэмүүлэх торгон агшныг, чимэг–тодотгол өгүүлбэрээр товч тодорхой дүрсэлсэн байдаг бол,

...Амин халуун хайраар холбоотой төрж өссөн **нутаг уснаасаа** харь хол яваа эр хүн хүлэг морь хоёрын сэтгэлийн үзүүрийг сэрвэлзүүлсэн хөх ногооны униар ид татаж байсан цаг. (Б.Догмид, "Нутаг")

(амин халуун хайраар холбоотой төрж өссөн^{тодотгогч} ← **нутаг ус**^{тодотгуулагч})

...Гол ус нь хүйгээрээ хүн бүхэнтэй холбоотой

Гоо сайхан **нутаг минь** бидний сэтгэл дээр тогтдог.

(О.Дашбалбар, "Зүүдний мөнгөн шувуу")

(гол ус нь хүйгээрээ хүн бүхэнтэй холбоотой^{тодотгогч} ← **нутаг минь**^{тодотгуулагч}) гэсэн чимэг тодотгол өгүүлбэрээр бид эх орон, байгаль ертөнцтэйгээ амь амьсгал нэгтэй хэмээн эрхэмлэн дээдлэх монгол соёл сэтгэлгээ, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан дээдлэх өнгө аясыг илтгэжээ.

Халуун зүрхний уяа **эх орон та минь**

(Д.Цоодол, "Жаргалтай дэлгэр орон")

(халуун зүрхний уяа^{тодотгогч} ← **эх орон**^{тодотгуулагч})

...Элэг зүрхнээс уяатай

Энхрий **монгол нутаг**

(Ж.Бадраа, "Элгэн халуун нутаг")

(элэг зүрхнээс уяатай^{тодотгогч} ← **монгол нутаг**^{тодотгуулагч})

...Өр зүрхэнд уянга хайрлах

Өвгөдийн заяатай амгалан **хөдөө нутаг**

(И. Алтантүлхүүр, "Сэтгэл даллах нутаг")

(өр зүрхэнд уянга хайрлах^{тодотгогч} ← **хөдөө нутаг**^{тодотгуулагч})

Дээрх уран сайхны эхийн найруулга дахь тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан дээдлэх өнгө аясыг илэрхийлсэн бол,

...Гүү үүрээр унагалж, гөрөөс үдшээр цавь суганыхаа цагаан таныг гэрэлтүүлэн бүрхрэн дуугарах дорнын аглагхан хээр талд хавар яагаа ч үгүй эрт хөх цөцгий хэмээх хөөрхөн шувуухай ирж үүрээ засдаг *санаж сарвайх ус нутаг минь*. (Б.Догмид, "Санаж сарвайх ус нутаг мину")

(*санаж сарвайх*^{тодотгогч} ← *ус нутаг минь*^{тодотгуулагч})

...Сундлаа цагаан үүлсээ сугсарч сэгсэрч дүнхийсэн Дарвийн цэнхэр нуруу минь даанч сайхан диваажин. Бууж мордох хорвоод *буцаж холдомгүй нутаг*.

(С.Пүрэв, "Сундлаа цагаан үүл")

(*буцаж холдомгүй*^{тодотгогч} ← *нутаг*^{тодотгуулагч}) гэсэн дүрслэлүүд нь "эх орон - иргэн", "хүн-байгаль" -ийн хүйн холбоо, эх орноо хайрлах, эх орноо магтан дуулах сэтгэлийн дуулал болж чадсан бөгөөд дүрслэлт чимэг тодотголууд нь хэвшинж бүтцийн хувьд хураангуй ба дэлгэрэнгүй хэлбэрээр "чимэг үг-тодотгогч" жишээ нь: энхрий-**нутаг**, "чимэг тодотгол-нийлэмж" жишээ нь: элэг зүрхнээс уяатай-**нутаг**, "чимэг тодотгол өгүүлбэр-тодотгогч" жишээ нь: ...*Амин халуун хайраар* өссөн **нутаг**гэсэн хэлбэр бүтэцтэйгээр илэрчээ.

"Байгалийн сайхан буюу байгалийн үзэгдлүүдийг үнэлэх гол сайхны үнэлгээ нь хүнээс байгальтай харьцах харилцааны явцад үүсч бүрэлддэг. Байгалийн олон янзын үзэгдэл, үйл явцад сайхны агуулгыг бүрдүүлдэг чанарууд объектив ёсоор агуулагдаж байдаг учраас байгаль нь бидэнд гоо сайхны мэдрэмж таашаалыг төрүүлдэг байна."⁶⁶ Үүний зэрэгцээ мэдэхүүний талаасаа болон танин мэдэхүйн талаасаа нутаг орон, байгалийн баян тансаг хийгээд үзэсгэлэн төгс, хийморь жавхаа, хөгжил цэцэглэлтийг илтгэсэн харьцангуй бодот утгатай учирзүйн дүрслэлт чимэг тодотголуудад өгүүлэгчийн эерэг үнэлэмж шингэсэн байдгийг дараах уран сайхны эхийн жишээнээс харъя.

...*Буурал эртний домог мөнхөд оршсон хаяа захгүй говьдоо ширээ хүрэн тэмээд тэнгэрээ өргөн тэшилдэж, цагаан зээрийн сүрэг цахилж нэг байж дэгдэх нь Дулаан Богд уул өөрөө хол замын биднийг дагаад ачаалах нь уу*

⁶⁶ Төмөрбаатар Ж., Гоозүйн үндсэн категорууд, Уб., 1998. 14-р тал.

гэлтэй их говийнхоо энгэрээр өндөлзөнө.^{тодотгогч} Ийм л^{тодосгогч} сайхан өгөөмөр амгалан^{тодотгогч} нутаг^{тодотгуулагч} даа. (С.Пүрэв, “Дулаан Богд Дулаан”) хэмээсэн хураангуй ба дэлгэрэнгүй олон янз дүрслэлт чимэг тодотголоор дөрвөн цагийн эргэлтэнд дураар нүүх нутагтай, хөрсөн доор нь эрдэнээр баян монгол орныхоо эзэн болсондоо хязгааргүй их омогшин бахархсан өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг тодотгожээ.

Уран сайхны эхийн баримтаас үзэхэд байгалийн өвөрмөц онцлог, түүнд хандах өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэсэн чимэг тодот голууд нь “тал”, “хангай”, “говь”, “хээр” тодотгуулагчтай байх нь олонтоо тохиолдож байна. Уудам дэлгэр нутаг оронтой монголчуудын хувьд амьдралын тэнүүн чөлөөт хэвшил, санаа сэтгэлийн уужим амгалан байдал зэрэгт онцгой ач холбогдол өгдөг. Жишээлбэл,

...Хөх туурь бол тэнгэрийн солир харван унаж байдаг, сар шөнөжингөө туулахдаа ч цуцдаг^{тодотгогч} агуу уужим тал нутаг^{тодотгуулагч} юм аа.

(П.Баярсайхан, “Хөх туурийн тал”)

...Алсын хөх зэрэглээнд адуу мал торолзож, хуурын аялгуу эгшиглэсэн^{тодотгогч} ийм л^{тодосгогч} саруулхан тал^{тодотгуулагч} нутагт би тогорууны дэгдээхэйтэй тоглож өссөн. (Б.Догмид, “Санаж сарвайх нутаг ус мину”)

..Гүйгүүл морин

Зургаан сардаа тууламгүй^{тодотгогч}

Нүүгүүл үүлс

Зуны сардаа барамгүй^{тодотгогч}

Тал минь,^{тодотгуулагч} тавиухан цэнхэр тал минь. (Дан. Нямаа, “Тал”)

хэмээн чимэглэн тодотгож, тал нутгийнхаа онцлог шинж байдлыг бахархан магтсан бол,

...Дулаахан бор сүүдэр хүүшилсэн^{тодотгогч} их талын^{тодотгуулагч} дунд сондгойдуухан ургасан хэдэн сөөг цагаан дэрс өвгөний үймж гашуудсан сэтгэлийн хар салхинд гэнэт алгадуулсан мэт толгой гудайлган гунигтайхан бөхөлзөнө. (Б.Догмид, “Нутаг”)

... Санаа алдахад

Эхийн сүү тагнайд амтагдаж

Салхины нь үзүүрийг залгихад

Агт хоолойд аргасан^{тодотгогч}

Боржгины бор тал минь^{тодотгуулагч} ... (Б.Лхагвасүрэн, “Боржгины бор тал”)
хэмээн тал нутгийнхаа сэтгэл татам өвөрмөц шинж байдлыг онцлон,
чимэглэн тодотгожээ.

Манай зохиолч, найрагчид маань нүнжиг буяны дээд цогцолсон “говь”
нутгийнхаа дагшин, шаргал, хонгор элсэн манхан, хуурын эгшигтэй зэрэглээ,
хосгүй сайхан байгалийг,

... Би энэ дагшин шаргал говийн амь халуун үндэс бүхэнд өөрийнхөө
зоргоор эрхэмсэг сэтгэлийг асгаж орхино, уяж орхино.... Юутай ч, элгэн
шаргал говьд нүнжиг буяны дээд цогцолжээ.

(Б.Баттулга, “Толгодын энгэр дэх чулуун гэр”)

(дагшин шаргал^{тодотгогч} ← говь^{тодотгуулагч})

...Нар мандахдаа говиос, тэр тусмаа Дорнын цэнхэр говиос эхэлдэг гэдэгт
би дандаа итгэдэг. Манай говийн хүүхнүүд ихэвчлэн нар үнэртүүлсэн хонгор
шаргал даахитай, хонин бор нүдтэй байдгийм. Би ч бас тэдний л адил.

(Г.Мөнхцэцэг, “Миний хатан булаг эх орноо манадаг”)

(цэнхэр^{тодотгогч} ← говиос^{тодотгуулагч})

...Наран саран хоёрын хооронд зундаа улайсч, өвөлдөө царцдаг бидэрт
хонгор манхны элс, бодол адил аниргүйхэн нүүдэллэдэг^{тодотгогч} өмнийн
хөлгөн^{тодотгогч} их говь^{тодотгуулагч} ...Униар зэрэглээ нь хүртэл хуурын
эгшигтэй^{тодотгогч} энэ халиун хонгор^{тодотгогч} говь^{тодотгуулагч} ...
(Б.Догмид, “Говь”) гэж дүрслэн чимэглэсэн байдаг бол, “хангай” нутгийнхаа
сайхан байгалийг,

...Сэвшээ хонгор салхитай^{тодотгогч}

Сэрүүн сайхан хангай^{тодотгуулагч} ...

(Д.Даржаа, “Сэрүүн сайхан хангай”)

...Эргэх улиралд өвс ус тэгш

Энхжингийн орон-цэнхэр номин^{тодотгогч} хангай^{тодотгуулагч} ...

(А.Самбалхүндэв, “Номин хангай”)

...Зүүдэнд уяатай

Зүрхэнд туяатай^{тодотгогч}

Асарлан дүнхийн харагдах

Арын сайхан хангай минь^{тодотгуулагч}

(Д.Найманжин, “Арын сайхан Хангай минь”)

хэмээн дээдлэн магтаж, ийм сайхан ус нутгийнхаа эзэн болсондоо сэтгэл ханагар, баяр бахдалтай байдгийг илтгэжээ.

“Тал”, “хангай”, “говь” гэсэн тодотгуулагчийн чимэг тодотголууд нь их төлөв байгалийн өвөрмөц онцлогийг илтгэсэн дэлгэрэнгүй дүрслэлт чимэг тодотголууд эсвэл уудам дэлгэр, хязгааргүй орон зайн утга бүхий уран тодотгол байдаг нь монголчууд ашдын заяат энэ уудам дэлгэр газар нутагтаа дөрвөн цагийн эргэлтэнд дураар сэлгүүцэн нүүдэллэж ирсэн аж амьдрал, ахуй соёлтой холбоотой.

Эрдэмтэн С.Дулам: “Зарим бэлгэдлийн утгазүй нь тухайн улс үндэстний оршин аж төрдөг газар нутгийн өнгө зохистой (местный колорид) холбоотой байдаг”⁶⁷ гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд нүүдэлчин соёл иргэншилт монгол угсаатан “газар дэлхийн” -ийн чимэг тодотголыг **“бор-тал, элгэн шаргал-говь, халиун хонгор-говь, номин цэнхэр-хангай”** гэх мэт “тодотгогч-тодотгуулагчийн харьцаагаар илэрхийлж, дүрсэлж ирсэн уламжлал байна.

Уран сайхны эхийн найруулгад сав ертөнц, уул усаа сүслэн дээдэлж, хүсэл юугаан шивнэн даатгаж ирсэн өнө эртний өвөрмөц зан үйл, монгол соёл сэтгэлгээг илэрхийлсэн нэгэн зүйл тодотгол ажиглагдаж байна. “Уул”-ыг чимсэн дүрслэлт чимэг тодотголуудын бүтэц хэвшинж, утга үүрэг, хувиргал нь өөр өөр байна.

...Элгэн их хаданд нь

Бүргэд шувуу хальсан^{тодотгогч}

Эрэг жалга бүгдэд нь

Араатан гөрөөс шивээлсэн^{тодотгогч}

Элдэв жимсийн модоор

Эгэл бие нь хучигдсан^{тодотгогч}

Энгүй их бартаатай

Сүртэй сайхан уул^{тодотгуулагч} байна.

(Ц.Дамдинсүрэн, “Зугаацахаар мордсон нь”)

гэж дүрслэлт, зэрэгцсэн, бодот шинжийг тоочсон, магтсан утгатай, дэлгэрэнгүй тодотгол гишүүн өгүүлбэрээр чимсэн бол,

⁶⁷Дулам С, Монгол бэлгэдэл зүй, УБ., 2000.33-р тал.

...Нэрийг хэлдэггүй

Сүсэгт^{тодотгогч} **уул минь**^{тодотгуулагч} (Б.Лхагвасүрэн, “Монгол уул”)

...Олон түмэн нь хүслээ даатгасан

Орчлонд ганцхан **хайрхан минь**

...Мянган бурхны шившлэгтэй^{тодотгогч} **уул**^{тодотгуулагч}

(Д.Чулуун, “Шүтээн уул”)

(мянган бурхны шившлэгтэй^{тодотгогч} ← **уул**^{тодотгуулагч})

...Цагаан бүхний дээжийг цогцлоож, цацлын есөн нүдээр дөрвөн зүг, найман зовхис руу шиврэн дусалсан^{тодотгогч} монголын **Цагаан уулс, Алтай минь.**^{тодотгуулагч} (Ж.Баттулга, “Алтай”) гэж

хүн-байгалийн хүйн холбоо, монгол зан заншлын онцлогийг илэрхийлсэн утгатай, уран тодотгол болон дэлгэрэнгүй дүрслэлт чимэг тодотгол өгүүлбэрээр дүрсэлсэн байхад,

...Торгон салхины үзүүр зөөлөрч, их уулын хормой бэлийн нимгэн цас шимгэлтээд, хээнцэр горхины эрэг горхины эрэг ширгээр нялх ногоо цухуйн, шувуудын ганганааг амраг минь хүлээж байгаа.^{тодотгогч} **Ийм**^{тодосгогч} ижилгүй тансаг **уулсаас**^{тодотгуулагч} **тань** илүү дутуугаа олж ухаарнам.

(Х.Эрдэнэбаатар, “Намун Асханы тэнгэр доор”)


...Зунд нь цэцэгс анхилуулж, өвөлд нь цасаа шилгээж, хавар намартаа хамаа хүн зон, мал ахуйгаа нөмөртөө багтаана.^{тодотгогч} **Ийм**^{тодосгогч} **сайхан уул**^{тодотгуулагч} энэхэн орчлонд өөр хаа ч байхгүй санагдана. Тийм дээ, хаа ч байхгүй. (С.Пүрэв, “Хараатын их гашуун”)

хэмээн эх нутгийнх нь уулс агуу сүрдэм хийгээд нөмөр нөөлөгтэй, ач буянтай, үр өгөөжтэйг сэтгэл бахдам өгүүлэхдээ “цогцолбор” чимэг тодотголоор дүрсэлсэн ур маяг байна. Чимэг тодотгол цогцолборыг “ийм” гэсэн тодосгогчоор хувирган давтсан нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг улам тодотгожээ.

Дом шившлэг, ид шид, цээрлэх ёс (тотем, анимизм, фетишизм, табу) гэсэн домгийн ойлголт монгол ертөнцийн домог зүйн загварын хувьд уул гэдэг нь ид шидийн орон зайн (концепт багц мэдлэгийн) төв ойлголт болохыг харуулж байгаа бөгөөд энэхүү концептэд эерэг үнэлэмж илрэх нь тодорхой юм. Энэ нь монголчуудын өнө эртний уламжлалт соёл,

сэтгэлгээний онцлог урансайхны эхийн найруулгад дүрслэлт чимэг тодотголоор илэрч байгаагийн нотолгоо билээ.

Дээр дурдсан чимэг тодотголын утга, үүрэг, хэвшинжийг нэгтгэн харвал,



Чимэг тодотгол үг, чимэг тодотгол нийлэмж, тэрчлэн хэл болоод хэлэхүйн хамгийн том утга төгссөн нэгж болох чимэг тодотгол өгүүлбэр, чимэг тодотгол цогцолбороор тодотгуулагч нэр үгийг дүрслэн чимэглэснээр өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан сайшаасан, хүндэтгэн биширсэн, омогшиж бардамнасан зэрэг өнгө аясыг илтгэж байна.

Өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн хураангуй ба дэлгэрэнгүй олон янз чимэг тодотголыг захирч чаддаг тодотгуулагч нэр үгэнд “нутаг, газар, эх орон, тал, хангай, говь, уул, хайрхан” гэсэн үгүүд багтаж байгаа нь нүүдэлчин монголчууд өнө эртнээс байгаль дэлхий, нутаг орон, уул усандаа сүслэн залбирч, байгаль дэлхийнхээ хишиг буяныг хүртэж амьдарч ирсэн ахуй, соёлтой холбоотой юм.

1.2.2. Хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд, тэдгээрт хандах өгүүлэгчийн эерэг үнэлэмж нь уран сайхны чимэг тодотголоор дамжин илэрч байна. Хүн тодорхой орон зай, цаг хугацааны дотор хорвоо ертөнцөд амьдрахдаа сайн муу, жаргал зовлон, учрал хагацал, баяр гуниг зэрэг олон үйл явдалтай учирч, танин мэдсэний үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч байдгийг чимэг тодотголоор яруу сайхан гаргасан жишээ олон.

Тухайлбал,

... *Өнгөт* энэ **орчлон**гоос

Өгснөөсөө авсан минь их... (Б.Лхагвасүрэн, “Ижийтэйгээ байхад...”)

...Ганган улаан тэмээг төрүүлж, миний хонгорыг заяасан *өгөөмөр* энэ

ертөнц.... (Д.Маам, “Хоёр хар буурын туурь”)

...Навч ногооны шим шүүс гүйцэж, хурын хурган цагаан манан талд буусан
намрын тоос тортоггүй торгон тэнгэрт уяхан **замбативийн** наран мөхөшгүй
өндөрт алтран мандана. (Б.Догмид, “Хулангийн шанд”)

... *Цэлгэр* энэ **орчлонгоо** хайрлах хайр

Цээжинд багтахгүй оргилж ирэх өдөр байхад...

(Ш.Сүрэнжав, “Наймт шүлгүүд”) гэж

хүний аж амьдрал, ажил үйлс дэгжин дээшилж, өөдрөг сайхан байхад бодол
санаа, хүсэл эрмэлзэл нь ч бас гэгээлэг байдгийг өнгөт-орчлон, цэлгэр-
орчлон, уяхан-замбатив гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаагаар
илэрхийлсэн бөгөөд чимэг тодотголууд нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн
сайшаан бахархсан өнгө аястай байна. Ийнхүү тодотгогч нь хураангуй
хэлбэрээр илрэхээс гадна,

...*Бүүвэйн дуутай*^{тодотгогч} **орчлон**^{тодотгуулагч} дээр бүүвэйн дуугүй айл орон
байна гэдэг гэрлийг харанхуйгаар сольсонтой адил юм даа.

(С.Пүрэв, “Бүүвэйн дуутай хорвоо”)

...*Нар гийсэн*^{тодотгогч} **ертөнцөд**^{тодотгуулагч}

Найргийн гал тасрах учиргүйд баярладаг.

(Ц. Ичинхорлоо, “Найргийн увдис”)

хэмээн хүний амьдралын орчил түгээмэл үзэгдэл, түүний мөн чанар нь
өгүүлэгчийн санаа сэтгэлд бахдам сайхан мэдрэмж төрүүлж байдгийг “чимэг
тодотгогч, нийлэмж”, “чимэг тодотгол өгүүлбэр”-ээр дүрслэн илэрхийлжээ.

...*Сайхан сайхан гэвэл жаргал нь амттай*^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч} юм.

(Л.Түдэв, “Болор биш мөс”)

...*Ай хөөрхий, учрал учралаа тосох жамтай*^{тодотгогч} **хорвоод**^{тодотгуулагч} юу эс
тохиохыг хэн урдаас хэрхэн мэдэх билээ.

(Д.Норов, “Сэрвэгэр хадны зэрэглээ”)

....*Зүүд хүртэл жаргаад сэрдээ*^{тодотгогч}

Зөв явбал зөөлөн зөөлөн^{тодотгогч} **замбуулин**^{тодотгуулагч}

(Л.Мөнхтөр, “Зөөлөн зөөлөн замбуулин”)

гэх мэт “чимэг тодотгогч, өгүүлбэр” нь “эзэн хичээвэл заяа хичээнэ” гэсэн
сургаал үгийн утгатай дүйх санааг илэрхийлсэн бөгөөд хүний амьдралын
орчил дахь түгээмэл үзэгдэлд өгсөн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн
илэрхийлэл болжээ.

Уран сайхны эхийн баримтаас үзэхэд, “орчлон, хорвоо, замбуулин, ертөнц” гэсэн тодотгуулагч нэр үгүүд нь хүний амьдралын орчил дахь хэрэг явдлыг өгүүлсэн утгатай гол тодотгуулагч болж байдаг бөгөөд өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн утгатай олон янз дүрслэлт чимэг тодотголоор утга дэлгэрч байна.

“Цаг хугацаа” гэсэн ухагдахуун ойлголт бол байгалийн үзэгдэлтэй шууд хамааралтай төдийгүй, хүн төрөлхтний амьдралын хөгжлийн үе шатуудтай салшгүй холбоотой бөгөөд цаг хугацаанаас ангид юм гэж энэ ертөнцөд нэгээхэн ч үгүй. Хэл талаас авч үзвэл, цаг хугацаа бол эхийн нэг категори юм. Уран сайхны цаг бол эх бичвэрийн агуулгыг бүрдүүлэх онцгой үүрэгтэй бөгөөд цаг хугацааны дотор орших юм үзэгдэл, түүний шинж чанарын өөрчлөлтийг тодотгогч-тодотгуулагч харьцаан дахь дүрслэлт чимэг тодотголоор илэрхийлсэн байдаг. Хүмүүний сэтгэлийг сэргээн баясгасан торгон агшин буюу нэгэн “өглөө”, “өдөр”, “үдэш” (мөчлөг цаг) -ийн байдал шинжийг, их зохиолч Д.Нацагдорж “Үзэгдээгүй юм” өгүүллэгтээ:

...Өглөөний нар оргин гарч ирэхэд голын эхэн дэх саруул хөндий гэрэлтэж, ариун агаар татан, үнэхээр зуны амьсгал анхилах бөгөөд дэргэдэх цэцэг нимгэн цагаан хяруу мэт гялтганаад, тэртээ ойд ногооны униар залгалдах нь даруй нүүдэлчин хүний сэтгэлийг хөдөлгөнө.^{тодотгогч} *Ийм нэг сайхан*^{тодотгогч} **өглөө**^{тодотгуулагч} *Идэр голын өмнөд этгээдэд сэргэлэн дэнжийн дээр хэдэн цагаан гэр цэмцийн үзэгдэж, айл бүрийн тоононоос хөх утаа савсан манарна. хэмээн “цогцолбор” чимэг тодотголоор илэрхийлсэн бол, зохиолч Б.Догмид “Хулангийн шанд” эхийн найруулгад, ...Зүдэг хар санаа, өшөө хорсол, атаа жөтөө хүний цээжинд тогтохын аргагүй*^{тодотгогч} *нартай, жаргалтай*^{тодотгогч} *сайхан* **өглөө**^{тодотгуулагч} *болжээ.”* гэсэн чимэг тодотгол өгүүлбэрээр яруу сайхан дүрсэлсэн байдаг нь зөвхөн байгалийн үзэгдлийг төдийгүй хүний сэтгэл санааны төлөв байдлыг төрүүлж байгаа багц мэдлэг хүний цэцэглэж өөдлөн буй амьдралын талаар шинэчлэл, цэвэршин тунгалагших гэх мэт хуучнаас далд битүүгээс ангижрах гэсэн утгыг илэрхийлж болдог” гэсэн судлаачдын дүгнэлттэй таарч байгаа нь сонирхолтой юм.⁶⁸

⁶⁸ Маслова В.А., Введение в когнитивную лингвистику, М., 2008.с.131.

Иймэрхүү жишээ монгол эх бичвэрт олонтоо тохиолддог нь монгол соёлын цаг хугацааны чухал багц мэдлэгийн нэг үзэхэд буруудахгүй билээ. Өөрөөр хэлбэл энэ мэт чимэг тодотголтой зүйрлэл монголчуудын ертөнцийг үзэх үзэл, сэтгэлийн хөдөлгөөн үзэл бодол үнэлэмжийг заах бөгөөд хэл ухамсрыг илэрхийлж байгаа хэрэг юм.

Эгшиг хонгорхон аялгуу дуутай^{тодотгогч}

Эгэл **өдрүүдийг**^{тодотгуулагч} хамтдаа туулахдаа

Эргэх цагийг гэрэлтүүлсэн анд минь ээ (Д.Бадамханд, "Миний найз") хэмээн чимэглэн тодотгож, өгүүлэгчийн "дотоод ертөнц"-ийн гэгээлэг сайхан мэдрэмжийг илэрхийлжээ. "Өглөө, өдөр, үдэш" гэсэн тодотгуулагч нэр үгүүд нь хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлийн нэг бөгөөд өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн утгатай олон янз дүрслэлт чимэг тодотголоор утга дэлгэрч байдаг.

"Бага нас-идэр нас-өтөл нас" гэсэн "төрөх-үхэх"-ийн завсар дахь хүний насны мөн чанар нь амьдралын орчил дахь үзэгдэл бөгөөд уран сайхны найруулгад өгүүлэгчийн эерэг үнэлэмж бүхий чимэг тодотголоор идэр залуу насны цог жавхлан, ид хавыг бахархсан, баяр жаргалыг эргэн дурссан дүрслэл олон тохиолдоно. Жишээ нь,

...Ээжийнхээ энгэрт эрхэлсэн

Аавынхаа мөрөнд зүүгдсэн

Тоглоом наадамд дуртайхан

Тоодгор жаахан^{тодотгогч} **бага нас минь**^{тодотгуулагч}

(Г.Ганболд, "Дэлхий дүүрэн бага нас минь")

...*Хонгор*^{тодотгогч} **бага нас минь**^{тодотгуулагч} урдаас тосном.

Хонь холбох шиг он жилүүдийг холбоно, би.

(Дан.Нямаа, "Миний ертөнц") гэж

хүний амьдралын баяр хөөр, аз жаргалтай мөчүүдийг "бага нас", "хүүхэд ахуй үе"-ийн өхөөрдөм, хайр булаам шинж байдлыг тодотгон дүрсэлснээр өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн өхөөрдөн энхрийлсэн өнгө аясыг,

...Хурууныхаа өндгөөр тэнд зүрхний тэмдгээ тавьж

Хуучиршгүй^{тодотгогч} **залуу насныхаа**^{тодотгуулагч} тэмүүллийг мөнхлөхсөн

(Л.Өлзийтөгс, "Тэмүүлэл") гэж залуу насны жавхаалаг, өнгөлөг, гэгээлэг шинж

байдлыг тодотгон дүрсэлснээр, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан өнгө аясыг илтгэжээ.

Хөрстийн амьдралд хөл алдсан
Хөлчүүхэн зүрхний тольтон дээгүүр
Шувууны сүүдэр шиг дайраад өнгөрсөн
Шунхан улаан^{тодотгогч} **залуу нас мину!**^{тодотгуулагч}

(Р.Чойном, "Залуу нас")


Энэ эхийн хэсэгт буй бадрангуйн утгын бэлгэдэл болсон "шунхан улаан" гэсэн "чимэг тодотгол нийлэмж" нь "залуу нас"-ны цог жавхлант, хийморьлог шинж байдлын уран дүрслэл болж чадсан бол,

Догшрон тачигнах идэр есаварт
Энээр задгайлсан^{тодотгогч} **залуу нас минь**^{тодотгуулагч}
Жавар тогтомгүй армагийн нуруунд
Асаж дүрэлзсэн^{тодотгогч} **залуу нас минь**^{тодотгуулагч}

(Б.Баярсайхан, "Залуу нас хийгээд гэрэлт шувуу")

гэсэн "чимэг тодотгол-өгүүлбэр"-ээр "залуу нас"-ны ид хав, хүч чадал, хийморьлог шинж байдлыг тодотгон чимэглэж, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн омогшин бахархсан өнгө аясыг илтгэжээ. "Бага нас, идэр нас, залуу нас" гэсэн тодотгуулагч нэр үгүүд нь хүний амьдралын хэрэг явдал-хүний насны мөн чанар-цаг хугацааны тухай өгүүлсэн гол тодотгуулагч болж байдаг учир өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн утгатай олон янз дүрслэлт чимэг тодотголыг захирч байна.

Нэгтгэн загварчилж үзүүлбэл,



гэсэн "мэдэгдэхүүн-хэлэгдэхүүн-мэдэхүүн-хэлэхүүн"-ийг хамарсан бүтэц-утгын харьцаа харагдана.

1.2.3. Уран сайхны эхийн найруулгад дүрслэлт чимэг тодотголоор аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэл, тэдгээрт өгсөн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлж байна. Тодруулбал, уран сайхны дүрийн гадаад болон дотоод мөн чанар, байдал шинжийн уран тодотголд өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн өнгө аяс шингэсэн байдаг.

Жишээ нь:

...*Үлэмж найрт*^{тодотгогч} **Солонгоо**^{тодотгуулагч} *үлэмж сэтгэлт*^{тодотгогч}
Алтаншааг^{тодотгуулагч} мөрөөдөв.
...*Үнэн элбэрэлт*^{тодотгогч} **Хонгорзул**^{тодотгуулагч} *үнэн өршөөлт*^{тодотгогч}
Мохулиг^{тодотгуулагч} цочоов.
(В.Инжинаш, “Хөх судар”)

Дээрх эх бичвэрт буй “үлэмж найрт”, “үлэмж сэтгэлт”, “үнэн элбэрэлт”, үнэн өршөөлт” гэсэн чимэг тодотгол нийлэмжүүд нь дүрийн зан байдлын сайхан чанарыг гарган дүрслээд зогсоогүй, өгүүлэгч баатартаа эерэг сайн хандлагатай байгаагийн илэрхийлэл болсон бол,

...*Бурхан ухаант*^{тодотгогч}
Дархан урчууд^{тодотгуулагч}
Ургаа галбар цанданг
Угсраа угсраагаар нь ацраад
...Эрхэм Замба хааны гүнж...
Эрдэм ухаан тэгш^{тодотгогч}
Далай гэрэл дагина^{тодотгуулагч}

(Т.Галсан, “Монгол Жангар”)

Энэ эхийн “эрдэм ухаан тэгш”, “бурхан ухаант” гэх мэт “нийлэмж үг-чимэг тодотголууд” бол зохиогч дүрийнхээ оюун билиг, авьяас чадварыг бахархан магтсан эерэг үнэлэмж юм.

Монголчуудын ахуй соёлд гэр бүлсэг байдал, эцэг эхийн элбэрэл журмыг хамгаас нандигнан эрхэмлэдэг. Тиймээс хамгийн эрхэм сайхан тодотголтой дүрүүдэд “ээж, эх, ижий”, “өвгөд, аав, эцэг” хэмээх нэр үгүүд зүй ёсоор орж байна.

Монгол уран сайхны эхэд “аав-эцэг-өвгөд”, “эх-ээж-ижий” -ийн ачлахуйн олон зүйл үйл, хувиршгүй их элбэрэл хайрыг магтан дуулсан чимэг тодотгол их төлөв дэлгэрэнгүй хэлбэрээр тохиолдож байгаа нь эцэг,

эхийнхээ ач гавьяаг магтан дуулах гэсэн үр хүүхдийнх нь чин хүсэл, эерэг үнэлэмжийн илрэл юм. Жишээ баримтаас дурдвал,

<p>Монголын үзэсгэлэн саран гоо, намайг төрүүлсэн ижий Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ижий Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ижий Зүйтэй уран үгээрээ сурган хүмүүжүүлсэн ижий (Д.Нацагдорж, “Миний ээжий”)</p>	<p>Хаа холын газраас Хаврыг дагуулсаар ирдэг аав (С.Дашдооров, “Аав минь”)</p>
<p>Цаглашгүй мэнэрсэн сэтгэлт Цал буурал...ижий Муу бүгдийг сайн болгодог Муухай бүгдийг сайхан болгодог...ижий Зажилсан хоол нь шимтэй болбол Тавагтаа үлдээж Балгасан цай нь амттай болбол Данхандаа хоцроодог... ижий (Ц.Дамдинсүрэн, “Буурал ижий”)</p>	<p>...Хайртай хайртай гэхдээ Хайчаар тоглуулаагүй аав Мөрөөс бүхнийг гүйцээхдээ Мөнгөөр тоглуулаагүй аав (Т.Галсан, “Аав,ээждээ”)</p>
<p>...Хүслийн маань тэнгэр үр минь гэдэг Хүний маань дээд нь ээж минь юм шүү дээ. (Л.Дагвадорж, “Хүний маань дээд нь ээж минь юм шүү дээ”)</p>	<p>...Жаргал тэвэрч гэртээ ирдэг Жавар үргээж дандаа инээдэг Хүний сайн нь аав минь юм шүү дээ. (Ч.Содномдорж, “Аав минь”)</p>
<p>...Эрдэнээр эрдэнээр хайлаад ч Эргээд заяахгүй^{тодотгогч} ээж минь^{тодотгуулагч} ... (Т.Галсан, “Аав,ээждээ”)</p>	<p>...Алтаар алтаар уйлаад ч Ахиад заяахгүй^{тодотгогч} аав минь^{тодотгуулагч} (Т.Галсан, “Аав, ээждээ”)</p>
<p>Халуун сэтгэл өвөрлөсөн Хамгаас ачлалт ээжий (Ш.Дулмаа, “Энэрлийн тэнгэр ижий”)</p>	<p>Хазайхад минь тулдаг^{тодотгогч} Хэлтийхэд минь түшдэг^{тодотгогч} Ачит сайхан аав^{тодотгуулагч} (Д.Гомбожав, “Ачит аав”)</p>

<p>...Үүлэн сүүдрээс цээжээрээ халхлан Үрээ бүүвэйлэн мишээж суудаг^{тодотгогч} Өрлөг эхийн^{тодотгуулагч} ариун сэтгэлийг Өнгөт орчлонгийн нартай зүйрлэм. (Ш.Дулмаа, “Эхчүүд”)</p>	<p>...Өсөх бага наснаас минь Өвөртөлж тэтгээсэн^{тодотгогч} аав^{тодотгуулагч} ...Хүлэг морины дөрөөнд Хүргэж өгсөн^{тодотгогч} аав^{тодотгуулагч} (Д.Гаравсүрэн, “Аав”)</p>
<p>...Даамай хайрыг нэхээгүй^{тодотгогч} Даанчиг ачтай^{тодотгогч} аав ээж минь ээ^{тодотгуулагч} Дэлгэр сэтгэл нь хөрөөгүй^{тодотгуулагч} Дэндүү хайртай^{тодотгогч} аав ээж минь ээ^{тодотгуулагч} ... (Ч.Содномдорж, “Даанчиг ачтай аав ээж минь”)</p>	
<p>...Хүүгээ гэсэн намайгаа Хүний зэрэгт хүргэх гэж Цаг эргэх мөч бүрийд Цацлаа өргөсөн^{тодотгогч} ээж^{тодотгуулагч} (А.Дандий –Ядам, “Миний ээж”)</p>	<p>Уургаа тулаад адуундаа мордохдоо Уулсаа халхалсан^{тодотгогч} ханхар аав^{тодотгуулагч} (Л.Гаваасүрэн, “Зүүдэнд уяатай аав”)</p>
<p>Нүдний үзүүрт зэргэлсэн Шаргын уудам говьд Хайрын булаг боржилсон^{тодотгогч} Хайртай ээж минь^{тодотгуулагч} суудаг юм аа. (М. Цэдэндорж, “Миний ээж”)</p>	<p>...Хүн чулуунд хатуугаа үлдээсэн^{тодотгогч} Хүүхдийн даахинд зөөлнөө үлдээсэн^{тодотгогч} Хүндэт өвгөд минь.^{тодотгуулагч} (Д.Цоодол, “Хүндэт өвгөд минь”)</p>
<p>Зүүдэнд аргадах хайраараа Зүүн хацрыг минь үнсээд Зүүрмэглэх төдий нойрондоо Зүрхэндээ нөмөрлөдөг^{тодотгогч} ижий^{тодотгуулагч} (Б.Ичинхорлоо, “Ижий”)</p>	<p>Өөрөөсөө унагаж Энгэрээсээ ундлаагүй ч Өвөртөө нөмөрлөж Элгэндээ бүлээцүүлж өсгөсөн аав минь Амьдралаас дутуу буцсан ч Алдраа бүтэн үлдээсэн аав минь (Ш.Уянга, “Аав”)</p>

эцэг, эхийн өглөг их хайр, ачлах энэрэхийн сайхан үйл, үр хүүхэд нь өсч том болоод эцэг, эхийнхээ цаглашгүй их хайр, энэрлийг бишрэн магтаж, хүндэтгэн дээдэлсэн эерэг үнэлэмжийг уран сайхны орон цаг, үйлийн орчил дунд илэрхийлэхдээ дэлгэрэнгүй чимэг тодотгол, чимэг тодотгол өгүүлбэрийг голлон хэрэглэжээ. Дээр багананд зэрэгцүүлснээс үзэхэд “эх-ээж-эжий”-ийн

болон “өвгөд-аав”-ын чимэг тодотголууд, түүний үүрэг, хэрэглээ, утга нь өөр хоорондоо ялгаатай байгаа нь монгол хүний “эцэг-эх”-ээ үзэх соёл, сэтгэлгээний онцлогтой салшгүй холбоотой.

Манай зохиолч, найрагчдын бүтээлүүд “бүсгүй-гэргий” хүний намба төрх, өнгө үзэмж, зан ааль, ажил үйл, энэрэл хайр зэргийг тодотгосон утгын чимэг, урансайхан дүрслэлээр баян бөгөөд тэрхүү чимэг тодотголуудад өгүүлэгчийн эрчим тэмүүлэл, сэтгэл сэрвэлзүүлсэн хүсэл зориг, эерэг үнэлэмж гүнээ шингэсэн байдаг. Үүний зэрэгцээ “хүч тэнхээтэй монгол эр хүн”, “холч ухаалаг монгол эр хүн” гэсэн ухагдахуун ойлголт, үнэлэмж уламжилж ирснийг уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголоос харж болно.

Тухайлбал,

<p><i>Гэрт орж гэгээнтэнд мөргөдөггүй</i> <small>тодотгогч</small></p> <p>сайн эрийн <small>тодотгуулагч</small> тухай ярианууд сэтгэлд ургав.</p> <p>(Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”)</p>	<p><i>Хайрын сэтгэлийг гэгэлзүүлсэн</i> <small>тодотгогч</small></p> <p><i>Хархан нүдтэй</i> <small>тодотгогч</small></p> <p>бүсгүй минь <small>тодотгуулагч</small></p> <p>(Л.Баатарзоригт, “Хархан нүдтэй бүсгүй”)</p>
<p>Зээрийн шаргал дэнж дээр</p> <p>Ханаа шийрлэн тухалсан</p> <p>Зэрэглээ хатирсан талдаа</p> <p>Хангал булгиулж аархсан</p> <p><i>Босоо хийморьтой</i> <small>тодотгогч</small></p> <p>эр хүн <small>тодотгуулагч</small></p> <p>(Б.Пүрэвсүрэн, “Босоо хийморьтой эр хүн”)</p>	<p><i>...Зуун жил улиран одовч нэгээхэн зуур мартагдахын аргагүй, ертөнцийг уйлуулж дуулуулсан</i> <small>тодотгогч</small> эрх хар нүдтэй, <small>тодотгогч</small> үзэсгэлэн <small>гоо</small> <small>тодотгогч</small></p> <p>бүсгүйчүүлийн <small>тодотгуулагч</small> тухай би бичихгүй байж чадашгүй нь.</p> <p>(Б.Догмид, “Сайхан бүсгүй жаргадаггүй”)</p>
<p><i>Тэнгэрлэг сайхныг өвөрлөн</i></p> <p><i>төрсөн</i> <small>тодотгогч</small></p> <p><i>Тэнхээт</i> <small>тодотгогч</small> эрчүүл <small>тодотгуулагч</small></p> <p>айлын шүтээн</p> <p>Бүхэл бүтэн нэгэн өрхийн</p> <p>Бүрэн эрхт эзэн заяа</p> <p>(Ш.Дулмаа, “Эзэн заяа”)</p>	<p><i>Эгэл даруухан төрхөөрөө</i></p> <p><i>Орчлонг зөөллөж мишээсэн</i> <small>тодотгогч</small></p> <p><i>Эрхэмсэг агаад тэнгэрлэг</i> <small>тодотгогч</small></p> <p><i>Монголжингоо</i> <small>тодотгогч</small></p> <p>бүсгүйчүүд минь ээ <small>тодотгуулагч</small></p> <p>(Н.Баянмөнх, “Монголжингоо”)</p>
<p>...Үзвэл, нас хорин гурав дөрөв хир, <i>нүүртээ цогтой,</i> <i>нүдэндээ галтай,</i> <small>тодотгогч</small></p> <p><i>шаавхийсэн</i> <small>тодотгогч</small> хар хүү....</p> <p>(Д.Нацагдорж, “Үзэгдээгүй юм”)</p>	<p>Үйлэнд урнаараа цуутай яа,</p> <p><i>Ай, миний нутгийн хонгорхон</i> <small>тодотгогч</small></p> <p>бүсгүй <small>тодотгуулагч</small></p> <p>(П.Бадарч, “Миний нутгийн бүсгүй”)</p>

Дээрх бүлэглэлийн чимэг тодотголыг ажиглахад хэл талаасаа “чимэг үг+нэр үг”(гэргий-бүсгүй), (эрчүүд-хархүү) эсвэл “чимэг тодотгол өгүүлбэр+нэр үг” (гэргий-бүсгүй), (эрчүүд-хархүү) харьцаа бүхий загвараар илэрч, хэлэхүй тал ба хэрэглээ талаасаа чимэг нь тодотгол нь “эрчүүд-хархүү”, “гэргий-бүсгүй”-ийн зан ааль, мөс чанар, сэтгэл санаа, хайр энэрэл, намба төрх, өнгө үзэмж тэргүүтнийг урнаар тодотгохын хамт өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан өнгө аясын илэрхийлэл болжээ. Түүнчлэн “эрчүүд-хархүү”-ийн чимэг тодотголууд, “гэргий-бүсгүй”-ийн чимэг тодотголууд, түүний үүрэг, хэрэглээ, утга нь өөр хоорондоо ялгаатай байгаа нь харагдаж байна.

Дүрслэлт чимэг тодотгол нь цогцолбороор илэрч, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэнэ. Тухайлбал,

- *Дүрийн (хүний) зан ааль, цог жавхлант байдлыг дүрслэн чимэглэсэн, магтсан утгатай, тоочимж цогцолбор:*

...Үг хэлэлцэн хичээнгүйлэн аашлах нь бага хүүхэд мэт хөнгөмсөг эевэргүү, хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ үе үе яралзуулан инээмсэглэн мишээнэ. Хээр талын дунд хөндлөн гулд давхиж, хөдөөгийн саруулд биеэ гайхуулсан^{тодотгогч} ийм^{тодотгогч} нэг үзэсгэлэнт **охинтой**^{тодотгуулагч} учраад, хэрхэн сэтгэл хөдлөхгүй байж болох ажээ.

(Д.Нацагдорж, “Хөдөө талын үзэсгэлэн”)

Зохиолын баатрын зан чанар, дотоод сэтгэл, гадаад үзэмж хийгээд өрөөл бусдаас ялгагдах хамгийн тодорхой онцлог шинжийн илэрхийлэл нь “нүдний тухай дүрслэл” юм. Энэ утгаараа “нүд” гэсэн тодотгуулагч нь эерэг ба сөрөг үнэлэмжит дүрслэлт чимэг тодотголоор утга дэлгэрэх нь түгээмэл байна. Үүнээс эерэг үнэлэмж бүхий чимэг тодотголтой дүрслэлийг авч үзвэл:

- Уран сайхны дүрийн цовоо сэргэлэн, авхаалж самбаатай төрх байдлыг,

...Уургын морины *галтай сэргэлэн*^{тодотгогч} **нүдийг**^{тодотгуулагч} үзвээс өхөөрдөн хайрлахын сацуу бас өр өвдөх шиг болдог. (Б.Догмид, “Хөөрхий”)

...*Үргэлж мишээж тоглож байдаг*^{тодотгогч} **жарталзсан хар нүд**^{тодотгуулагч} ...тэр бүхэн нь ямар сайхан болоо вэ гэж ид хав нь сэргэн,... мориндоо ташуур өгч, хатсан газрын тоосыг пур пур шидэлсэн суман хатираагаар гүйцэн ирэв.

(С.Эрдэнэ, “Хөх хулгана жил”)

...Морины салхинд дэрвэлзэх улаан торгон алчуурын сэжүүр дороос
инээмсэглэл бужигнуулсан^{тодотгогч} эрх хар нүд^{тодотгуулагч} тормолзоно.

(Б.Догмид, "Хүний хань")

...Зуун жил улиран одовч нэгээхэн зуур мартагдахын аргагүй, ертөнцийг
уйлуулж дуулуулсан^{тодотгогч} эрх хар нүдтэй^{тодотгуулагч} үзэсгэлэн гоо
бүсгүйчүүлийн тухай би бичихгүй байж чадашгүй нь.

(Б.Догмид, "Сайхан бүсгүй жаргадаггүй")

хэмээн "чимэг тодотгол-үг", "чимэг тодотгол өгүүлбэр"-ээр,

➤ Уран сайхны дүрийн намуун дөлгөөн, ухаалаг төрх байдлыг,
Хатанбаатар Дулмааг зөөлөн бөгөөд бахдалтай^{тодотгогч} нүдээр^{тодотгуулагч}
ажиглан хэсэг зогссоноо эргэж майхандаа ороод удалгүй хүрэн цэмбэн хүрэм
барин гарч ирээд "чиний оёсны дээд талаар урагдсан байна билээ" гээд өгөв.

(Ч.Лодойдамба, "Тунгалаг Тамир")

...Бормаамын хорхойд хоргүй^{тодотгогч} хоёр зөөлөн^{тодотгогч} хар нүд^{тодотгуулагч},
түүний цээжнээс битүү амьсгаагаар ус шиг урсах "хөх торгон дээл"-ийн уран
торгон нугалаатай хөхөмдөг хөх аялгууг сонсоход хөөрхий хөдөө хээр
явгалан элдэвлэн зовоосноо бодохоос гэмших байтугай үхэхэд ч багадмаар.

(Б.Догмид, "Томоогүй нас")

гэж чимэглэн тодотгосон байдаг бол,

➤ Уран сайхны дүрийн сэтгэл татам сайхан төрх байдлыг,
Анх удаа харж байгаа Дулмаагийн нүдэнд хүрээний юм бүхэн сонин бөгөөд
нэг юмнаас нөгөө юманд шилжүүлэх бүрдээ Төмөрийг их хайр, үлэмж баяр
хосолсон^{тодотгогч} нүдээр^{тодотгуулагч} харж инээмсэглэнэ.

(Ч.Лодойдамба, "Тунгалаг Тамир")

Зүрх гижигдсэн^{тодотгогч} сайхан хар нүдийг^{тодотгуулагч}

Зүүдэндээ үзлээ, би.


(Р.Чойном, "Хар нүд") гэсэн

чимэг тодотголоор дүрслэн илэрхийлжээ. Зохиолын баатрын баяр жаргалтай,
жавхаалаг, хийморьлог шинжийг илтгэсэн уран дүрслэл нь "нүд" гэсэн үгийг
тодотгохын зэрэгцээ өгүүлэгчийн сэтгэлд нийцтэй, тааламжтай мэдрэмжийн
илэрхийлэл болжээ. Дүрийн (хүний) сэтгэлийн хүч тэнхээ баяр баясгалан,
цог хийморьийг илтгэсэн утгатай "жарталзсан-нүд, эрх-нүд, хөөрхөн-нүд,
зөөлөн-нүд, бахдалтай-нүд, хархан-нүд" гэсэн "чимэг үг, тодотгогч-
тодотгуулагч, нэр үг"-ийн харьцаагаар, "галтай сэргэлэн-нүд, хорхойд хоргүй-

нүд, урин зөөлөн-харц” гэсэн “чимэг тодотгогч, нийлэмж үг-тодотгуулагч, нэр үг” харьцаа хамаарлаар, “үргэлж мишээж тоглож байдаг-нүд, инээмсэглэл бужигнуулсан-нүд, нэгээхэн зуур мартагдахын аргагүй-нүд” гэсэн “чимэг тодотгол өгүүлбэр-тодотгуулагч, нэр үг” гэсэн бүтэц загвар голлож байна.

Нэгтгэн загварчилж харвал,

Загвар №4



Өгүүлэгчийн эерэг үнэлэмжит олон янз дүрслэлт чимэг тодотголыг захирдаг, гол тодотгуулагчид “морь-хүлэг-ажнай-адуу” гэсэн нэр үгүүд багтаж байгаа юм. Хүлэг морь бол монголчуудын амьдралд хамгийн ойр, хамгийн найдвартай хань нөхөр нь байсныг эрт эдүгээгийн аман болоод бичгийн зохиолуудад яруу сайхнаар дүрсэлж, “морь-молор эрдэнэ” хэмээн хайрлан шүтэж, магтан дуулж ирсэн уламжлалтай. Тодруулбал,

А. “Д.Равжаа “Өндөрлөгч ууланд” шүлэгтээ:

Хазаараараа наадагч

Хайсан хар морь

Харихдаа донгодогч

Галабингийн эгшиг бий гэж шүлэглэжээ.

Энэ бадагт “хазаараараа наадсан” гэж хөлөг морины сайхныг тун өвөрмөцөөр дүрсэлсэн юм.”⁶⁹

...Од, мичдийг магнайдаа тоглуулсан^{тодотгогч}

Орчлонд ижилгүй морь мину^{тодотгуулагч} ...

(Б.Догмид, “Санаж сарвайх нутаг ус минь”)

Шашир суман дэлэнд нь

Салхи исгэрэн наадсан^{тодотгогч}

Сайхан монгол морь минь^{тодотгуулагч}

⁶⁹ Хүрэлбаатар Л.,Огторгуйн цагаан гарди,Уб.,1996.147-р тал.

(Л.Дагвадорж, “Сайхан монгол морь”) гэж хүлэг морины шандас хүч, хийморь жавхааг сайшаан магтсан бол,
...Гал улаан зээрд зүстэй, өндөр сэрвээ, өргөн ташаатай, ханагар цээж, *гөрөөсний хөл хөл*, шингэн боловч шулуун сүүл унжин, *согоо шиг хоёр чихтэй* энэ **морийг** харсан хүн бүхэн ёстой л аргамгийн дээд байна гэдэг. Сайн морь шогшуулж, сайн морь хатируулдаг *гуйн хар алхаа, долгион урсах арилжаа хатираа* нь унаж яваа хүний сэтгэлийг баяр бахадлаар дүүргэнэ.^{тодотгогч} Үнэхээр ч *харсан бүхний нүд булаасан*^{тодотгогч} сайхан ч, сайн ч **морь**.^{тодотгуулагч}

(Ч.Лодойдамба, “Хайр жигшил”)

хэмээн галбир төрх, шинж байдлын сайхныг нь магтан, чимэглэн тодотгож дүрсэлсэн байдаг.

Б. Монголчуудын хувьд морь бол эрт, эдүгээ ч хүний сайн нөхөр, морьгүйгээр малчин ахуй соёлыг төсөөлөх аргагүй юм. Иймээс,

...Хайр даахнаа ухаантай^{тодотгогч}

Хал даахнаа урамтай^{тодотгогч}

Оломны цагаан олойртой

Миний номхон **ажнай**^{тодотгуулагч}

(Д.Банзрагч, “Хонины морь”)

...Хонь үхрийн бэлчээр тахиж эргэлдэхгүй

Хол хэрмүүн хээрт үс нь онголж атарлан,

Хоногийн шөнөдөө босоо зүүрмэглэн сэрэх^{тодотгогч}

Хорвоогийн сэргэлэн амьтан адуу^{тодотгуулагч} сайхан.


П.Бадарч, “Адуу”) гэж

шүлэг зохиолдоо магтан дуулдаг билээ.

(А) бүлэгт авч үзэж байгаа чимэг тодотголууд нь монгол “хүлэг морь”-ны хүч чадал, золбоо хийморь, цог жавхлант байдлыг илтгэжээ. Дүрслэлт чимэг тодотгол нь гол төлөв “чимэг тодотгол үг+нэр үг” (хүлэг-морь-ажнай) бүтэцтэйгээр илэрсэн бол, (Б) бүлэгт авч үзэж байгаа чимэг тодотголууд нь “морь” бол монгол хүний итгэлтэй нөхөр, зорьсон үйлд нь саадгүй хүргэдэг тэнгэрлэг “хүлэг” гэдгийг харуулсан. Дүрслэлт чимэг тодотгол нь гол төлөв “дэлгэрэнгүй чимэг тодотгол өгүүлбэр+нэр үг” (хүлэг-морь-ажнай) гэсэн бүтэц голлож байна.

Эдгээрийг нэгтгэн харвал,

Загвар№5



Хүний сэтгэлийн дотоод орчлон руу нэвтрэн, сэтгэл хөдлөлийн нарийн хөг, өнгө аясыг хөндөн доргиох нь зохиолч, найрагчдын уран чадварын илэрхийлэл билээ. Уран сайхны эхийн баримтаас ажиглахад, “дотоод” ертөнцийн дүрслэл буюу хүний сэтгэл зүрхний намуун зөөлөн уянга, сэтгэлийн догдлол, уярал хайрлал, санаашрал, цайлган сэтгэл, гэгээн гуниг зэрэг бодлогоширдог сэтгэлгээ нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор дамжин илэрдэг бөгөөд гол тодотгуулагч нь “аялгуу” хэмээх үг байна.

Монголчууд хийсвэр ухагдахуун ойлголтыг өнгөөр ёгтлох заншилтай байсан агаад цагаанаар хиргүй тунгалгийг илэрхийлдэг. Энэ нь уран сайхны эхийн найруулга дахь чимэг тодотголд тусгалаа олж, уламжилсан байна.

Тухайлбал,

...Өнөөдрийг хүртэл цээжиндээ баринтаглан хадгалж уйлан хайлан дуулж явсан зүрхний *цагаахан*^{тодотгогч} **аялгуу**^{тодотгуулагч} Хөшөөтийн найман ухаа толгод хөх ногооны униарт будантан хөхөрнө.

(Б.Догмид, “Эргэж төрдөггүй орчлон”)

...Цагаан өвс аниргүйхэн ганхах их тал эл хульхан, бялзуухай ч үл жиргэх бөгөөтөл манан будангийн дуу л ийм л байдаг болов уу гэмээр нэгэн бүдэгхэн *цагаан*^{тодотгогч} **аялгуу**^{тодотгуулагч} чихний үзүүрт сонсогдохтой үгүйтэй холдон ойртон эгшиглэнэ.

(Б.Догмид, “Нутаг”)

гэж өнгийн бэлгэдэл утгыг сэтгэл хөглөх торгон мэдрэмжийг илтгэсэн шууд бус нэрлэлтийн утга бүхий чимэг тодотголын үүргээр хэрэглэсэн нь дүрслэлийн нарийн ур маяг болж чадсан төдийгүй өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлдэг.

Түүнчлэн монгол хүний сэтгэл хөдлөлийн нандин сэрэл сэрэхүйг илтгэх “аялгуу” хэмээх тодотгуулагч үгэнд чанарын утгат дүрслэлт чимэг тодотголыг захируулан эерэг үнэлэмжийг үзүүлжээ. Үүнд:

А.Би гараасаа хөтлөх хүүтэй болсон гэж санахаас түүний цээжинд хайр энхрийллийн нэгэн сайхан *жаргалтай халуун*^{тодотгогч} **аялгуу**^{тодотгуулагч} халгилан эгшиглэнэ. (Б.Догмид, “Эргэж төрдөггүй орчлон”)

...Асгармал цагаан саран асхандаа манддаг дэлхийд аньсгандаа нууж залбирмаар *нууцхан*^{тодотгогч} **аялгуу**^{тодотгуулагч} байдаг аа.

(И.Нарантуяа, “Нууцхан аялгуу”)

...Чагнахуйяа чухам л

Цангаа гаргам^{тодотгогч} *сайхан* **аялгуу**^{тодотгуулагч}

Үдшийн оддын гэгээ шиг^{тодотгогч}

Дөлгөөхөн **аялгуу**г хүсэмжлэн... (З.Түмэнжаргал, “Тууварчны охин”)

“жаргалтай-аялгуу”, “халуун-аялгуу”, “сайхан-аялгуу”, “нууцхан-аялгуу”, “дөлгөөхөн-аялгуу” гэсэн тодотгогч-тодотгуулагч -ийн харьцаан дахь чимэг тодотголоор,

Б. ...Цонхон дээр тавьсан ер бусын тод сонин өнгөтэй гал улаан цэцэг үзэгдлээ. Тэр цэцэгнээс алтан утас адил *эмзэг энхрий*^{тодотгогч} **аялгуу**^{тодотгуулагч} долгион байх шиг...

...Сэтгэлд тэмтрэгдэж, гарт баригдашгүй хол атлаа зүүдэндээ л сонссон байлтай сайхан гэж хэлэхэд дэндүү багадмаар ороо жороо **аялгуу** гунигтайхан эгшиглэх нь даанч эмзэгхэн.

(Б.Догмид, “Эргэж төрдөггүй орчлон”)

“эмзэг энхрий-аялгуу”, “ороо жороо-аялгуу” гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь “чимэг тодотгол нийлэмж”-ээр,

В. *Сэтгэлд тэмтрэгдэж, гарт баригдашгүй хол атлаа зүүдэндээ л сонссон байлтай сайхан гэж хэлэхэд дэндүү багадмаар ороо жороо* **аялгуу** гунигтайхан эгшиглэх нь даанч эмзэгхэн.

(Б.Догмид, “Эргэж төрдөггүй орчлон”)


...Асгармал цагаан саран асхандаа манддаг дэлхийд аньсгандаа нууж залбирмаар^{тодотгогч} *нууцхан* **аялгуу**^{тодотгуулагч} байдаг аа.

(И.Нарантуяа, “Нууцхан аялгуу”) гэх мэт

“чимэг тодотгол өгүүлбэр”-ээр өгүүлэгчийн уярал, догдлол, бардамнал зэрэг

дотоод сэтгэлийн нандин мэдрэмжийг гүн гүнзгий илэрхийлсэн уран дүрслэл болжээ.

Эдгээрийг нэгтгэн харвал:



Дээрх жишээнүүдийн чимэг тодотголыг ажиглахад:

1. Уран сайхны чимэг тодотголууд нь хэлбэр-хэлзүйн бүтцийн талаасаа:

- “Тодотгон холбох нөхцөлтэй үйл үг+нэр үг” гэсэн загвар, ялангуяа өнгөрсөн цагаар тодотгон холбох -сан, -сэн, -сон, -сөн нөхцөл илүү их давтамжтай байгаа нь уран сайхны эхийн учирзүйн холбоо харьцаа, цагийн нөхцөлийн найруулгын үүрэг, өгүүлэгчийн үнэлэмж, эхийн мэдээллийн бүтэц, өгүүлж буй орон цагтай холбоотой зүйл юм.
- Тодотгогч–тодотгуулагчийн харьцаанд “тэмдэг үг+нэр үг” гэсэн бүтэц загвар голлож байна. Энэ нь уран сайхны эхэд өгүүлэгчийн үнэлэмж нь хэлзүйн тодотголын байдал, шинж, чанарын утгатай нөхцөлдөж буйтай холбоотой гэж үзэж болно.
- Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлэхэд хүч нэмэгдүүлсэн тодотгол үгүүд чухал үүрэгтэй байна.

2. Өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрхийлсэн чимэг тодотголуудын илрэх хэмжээ урт нь “ чимэг тодотгол-үг” , “чимэг тодотгол-нийлэмж үг”, “чимэг тодотгол-өгүүлбэр”, “чимэг тодотгол-цогцолбор” гэх мэт янз бүр байна. Гол төлөв дэлгэрэнгүй хэлбэрээр илэрч байгаа нь өгүүлбэрзүйн тодотгогч-тодотгуулагчийн харьцаа, өгүүлбэрзүйн нөхцөлдөх утга, түүний утгыг бүрдүүлж буй үгсийн утгазүйн нарийн учир, дэс дараалалтай холбоотой.

3. Хэлэхүүн , хэрэглээ талаас харвал:

- Өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан омогшсон, хүндэтгэн биширсэн, магтан сайшаасан өнгө аясыг илэрхийлсэн хураангуй ба дэлгэрэнгүй чимэг тодотгол
 - Монгол зан үйл, сэтгэлгээний онцлогийг илтгэсэн утгатай чимэг тодотголууд байна.
4. Монгол уран сайхны эхийн найруулга дахь чимэг тодотгол нь урнаар дүрслэх хэрэглүүр болохоос гадна байгаль ертөнц, хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд, аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэл, тэдгээрт өгсөн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэх үүрэгтэй байна.

1.3. Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

“Адилтгал” дүрслэх ур маягийн талаар уран зохиолшинжлэлд хэрхэн тодорхойлж ирснийг товч дурдъя.

Дандины “Зохист аялгууны толь”-д адилтгах ёсыг “үлгэрийн чимэг” гэж нэрлээд үлгэрийн чимэгтээ адилтгалын гучин хоёр хувилбарыг гаргажээ.

Эрдэмтэн Х.Гаадан: “Зохиолын утга санааг улам нэвтэрхий, тансаг гоо сайхан, гоо болгодог уран дүрслэлийн арга Дандины толинд боловсорсон гэж болно. Уран дүрслэлд юуны өмнө адилтгалыг оруулан хэлэлцэж болно. Адилтгах ёсыг ерөнхийд нь “үлгэрийн чимэг”, “адилтган гийгүүлэх үгсийн найруулга” гэж хоёр ангид хуваажээ.”⁷⁰ хэмээн тэмдэглэсэн бол, эрдэмтэн Д.Галбаатар: “Дүрслэлийн нэг зүйл уран хэрэглүүр юм. Төрлийн нэг зүйлийг зүйлд юм уу төрөл эсвэл өөр зүйлийг адил төсөөр нь ижилсүүлэн дүрслэх аргыг адилтгал гэнэ. Жишээ нь:

Нийлсэн хоёрын сэтгэл нь

Мянган лан алт шиг

Зайгүй хатуу нягтад нь

Зүүний үзүүр орохгүй (Д.Н.“Янаг”) гэж тодорхойлсон байна.⁷¹

⁷⁰Гаадан Х., Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл, Уб., 1986. 14-р тал.

⁷¹Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь, Токио., 2002. 12-р тал.

Эрдэмтэн С.Дулам, Ц.Хасбаатар: "Адилтгал нь юуны өмнө хоёр юм үзэгдлийн адил төстэй байдалд үндэслэсэн бөгөөд зүйрлэлээс ялгаатай нь адилтахуун нь адилтгагдахуунаараа илэрдэг"⁷²

Эрдэмтэн Ш.Гаадамба: "Үзэгдлүүдийн төстэй талыг нь харьцуулан зааж, үг холбон бичсэнийг адилтгал гэнэ."⁷³

Эрдэмтэн Г.Галбаяр: "Адилтгал гэдэг харьцуулан үзэж байгаа хоёр үзэгдлийн адил төстэй байдалд үндэслэж гол мөн чанарыг гаргах гэж буй юм нь далд байж, түүнтэй адилтгасан зүйл нь ил дүрслэгдэхийг хэлдэг."⁷⁴ хэмээн дүрслэх ур маяг болох талаас нь тодорхойлсон байна.

Эрдэмтэн М. Базаррагчаа: "Монгол хэл нь шууд ба шууд бус нэрлэлтийн зүйлээр нэн баян юм. Шууд бус нэрлэлтээр бүтсэн ил ба далд адилтгал нь хэлэхийн цуваанд бүтээвэр, үг(гишүүн), холбоо үг, нийлмэл өгүүлбэр, цогцолбор зэрэг үндсэн ба завсрын түвшний аль ч нэгжийн цуваанд бүтдэг байна."⁷⁵ хэмээн хэлний их ба бага нэгжтэй холбон тайлбарласан бол судлаач Б.Даваасүрэн: "Хэлэхүйн адилтгал: Энэхүү шатанд толь бичигт тэмдэглэгдээгүй, нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй боловч тухайн хэлээр яригчдын ухамсарт байж, тохиолдлын болон ер бусын илэрч гарч болохуйц адилтгал байдаг. Ийм төрлийн адилтгал нь гол төлөв санал асуулгаар гарч ирдэг. Тухайлбал, салхинд дэрвэж буй өрх гэж "чалчаа" хүнийг, хавар эрт ургаж буй өвс гэж "туршлагагүй" хүнийг, нялзгай гурил гэж "эрх нялуун" хүнийг...гэх зэргээр зүйрлэн хэлсэн байдаг. Хэлний адилтгал: Энэ нь нийтээр хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл, тухайн ярилцагчдад аль хэдийн танил болсон, зүйрлэл болох шатандаа яваа адилтгал, уран зохиолын зүйрлэл юм." гэж хэлэхүй, хэрэглээний талаас тодотгон авч үзжээ.⁷⁶

Орчин үед метафорыг танин мэдэхүйн хэлшинжлэлийн судалгааны нэгэн төрөл болгон авч судалж байна. Танин мэдэхүйн хэлшинжлэлийг үндэслэгч Жорж Лакоф, Марк Жонсон нар "Метафор бол найруулгын төдий асуудал бус, бид бүхний үндсэн танин мэдэхүйн чадварын нэг мөн" хэмээн үзэж,

⁷² Дулам С., Хасбаатар Ц., Уран зохиолын онолын үүд, Уб., 1980.152-р тал.

⁷³ Гаадамба Ш., Утга зохиолын онолын товч, Уб., 1958.104-р тал.

⁷⁴ Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн лекц, Уб., 2002.91-р тал.

⁷⁵ Базаррагчаа М., Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр, Уб., 1993.45-р тал.

⁷⁶ Даваасүрэн Б., Орчин цагийн монгол хэлний хүншүүлсэн утга, Уб., 2009.14-р тал.

асуудлыг дэвшүүлсэн байна.⁷⁷ “Хийсвэр ухагдахуун болон тодорхой юмс үзэгдлээс тогтсон бодит ухагдахуун хоёрын дунд бүрэлдэн тогтсон тогтвортой, харилцан хамаарал бүхий харилцааг Метафор гэж хэлнэ гээд, цаашлаад энэ нь хэдийгээр зүйрлэлийн шинжтэй боловч, утга зохиолын ойлголтод багтдаг чимэг төдий зүйл биш, харин ч өдөр тутмын амьдралд тохиолдож, хэрэглэж байдаг юм гэж дүгнэжээ.

Эрдэмтэн Ж.Баянсан: “Адилтгал, зүйрлэлийн үндэс нь хоёр юмыг жишин харьцуулах аргад тулгуурласан байдаг. ...Ийнхүү жишин харьцуулна гэдэг бол нэг юмыг нөгөө юмтай ямар нэг хавьтал хамааралтай болгож байгаа авалцуулан холбох сэтгэцийн үйлдэлтэй холбоотой юм. ...Ийм учраас юуг юутай авалцуулан холбож, адилсуулж үзэх нь үнэндээ хүний өөрийн дурын хэрэг болно. Үүнийг ялангуяа бодгаль хүн-зохиолч, яруу найрагч уран дүрслэлийнхээ арга болгож хэрэглэсэн нь адилтгал зүйрлэлээс тодорхой ажиглаж болно.”⁷⁸ гэжээ.

Эрдэмтэн А.Пүрэвжанцан: “Үгийн сангийн цөм утга хэрэглээний явцад их төлөв зүйрлэх, адилтгах байдлаар өөрчлөгдөн утга шилждэг түүхэн зарчимтай.”гээд 1990 –ээд оноос хойшхи сонины материалыг ажиглан, шинээр түгээмэл ашиглаж, хэрэглээнд оруулж байгаа үгсийг зүйрлэн нэрлэх (будaa болгох, бялуу хуваах, гахай зөөх, хор найруулах), солин нэрлэх (борчуудын хороолол, өвгөнтийн хөндийнхөн, хөдөөгийн фракц), төлөөлөн нэрлэх (жалгын үзэлтэн, амлалтын депутат), шинэ юм үзэгдлийг зааж, шинэ утгаар хэрэглэх (ил тод байдал, намчирхах, нийгмийн эмзэг хэсэг, олонхи, цөөнх...) ⁷⁹ гэж тоймлон ангилсан бол, эрдэмтэн С.Энхбаяр: “Үгийн утга шилжүүлэн бодитойг хийсвэрлэх, хийсвэрийг бодгальжуулж, өөрийн гэсэн өвөрмөц содон гаж адилтгал бүтээж байгаа нь манай найрагчдын урнаар сэтгэх сэтгэлгээний хэв маягийн тусгал болж, туурвилзүйн онцлогийг нь бүрдүүлж байна.”⁸⁰ хэмээн адилтгал зүйрлэлийн үр дүнд өвөрмөц шинэ нэрлэлт үүсч байгаа талаар дүгнэн хэлсэн байна.

⁷⁷ Тогтуун Э., Метафор ба когнитив хэлшинжлэл, МУИС, МХСС, Монгол судлал, Уб., 2010. 329-р тал.

⁷⁸ Баянсан Ж., Соёл, хэл, үндсэний сэтгэлгээ, Уб., 2002. 25-р тал.

⁷⁹ Пүрэвжанцан А., Үгийн утга шилжих тухайд, МУИС, МСС, Монгол судлал, Уб., 1999. 67-р тал.

⁸⁰ Энхбаяр С., Утга зохиолын онол, Уб., 2011. 234-р тал.

“Орчин үеийн когнитив хэлшинжлэл метафорыг дүрийг тодотгогч, хэл яриаг чимэглэгч утга тонгоргосон хэллэг бус харин сэтгэхүйн хэлбэр гэж үздэг. Харилцааны үед метафор нь харилцагчийнхаа оюун санаа, мэдрэмж, хүсэл эрмэлзэлд нөлөөлөх чухал хэрэгсэл болдог.”⁸¹

Адилтгасан нэрлэлтийг бүрдүүлж байгаа тухайн нэрийн утгыг хийсвэрлэхдээ түүгээр нэрлэгдсэн юмын бүх шинжийг биш, шинэ нэрлэлт үүсэхэд давын өмнө зайлшгүй хэрэг болж байгаа аль нэг шинжийг л онцолж сонгодог. Тухайн нэрлэгдэхүүний бусад шинж нь энэ удаад төдий л чухал биш болж, орхигдох онцлогтой байна. Зальжин хүнийг “үнэг” гэдэг адилтгалаас үүдэж, хүн ер нь сүүлтэй бил үү гэж бодох хэрэггүй, харин хийсэн хэрэг хэлсэн үгийнхээ ул мөрийг баллачихдаг шинжийг л онцолсон байдаг гэж Н.Д. Артюнова тодорхой тайлбарласан байдаг.⁸²

Иймд адилтгал нь дүрслэлийн нэгэн зүйл уран хэрэглүүр төдийгүй үндэстний ахуй амьдрал, зан заншил, соёл сэтгэлгээний онцлог, өгүүлэгчийн үнэлэмжийг тээж байдаг “хэлний нэгж” юм.

1.3.1. Монгол уран сайхны эхэд байгаль ертөнц, түүнд өгсөн өгүүлэгчийн үнэлэмж нь дүрслэх ур маяг адилтгалаар дамжин илэрч, тодотгогч-тодотгуулагчийн харьцааг илтгэж байдаг. Жишээ нь,

А) ...Надад заяасан

Нар, сартай *диваажин*

Намтар түүхээ дархалсан

Насан үүрдийн *өлгий эх орон*

(Ш.Дулмаа, “Хайрын мянган бодол”)

...Ай хөөрхий, өвчүүн дээрээ тоглуулж өсгөсөн *өлгий* их **нутаг минь** өмнө зүгт байдаг аа. Хатан булагт минь хавар аль хэдийн ирчихсэн шинийн нэгний өглөө сумаа тойроод мөрөө гаргах шинэ хүний тоо нэмэгдэж л байгаа даа.

(Г.Мөнхцэцэг, “Миний Хатанбулаг эх орноо манадаг”)

Мянган угалзатын өвөр бэлийн хэдэн толгод дунд Хүрэн толгойн бууц бий. Миний нутгийнхан бүүр тодруулж, Хуудасны хүрэн толгой гэнэ. Ямархан аз

⁸¹ Төмөрхуяг Б., Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэлшинжлэлийн үүднээс судалсан нь, УБ., 2011. 8-9-р тал.


⁸² Артюнова Н.Д., Языковая метафора, Лингвистика и поэтика.М., 1979.с.160.

тохиолоор Хүрэн толгойн бууцанд мэндлэв дээ. ...Ай, хөөрхий амьсгал уужруулах *алтан хэвлий* **Хүрэн толгойн бууц** минь би чамтай амь нэгтэй шүү, Хайрхан минь. (Ж.Баттулга, “Хүрэн толгой”)

хэмээн нотлон адилтгасан нь төрж өссөн нутаг юугаан эрхэмлэн дээдэлсэн иргэн хүний сэтгэлийн илэрхийлэл мөн.

Эдгээрийг нэгтгэн харвал,

Загвар №7



Б) ...Нар дурлаж өдөржин саатдаг **эх орон**

Сар дуншиж шөнөжин мэлмэрдэг **ээж орон**

(М.Билигсайхан, “Эх орны минь босго өндөр”)

...Олон жарны домог жаргааж налайсан

Оргил тэргүүн нь буурал **эжий газар** (Л.Мөнхтөр, “Ижий газар”)

Орчлонд миний заяаж үдэлсэн **газар ээж**, миний аниргүй цэнхэр алс, Монгол их Алтайнхаа хормой бэлийг дэрлэн бойтогны минь хонхны хэлгий бөөлөөг анирдан нам гүмхэн налайна. (С.Пүрэв, “Аниргүйн цэнхэр аяз”)

хэмээн газар шороо, нутаг орноо ачлал элбэрэлт “ижий”-тэйгээ адилтган, урнаар дүрсэлсэн бол,

В. ...Өлгийдөө сөгдсөн хүүгийнхээ

Мэлмий нээдэг **эцэг уул**

(Х.Лхасүрэн, “Цагаан уулын гэгээ”)

....Бас ертөнцөд ойр хол хэрэн хэсэж ухаантай сайхан, баян тарган, хар шар олон эрчүүдтэй уулзаж явсан ч ажаатайгаа зүйрлэх хэн билээ. Эцэг гэгч **эцэг-уул аж**. (Д.Цоодол, “Ганцхан ажаатай хорвоо”)

гэх мэтээр уул хангайнхаа нөмөр нөөлөг, сүрдэм сүрлэг шинж байдлыг аавтайгаа адилтган магтаж, хүндэтгэн дээдэлсэн байна.,

...Халзан Бөхөнгийн

Сүлдэн уул минь


(Б.Лхагвасүрэн, “Монгол уул”)

(сүлдэн^{тодотгогч} ← уул минь^{тодотгуулагч})

Төрийн сүлд бол монголчуудад төр төвшин, түмэн амгалан байхын бэлгэдэл болдог. Тиймээс төрийн сүлдээ дээдлэн, сүслэн залбирдаг бөгөөд үндэстний энэхүү соёл сэтгэлгээний онцлог, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн шүтэн бишрэх өнгө аяс зэрэг нь уран сайхны эхийн найруулгад адилтгалт чимэг тодотголоор илэрчээ. “Эрхэм зүйл”-ийг “эрхэм зүйл”-тэй эн тэнцүүлэн адилтгаснаар, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бишрэн хүндэтгэсэн, бахархан дээдэлсэн өнгө аяс илэрч байна.

Үүнийг нэгтгэн харвал,

Загвар №8



1.3.2 Монгол уран сайхны эхэд дүрийн гадаад дотоод байдал шинж, түүнд өгсөн өгүүлэгчийн үнэлэмж нь уран дүрслэлийн хэрэглүүр адилтгалаар дамжин илэрч, тодотгогч-тодотгуулагчийн харьцааг илтгэж байдаг. Жишээ нь,

...**Бурхан хоёр буурлыгаа**

Зүдэрнэ чинээ санасангүй дээ, би

(Д.Алтангэрэл, “Бурхан бумбын орон”)

... Гэрийнхээ хоймрыг дүүрэн эзэлсэн

Гэгээн сэтгэлтэй **бурхан аав**

(Л.Гаваасүрэн, “Бурхан аав”)

...Уураг сүүгээ эвлэсэн их хайр

Уулга алдахдаа дууддаг **бурхан ээж**


(Д.Дашдондов, “Бурхан ээж”)

...Энэхэн биеийг минь өсгөх гэж сэтгэлээ чилээсэн

Элбэрэл хайрын **тэнгэр- эцэг минь**

(Ш.Дулмаа, “Хан уул шиг аав минь”)

хэмээн адилтган чимэглэж тодотгосон нь монгол зоны “шүтэн бишрэх, дээдлэн хүндлэх” сэтгэлгээний онцлогийн илрэл юм. Дүрслэлт чимэг тодотгол нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай бүхэлзүйжсэн нийлэмж үгээр “адилтгагч-адилтгуулагч” хоёр нь нийлж зэрэгцсэн байдлаар илэрсэн өвөрмөц бүтэцтэй байна.



Юмшуулж, амьтаншуулж адилтган тодотгосноор, өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрч байна.

Адилтгагдахуунаа үнэт зүйл хэмээн үздэг юмс үзэгдэлтэйгээ адилтган, чимэглэж, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн эрхэмлэн дээдэлсэн өнгө аясыг илэрхийлж ирсэн уламжлал байна. Тухайлбал,

... Хүмүүн бидний ганцхан өлгий

Хөрст *алтан дэлхий минь* ээ? (Ш.Дулмаа, “Эх дэлхий”)

...Эхийн хэвлийгээс хүйгээр тасарч унах нутаг, энэ орчлонгоос амь биеэр тасарч уусан шингэх амин хайртай *алтанхан газар шороо Миний Дэлүүн*.

...Зөв нь буруудаж, буруу нь зөвдөх болсон цөвүүн цаг дор хүмүүн бид аашаа арав хувиргавч ус гол эргэж буцахгүй нь үнэн. Түүн лүгээ түүх ч өөрөө ухрахгүй. Тиймийн учир ганц олдсон амьдралдаа ухаантай байгаач гэдгийг *газрын мөнгөн сувд хатан Туул маань* урсгал эгшгээрээ өгүүлнэм.

(С.Пүрэв, “Туулын шугуй хүрэлтэнэ”)

...Аяа

Алтанхан орчлонг хэн гийгүүлсэн юм бэ?

Агуу их хайр гийгүүлсэн (Ц.Бавуудорж, “Алтанхан орчлон”)

“алт”, “сувд”-ны үнэ цэнэтэй гэх утгатай газар шороо, байгаль ертөнц, ус голоо адилтган дээдэлсэн, чимэг тодотгол болжээ.

Юмшуулж, амьтаншуулж адилтган тодотгосноор, өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрч байна. Жишээ нь:

Хувь хүрээ огоот төгссөн залуу *саран охин чи*

Хун галууны явдлаар сэтгэлийн цөөрөмд хөвж

Хулс зэгсний найгалзах баясгалангийн цэцэрлэгийг мөшөөлгөж

Хурам агшнаа амаржуулан жаргаахын наадмаар цэнгэлд.

(Жамъянгарав)

...Хангайн *наран* хан **аав**

Сүргээ хариулсан нутаг

Халхын *саран гоо* **ээж минь**

Сүүгээ өргөсөн нутаг (Б.Түвшинжаргал, “Цэнхэр хангай нутаг”)

хэмээн эцэг хүний нөмөр нөөлөг, үр хүүхдээ гэсэн халуун дулаан сэтгэлийг хүн зонд илч дулаанаа хайрладаг “наран” -тай, ээж хүний өнгө гэрэлтэй үзэсгэлэн төгс төрх байдлыг “саран гоо” хэмээн адилтган магтаж өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн бол,

Тэгвэл, амьтаншуулж адилтгаснаар өгүүлэгчийн эерэг үнэлэмж хэрхэн илэрснийг дараах уран сайхны эхийн баримтаас харъя.

...Нар мандахдаа говиос, тэр тусмаа Дорнын цэнхэр говиос эхэлдэгт би дандаа итгэдэг. Манай говийн хүүхнүүд ихэвчлэн нар үнэртүүлсэн хонгор шаргал даахитай, *хонин бор нүд*тэй байдгийм. Би ч бас тэдний л адил.

(Г.Мөнхцэцэг, “Миний хатан булаг эх орноо манадаг”)

Учиртайхан тормойх *тогос нүд чинь*, Хандаа

Улаа бутарсан царайдаа нар шиг гэрэлтэнэ, Хандаа.

(Б.Явуухулан, “Хандаа”)

...Бөртөн бөртөн зэрэглээ хормойтой минь орооцолдож

Бүжин бор хөлийн минь сайрыг долоодог байсан.

(Б.Лхагвасүрэн, “Ингэн хөөс”)

...Ач хүү минь

Ангаахай жаахан **үр минь**

Сэвлэгээс чинь

Цээнэ, сүү хоёр үнэртэнэ.

...Эцгийнхээ балчирхан үеийг


Эгээ хэвээр нь хуулсан

Эрвээхэй жаахан ач минь (Ш.Дулмаа, "Эрвээхэй жаахан ач минь")

Уран сайхны эхийн баримтад буй "хонин бор-нүд" гэсэн адилтгал нь "номхон дөлгөөн" гэсэн үнэлэмжийг, "тогос-нүд" гэсэн адилтгалт чимэг тодотгол нь "гоё, сайхан" гэсэн үнэлэмжийг, "бүжин бор-хөл", "ангаахай-үр минь" "эрвээхий-ач минь" гэсэн адилтгалт чимэг тодотгол нь "жижигхэн хөөрхөн" гэсэн өхөөрдөл үнэлэмжийг агуулж байна.

Нэгтгэн загварчилж харвал,

Загвар№10



Үгийн урлагаар ялангуяа адилтгалт чимэг тодотголоор дамжин аливаа үндэстний соёл, сэтгэлгээнийх нь язгуур шинж хамгийн тод илэрч байна. Монгол уран сайхны эхэд адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмжийг илрүүлэх нь түгээмэл тохиолддог хэлбэр бөгөөд юуг юутай авцалдуулан холбож, адилсуулж үзэх нь зохиогч (өгүүлэгч)-ийн уран дүрслэлийн сонголтын онцлог төдийгүй монгол сэтгэлгээний мөн чанар, танин мэдэхүйтэй холбоотой юм.

1.4. Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

Зүйрлэл нь үгийн утга шилжүүлэх ёсны нэг хэлбэр, дүрслэлийн уран яруу хэрэглүүр юм.

Дандины "Зохист аялгууны толь"-д зүйрлэлийг "дүрст чимэг" гэж нэрлэн "Дүрслэх чимгийн утга хязгааргүй олон тул эс төгсөв" хэмээн өгүүлээд зөвхөн хорин хувилбарыг тодорхойлон жишээ болгожээ. "Зохист аялгууны толь" дахь зүйрлэл хүний дотоод сэтгэлд баясал төрүүлэх аргыг чухалчилсан эртний уламжлалт арга барил юм.

Эрдэмтэн Х.Гаадан: “Зүйрлэл нь уран санаагаар магтах юмныхаа сайныг гаргах найруулгын нэгэн арга бөгөөд зүйрлэлээр үе гишүүн, их бие, эрдэм үйлс, гэрэл тэргүүтнийг үзүүлжээ.” гэж дүгнэжээ.⁸³

Эрдэмтэн С.Дулам, Ц.Хасбаатар: “Зүйрлэл гэдэг бол нэг нийтлэг төстэй шинж бүхий хоёр юм үзэгдэл, ойлголтыг хооронд нь жишиж нэгний нь уран сайхны өвөрмөц шинжийг тодруулдаг дүрслэл бүхий хэллэг юм”⁸⁴

Эрдэмтэн Д.Галбаатар: “Зүйрлэл-metaphor” нь үгийн утга шилжүүлэх ёсны нэг хэлбэр, дүрслэлийн уран яруу хэрэглүүр юм. Нийтлэг төстэй шинж бүхий хоёр юм үзэгдэл, ойлголтыг хооронд нь жишиж нэгний нь уран сайхны онцлогийг ялгаруулан тодруулдаг дүрслэлийн аргыг зүйрлэл гэнэ.”⁸⁵

Эрдэмтэн Г.Галбаяр: “Дүр байдал, чанар, өнгө үзэмж зэргээрээ нэг нийтлэг шинж бүхий хоёр юм үзэгдэл, ойлголтыг хооронд нь жишиж нэгний нь уран сайхны өвөрмөц шинжийг тодруулдаг дүрслэл бүхий хэллэгийг зүйрлэл гэдэг. Жишээ нь:

Нарны илч шиг төөнөөд ирэхдээ дурлал

Гантиг ханыг ч бол нэвтлээд орно.

Нүүдлийн шувуу шиг буцаад явахдаа дурлал

Ган аргамжаас ч бол мултраад арилна.

(Б.Явуухулан, “Дөрвөн мөрт”) гэж нарны илч, нүүдлийн шувуутай ирж байгаа, буцаж байгаа дурлалыг зүйрлэн дүрсэлжээ.⁸⁶ хэмээн тус тус тодорхойлжээ.

Эрдэмтэн Д.Э.Розенталь, И.Б.Голуб нар: “Секрети стилистики” номдоо “Хоёр юм үзэгдэл ойлголтын төсөөтэй тал дээр үндэслэж шилжсэн утгаар хэрэглэгддэг дүрслэлийн аргыг зүйрлэл гэнэ.”⁸⁷ гэж уран яруу дүрслэн зохиох найруулгын ур маяг болох талаас нь ажиглан тодорхойлж иржээ.

Эрдэмтэн Ж.Баянсан: “Харилцаж байгаа хүн хийгээд өгүүлж байгаа юмандаа яаж хандаж байгаа харьцаа хандлага буюу өгүүлэгчийн үнэлэмж зүйрлэлд маш тодорхой илэрсэн байдаг. ... Монгол хүн эрүүл чийрэг хүнийг

⁸³Гаадан Х., Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл, Уб., 1986.69-р тал.

⁸⁴Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэртомъёоны тайлбар толь, Токио., 2002. 127-р тал.

⁸⁵Дулам С., Хасбаатар Ц., Утга зохиолын онолын үүд, Уб., 1980.150-р тал.

⁸⁶Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн лекц, Уб., 2002.92-р тал.

⁸⁷Розенталь Д.Э., Голуб И.Б., Секреты стилистики, Моск., 1999.с.401.

чулуу шиг биетэй хэмээн хэлэлцэх нь бий. Монголчуудын ертөнцийг танилтын эртний ул мөр болж, улмаар энэ зүйрлэлд уламжлагдан ирсэн биш байгаа гэж санагдана.”⁸⁸ гэж үндэстний сэтгэлгээний илэрхийлэл болох талаас нь тодотгон тайлбарласан байна.

Танихуйн хэлшинжлэлийн гол төлөөлөгч Ж.Лакоф танихуйн зүйрлэлийн тухай өгүүлэхдээ: “Зүйрлэл бидний эргэн тойронд энд тэндгүй байх бөгөөд зөвхөн хэлний үзэгдэл болоод зогсохгүй бидний ухамсар болон үйлдэлд ч байдаг. Ер нь бидний сэтгэдэг, аливаа үйлдэл хийдэг ухамсрын тогтолцоо зүйрлэлийн шинжтэй. Тиймээс бидний ухамсар, өдөр тутмын үйл ажиллагаа, амьдралын туршлага, биеэ авч явах байдал бүгд зүйрлэл дээр үндэслэдэг гэж болно. Харин хэл эдгээр зүйрлэх үзэгдлийг хэлний нэгжээр илэрхийлж байдаг. Нэг төрлийн юм үзэгдлийг өөр төрлийн юм үзэгдлийн нэртомъёогоор орлуулан ойлгож ухамсарлахад зүйрлэлийн мөн чанар оршино.”⁸⁹ гэжээ.

“Метафор нь хүний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгдэж байдаг төдийгүй яруу найраг, уран зохиолын төрөл зүйлд хүртэл арвин баялаг орсон байдаг бөгөөд Р.Якобсоны хэлснээр “Бүх үгэлбэр бол нэг бол метафорик нэг бол метонимик хэвшинжид хамаардаг байна.”⁹⁰

“Зүйрлэх үзэгдэл хүн ямар хэлээр хэлэлцэхээс үл хамаарах оюуны нийтлэг үзэгдэл мөн бөгөөд хүн бодот ертөнцийн юм үзэгдлийн өөр хоорондоо огт хамаагүй аль нэг юм, үзэгдэл, ухагдахууныг нөгөөтэй зүйрлэж амьдралын нэг салбарт хуримтлуулсан туршлага, мэдлэгээ нөгөө салбарт шилжүүлэн хэрэглэдэг. Зүйрлэх үзэгдэл аль ч хэлэнд ботод ертөнцийн юм үзэгдлийн адил төстэй шинж, талыг нь харьцуулах замаар ард түмний зарим тодорхой шинж эсвэл бүлэг шинж зүйрлэлд тусдаг. Хэлэлцэж буй хэлнээс үл хамааран хүн ерөөс хуучныг шинэтэй, мэдэхийг мэдэхгүйтэй жиших оюуны үйлдэл хийдэг нь хэл бүрт адилтгал, зүйрлэл үүсэх механик үйлдэл адил байгаагаас харагддаг. Гэхдээ энэхүү үйлдэлд ард түмний танин мэдэхүйн үйл ажиллагаа, амьдралын туршлага, ёс заншил голлох үүрэгтэй.”⁹¹ гэжээ.

⁸⁸ Баянсан Ж., Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб.,2002.2-р тал.

⁸⁹ Лакофф Дж., Джонсон М.,Метафоры которыми мы живем,М.,1990.с.,387- 415.

⁹⁰ Ууганбаяр М.,Метоним, метафор хэмээх ойлголт ба эхийг унших ерөнхий загварын нэгэн жишээ, МУИС,МХСС, Монгол судлал,2007.115-р тал.

⁹¹ Нансалмаа Н.,Хэлшинжлэлийн судалгааны аргазүй,Уб.,2010.144-р тал.

Үүнээс үзэхэд, зүйрлэлт чимэг тодотголыг монгол ахуй, зан заншил, соёл сэтгэлгээ, танин мэдэхүйн өвөрмөц онцлог болон өгүүлэгчийн үнэлэмжийг тусгасан “хэлний нэгж” болох талаас нь судлах шаардлагатай байна.

1.4.1. Нүүдэлчин монголчуудын байгаль ертөнцийг шүтэн бишрэх, сүслэн залбирах зан заншил, соёл сэтгэлгээ, байгаль ертөнцөд хандах хандлага зэрэг нь зүйрлэлт чимэг тодотголоор дамжин илэрдэг зүй тогтолтой байна.

Монголчууд унасан газар, угаасан ус, эх орноо “өндөр заяаллын **нутаг**”, “тэнгэрийн заяат **нутаг**”, “буянт дээдсээс өвлөсөн **нутаг**”, “аав ээжийн минь оршсон ашдын заяасан **нутаг**” хэмээн эрхэмлэн үздэг “нутаг амьтай” ард түмэн. “Буян заяа, хувь тохиол”-ыг дээдлэх монгол сэтгэлгээний энэхүү онцлог нь уран сайхны эхэд тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай зүйрлэлт тодотголоор дамжин илэрч байна. Тухайлбал,

Манай нутаг төв дундаа нэг их сайхан нууртай. Тэр бол дээр өгүүлдэг. Баянтөхөм, Төхөм тойроод нил хужир. Их хөндийн энгээр нил таана, баглуур, бударгана, дэрс. Тэр хавьд чоно, нохой ч байхгүй. Тэмээний диваажин л гэж, диваажин шиг гэж **тийм газар орон** байдаг байх.

(Д.Цоодол, “Шар тэмээний нутаг”)

...Зүүдэнд л зөвхөн үзэгддэг “Алтан Бумбын орон” шиг^{тодотгогч}

Зүйргүй сайхан **эх орон минь ээ**^{тодотгуулагч}

Зүгээр ч суухын завдалгүй байгалийн хишиг өгөөжтэй

Зүрх халиун намарт чинь би дуртай яа.

(Ч.Дамдиндорж, “Уянга хайлах намар”)

Бумбын орон шиг^{тодотгогч} **нутгаа**^{тодотгуулагч} би

Зүүдэлнэ чинээ бодсонгүй дээ хө.

(Д.Алтангэрэл, “Бурхан Бумбын орон”)

...Цармын өндөртөө цастай байдаг

Цайдам хөндийдөө цэцэгтэй байдаг

Адуу малын тэнэгэр бэлчээртэй

Ариун мөрдийн оргилуун ундаргатай

Эргэх улиралд өвс ус тэгш

Энхжингийн орон^{тодотгогч} -цэнхэр номин **хангай**^{тодотгуулагч}.

(А.Самбалхүндэв, “Номин хангай”)

...Үлгэрийн юм шиг тансагхан^{тодотгогч} энэ нутаг^{тодотгуулагч}

Миний **эх орон** билээ. (Ш.Дулмаа, “Цэнхэр тэнгэрийн орон минь”)
хэмээн баян дэлгэр монгол нутгаа магтан өргөмжилж, зөвхөн үлгэр, туульд дүрслэгддэг хийгээд орчлон ертөнцөд огт байж боломгүй эгэлгүй сайхан “бурхан бумбын орон”, “диваажин”, “үлгэрийн ертөнц”-тэй зүйрлэн ашид мөнх оршихийн цогц утгыг бэлгэдэн гайхалтай сайхан урлажээ.

Монгол хүн газар дэлхий, уул ус, нутаг орноо, “эцэг эх”, “өвөг дээдэс”-тэйгээ зүйрлэж, эсвэл эцэг эх, өвөг дээдсээ “газар дэлхий”, “уул ус”, “нутаг орон” -тойгоо зүйрлэн жишиж, хүндэтгэн дээдэлдэг ухаарал сэтгэлгээтэй ард түмэн билээ. Иймээс газар дэлхий, уул усандаа хувь заяагаа даатган залбирч, унасан газар, угаасан ус гол минь өвөг дээдэс, эцэг эхийн хайр энэрлийг үзүүлдэг хэмээн сэтгэж, шүтэн биширдэг. Үүнийг дараах уран сайхны эхийн баримтаар тодруулъя.

Өвгөд шиг ханхайсан^{тодотгогч}

Уулсын чинь^{тодотгуулагч} үрчгэр бэлийг

Ноолж өслөө, эх орон минь... (Б.Лхагвасүрэн, “Өргөдөл”)

...Хүрэн жинст уул минь ёстой л, эр хүн шиг^{тодотгогч} уул^{тодотгуулагч} юм даа.
Танд омгорхол, ихэрхэл, нулимст цэцэн уярал, инээмсэглэл бүгд байнам.

(Д.Нямаа, “Хүрэн жинст уул минь”)

...Говь нутаг минь. Эжий зөнтэй^{тодотгогч} говь нутаг минь.^{тодотгуулагч} Ариусах гэж бага насаа дурсан санах гэж толгодын дунд зогсму,би.

(Б.Баттулга, “Толгодын энгэр дэх чулуун гэр”)

...Эхийн сүү шиг^{тодотгогч} мөрөн голоо^{тодотгуулагч} урсгаж байдаг

Монгол орон минь. (Ц.Уламбаяр, “Монгол орон”)

...Ижий болсон^{тодотгогч} цэнхэр нуураа^{тодотгуулагч}

Эргэж гурвантаа ганганах ч байсан юм бил үү ...

(Б.Лхагвасүрэн, “Намрын нуур руу чулуу юунд шидлээ”)

...Ижийн сэтгэл шиг нялх^{тодотгогч}

Үрийн зулай шиг энхрий^{тодотгогч}

Ингэн буйлаат төгрөгийн

Ай, Бурхан төрөхийн их тал^{тодотгуулагч} ...

(П.Бадарч, “Ботгон төгрөгийн тал”)

...Эртний хүн чулуу надад эрин зууны үлгэр хүүрнэж, *домгийн эцэг шиг ханхар*^{тодотгогч} **уулс минь**^{тодотгуулагч} таанын сэвшээндээ хөлчүүрхэн, өөрсдөө энх мөнхийн туульс хайлах нь юутай жаргалтай.

(С.Пүрэв, “Аниргүйн цэнхэр аяз”) гэх мэт.

1.4.2 Уран сайхны эхийн найруулгад зүйрлэлт чимэг тодотголоор аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэл, тэдгээрт өгсөн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлж байна. Тодруулбал, уран сайхны дүрийн гадаад болон дотоод мөн чанар, байдал шинжийн зүйрлэлт чимэг тодотголд монгол ахуй, соёл сэтгэлгээ, өгүүлэгчийн эерэг үнэлэмж шингэсэн байдаг. Үүнд,

- “Аав”-ын нөмөр нөөлөг, өвөр дулаан, өмөг түшиг, сүр сүлд, уужим ухаан зэрэг шинж байдлыг “уул, хайрхан”-тай, “эх”-ийн уян зөөлөн сэтгэлийг “ус мөрөн, нуур далай”-тай зүйрлэн дүрсэлдэг байна.

Нар туссан хайрхан шиг^{тодотгогч} **настан буурлуудад**^{тодотгуулагч} айлтгах бэлгэдэл. (Т.Галсан, “Бэлгэ үг”)

...Урамгүйхэн сажлуулж гэртээ ирэхэд

Уул шиг^{тодотгогч} **аав минь**^{тодотгуулагч} дөрвөлж дээр суучихаад

Бэлчээр түйвээсэн овилгогүй... гэнгүүт нь

Би гэдэг...морьтой хөшөө... (Б.Лхагвасүрэн, “Багын шүлэг”)

Уртын дуугаараа нутгаа гоёсон

Уул шиг амгалан^{тодотгогч} **аав уу даа**^{тодотгуулагч}

(Ц.Батхишиг, “Амгалан аав”)

Баян далайн ус шиг

Бялхам сэтгэлт аав минь (П.Самбуу, “Аав даа”)

.. *Уст их нуур: нуур биш!* **Ээж минь** юм байна.

(Т.Галсан, “Хаврын мэдрэмж”)

гэх мэт “эрхэм зүйл”-ийг “эрхэм зүйл”-тэй эн тэнцүүлэн зүйрлэснээр, өгүүлэгчийн бишрэн хүндэтгэсэн, бахархан уяссан эерэг үнэлэмж нэн тодорхой илэрч байна.

Эрэгтэйтэй хүн, эмэгтэй хүн хоёрыг үзэх монгол сэтгэлгээний онцлогийг уран сайхны эхийн найруулга дахь зүйрлэлт чимэг тодотголын баримтад түшиглэн авч үзвэл дараах онцлогтой байна.

<p>Зүйрлэлт чимэг тодотгол-нийлэмж үг: <i>Бадамлянхуа цэцэг шиг</i> үзэсгэлэн төгс бүсгүй Баясгалант царайгаар намайг ширтэж байна. (М.Ширчинсүрэн, “Дурсан санахад”)</p>	<p>Зүйрлэлт чимэг тодотгол-үг: Эзэнгүй адуу ямар Эрхэс тэнгэрээс буувал гэж <i>Галтай цахиур шиг эр</i> Морьтой давхин ирэв ээ. (Дан.Нямаа, “Зууны сүүлчийн цас”)</p>
<p>Зүйрлэлт чимэг тодотгол-үг: Эмэгтэй гэдэг эрхэм нэртэй Энэ дэлхийн <i>сар шиг</i> хүүхнүүд минь (С.Оюун, “Хүүхнүүд минь”)</p>	<p>Зүйрлэлт чимэг тодотгол-үг: <i>Тал шиг уужим бодолтой</i> <i>Гал шиг дүрэлзсэн жавхаатай</i> Тэмүүлсэн хүслээр дүүрэн Тэр сайхан эрчүүл (Ш.Дулмаа, “Халхын сайхан эрчүүл”)</p>
<p>Зүйрлэлт чимэг тодотгол- нийлэмж үг: ...<i>Үдийн нар шиг</i> хонгор минь Үзэгдэж гийгүүлээд ирэвч Үйлтэй төрсөн би чинь Үүлний сүүдэрт үлдэж байна. (Ц.Дамдинсүрэн, “Үдийн нар шиг хонгор минь”)</p>	<p>Зүйрлэлт чимэг тодотгол-нийлэмж үг: <i>Хүр хад шиг</i> гаднаасаа аргил баргил атлаа Хүлэг уралдаад ирэхэд нүдэндээ нулимстай явах Хүйтэн халууныг даах сэтгэл минь хатан гэлээ ч Хүүгийнхээ зулайг үнэрлэхэд л хадаг мэт зөөлрөх Эр бид чинь тийм ч хатуу улс биш ээ (Д.Цоодол, “Жаргалтай дэлгэр орон”)</p>
<p>Зүйрлэлт чимэг тодотгол-өгүүлбэр: <i>Зүс нь хасын саран шиг</i> <i>Үс нь усны долгио шиг</i> <i>Үг нь хайрын дуу шиг</i> <i>Нүд нь үдшийн од шиг</i> } Үзэсгэлэнг нь үгээр хэлшгүй Орчлонг чимсэн бүсгүй (П.Бадарч, “Бүсгүй”)</p>	<p>Зүйрлэлт чимэг тодотгол-үг: <i>Халхын тал шиг тэнэгэр ухаантай</i> Суут хүү (Ц.Гайтав, “Дамдины Сүхбаатар”)</p>
<p>Зүйрлэлт чимэг тодотгол-цогцолбор: ...<i>Өнгө зүс нь солонго мэт сайхан</i> <i>Үйл бүтээхдээ шоргоолж мэт уран</i></p>	<p>Манай нутагт Сандаг гэдэг сайхан эр байлаа. <i>Дүнхийсэн магнайтай, ханхайсан цээжтэй, хангай шиг эр</i> юмсан. Амьтан ах дүүд тусч, ажил төрөлд гойд хүнсэн. (П.Бадарч, “Мундаг Сандаг”)</p>

<p>Үг хэл нь ерөөл мэт цэцэн Өтгөс буурлуудад Үр мэт зөөлөн</p> <p>Алтан Ганжуур хатан (Т.Галсан, “Монгол Жангар”)</p>	<p>Зүйрлэлт чимэг тодотгол-нийлэмж үг: Ханд авгай залуу насандаа эр нөхрөөсөө хагацаж хоёр хүүгий нь өсгөхийн тулд гэрт орвол эм, гадаа гарвал эр болж явжээ. Тэд нь өдөр түлхэн өндийж, <i>яргай даргай шиг эрчүүд</i> болов. (Д.Норов, “Мөнхийн дуудлага”)</p>
<p>....Болсон тошлог шиг ягаан хацартай, цог шиг гялалзсан хар нүдтэй, жавхалзсан хүүхэн. ...Шар хул морин дээр хормой тавшуургадан, жавхайтал суугаад, морины толгой хаялах тоолонд нарийхан бэлхүүсээрээ ганхасхийн байсан нь сэтгэлд зурагдан үлджээ. (Д.Норов, “Хөх сайрын чулуу”)</p>	

Дээр зэрэгцүүлэн товчоолсноос үзвэл манай зохиолч, найрагчид “бүсгүй” хүний гоо сайхныг үзэн баясах, сэтгэл татагдан догдлох торгон мэдрэмжийг илэрхийлэхдээ “наран”, “саран”, “солонго”, “сарнай”, “цэцэг” хэмээн од эрхэс, ургамлын сайхантай зүйрлэн, магтаж эерэг үнэлэмжийг илэрхийлдэг бол “эр” хүнийг “хүр хад”, “ган жад”, “гал дөл”, “алх дөш”, “тал шиг”, “хангай шиг”, “галтай цахиур”, “яргай даргай” шиг хатан зоригтой, хийморь жавхаатай, хүдэр чийрэг, холч ухаантай гэдэг талаас нь зүйрлэн жишиж, бахдан сайшааж ирсэн уламжлал байна.

Түүнчлэн “эрэгтэй”, “эмэгтэй” хүнийг амьтны сайхантай зүйрлэхдээ:

<p>Уулын <i>согоо шиг</i> хүүхэнд Хайрын сэтгэл дасна. (Б.Явуухулан, “Туулын шугуй”)</p>	<p>Уулын бүргэд <i>шиг хийморьтой</i>, хаданд дүүлэх <i>янгир шиг сэргэлэн цогтой залуу</i> санагдлаа. (С.Пүрэв, Нүүдэл суудал”)</p>
<p>Саатан зогсох нь <i>согоо сайхан</i> Санаа сэтгэл чинь үүлгүй тэнгэр Сайхан царай чинь өнгө тунамал Хатан Өзлүний алтан ураг Хайрын дэнлүү монгол бүсгүй (П.Бадарч, “Сайхан монгол бүсгүй”)</p>	<p>...Баатар биет, <i>барс зоригт</i> мянга мянган эрс энэ газар шороо, эх орон хэмээх аугаа их ертөнцийнхөө төлөө бурхан ч бүтээшгүй гавьяаг байгуулсан байхад өнөөдөр бид цагаан магтаал хайлан, цан хэнгэрэгээ түмэнтээ дэлдээд ч яах юм билээ. (С.Пүрэв, “Дөрвөн бар тохиосон өдөр”)</p>

хэмээн “эр” хүний хүч тэнхээ, баатар сүрийг “арслан”, “бар”, “бүргэд”-тэй харин “эмэгтэй” хүний уран гоолиг төрх байдлыг “согоо” сайхан хэмээн зүйрлэн жишиж, үнэлж цэгнэж иржээ.

Монгол хүний “үр хүүхдэд”-ээ гэх сэтгэлийн илрэл, элбэрэл хайрын мөн чанар нь зүйрлэлт чимэг тодотголоор илэрдэг. Жишээлбэл,

“...*Дунжаагийн сэтгэлийг дэвтээж, орчлонг уужим болгодог гэрэлт нар болсон*^{тодотгогч} **хүү нь**^{тодотгуулагч} алив гай түйтгэрт өртөлгүй арван нас хүрчээ. Эх хүү хоёр бие биеэ энхрийлэн хайрлах нь туйлгүй...”

(Д.Намсрай, “Буяны нүгэл”)

...*Аавдаа алт болсон*^{тодотгогч}

Ээждээ сувд болсон^{тодотгогч}

Энхрий булбарай бие нь^{тодотгуулагч}

Эсэн мэндээр хүмүүжиг (Ц.Дамдинсүрэн, “Хоёр настай Ро”)

...Ээжийн ганц

Эрдэнэ болсон^{тодотгогч} **үр минь**^{тодотгуулагч}

(Т.Галсан, “Монгол Жангар”)

Ийнхүү үр хүүхдээ хүн зонд илч дулааныг хайрладаг гэрэлт “наран”-тай, эсвэл үнэ цэнэтэй ховор “эрдэнэ”-тэй зүйрлэдэг нь монгол соёл сэтгэлгээний нэгэн онцлог бөгөөд зүйрлэлт чимэг тодотголоор дамжин өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн өхөөрдөн энхрийлсэн өнгө аяс илэрчээ.

Монгол уран сайхны эхийн найруулгад дүрийн дотоод мөн чанар буюу санаа сэтгэл, зан байдлын онцлогийг нээн гаргасан зүйрлэлт чимэг тодотгол нь малчин монгол ахуй, аж амьдралаас үүдсэн, монгол жишиг хэмжүүрийн илрэл болж байдаг. Жишээ нь,

...Гүдэсхэн шударга дөлгөөн зантай

Гөрмөл бугуйл шиг^{тодотгогч} миний л **аав уу даа**^{тодотгуулагч}

(Ш.Батхишиг, “Амгалан аав”)

...*Тэмээнийхээ нүд шиг*^{тодотгогч} **дөлгөөхөн** хар **нүдтэй**^{тодотгуулагч} монгол хүн хичнээн төлөв энгийн зантай, цагаан сэтгэлтэй, тэгээд хүнийг зочлохын төлөө төрсөн юм шиг байдаг гэж санана аа. (Ж.Бямба, “Хүний сайхан сэтгэл”)

... Алсын аян, замын шороо, хурц наранд борлосон энэ эмэгтэйн царайд алжаалын тэмдэг тодорхой авч, *эхийнхээ дууг сонссон ботгоны нүд шиг*

тормолзсон^{тодотгогч} болор хар **нүдэнд нь**^{тодотгуулагч} залуугийн гал, хөдөө талын бүсгүйн гоо жавхлан тодорхой ажээ.

(Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”)

Дээрх эхийн баримтаас харахад, “гөрмөл бугуйл шиг”-“тэсвэр тэвчээртэй, шулуун шударга”, “тэмээний нүд шиг”-“номхон дөлгөөн”, “ботгоны нүд шиг”-“сэргэлэн цовоо” зан төлөвийг тус тус дүрслэн гаргахын зэрэгцээ, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн хүндэтгэн бахархсан, хайрлан энхрийлсэн өнгө аясыг илтгэжээ.

Байгаль ертөнц хийгээд хүн, юмс үзэгдэлд өгсөн өгүүлэгчийн үнэлэмж, монгол ахуй, монгол сэтгэлгээний өвөрмөц онцлог нь зүйрлэлт чимэг тодотголоор илэрдэг. Үүнийг нотлох баримт жишээ цөөнгүй тохиолдож байна. Жишээ нь,

...Наранд ааруул шиг тос дааварлах^{тодотгогч}

Намхан бор **толгод**^{тодотгуулагч}

(Д.Цэнджав, “Нутгийн минь намхан толгод”)

гэж зүйрлэн чимэглэж, эх нутгийнхаа өгөөж хишигтэй, нүнжиг буянтай шинж байдлыг тодотгон дүрсэлж,

...Ижий аавын ээнэгшиж дассан нутаг сан

Илүүрийн ул шиг дандаа бүлээн^{тодотгуулагч} **тоонот сон**^{тодотгуулагч} ...

(Л.Мөнхтөр, “Ижий шаргал говь”) хэмээн

зүйрлэн чимэглэж, эх нутгийнхаа өвөр дулаан, нөмөр нөөлөг шинж байдлыг тодотгон дүрсэлж, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан дээдэлсэн өнгө аясыг илтгэжээ. Дээрх эхийн хэсэгт буй “илүүрийн ул шиг дандаа бүлээн”, “ааруул шиг тос дааварлах” гэсэн зүйрлэлт чимэг тодотгол өгүүлбэр нь монгол ахуй, монгол аж төрөх ёсны өвөрмөц онцлогоос үүдэлтэй бөгөөд эх нутгийнхаа сэтгэл татам өвөрмөц шинжийг тодотгон магтсан дүрслэх ур маяг юм. Дорнын их яруу найрагч Б. Явуухулан “Би хаана төрөө вэ” шүлгийн

...Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө, би.

Зүйдэлгүй цагаан өрхийн хоймсолж томсон оосорт

Зүрхэн улаан галтай ган тулгын тотгонд


Зуун түмэн үед монгол түмний идээшсэн

Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө, би. хэмээсэн дүрслэлт чимэг тодотголуудад (чимэг, адилтгал, зүйрлэл) үндэстний их бахархал,

өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн омогшил бардамнал гүн шингэсэн байдаг билээ.

Нэгтгэн загварчилвал,

Загвар №11



Дээрх жишээнүүдийн чимэг тодотголыг ажиглахад:

1. Монгол уран сайхны эхийн найруулгад зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн эрхэмлэн нандигнасан, омогшин бахархсан, сайшаан магтсан, уяран баяссан өнгө аясыг илэрхийлнэ.
2. Монгол уран сайхны эхийн найруулгад “зүйрлэлт чимэг тодотгол” нь урнаар дүрслэх ур маяг болохоос гадна үндэстний танин мэдэхүй ба сэтгэлгээний онцлогийг илтгэх үүрэгтэй “хэлний нэгж” юм.
3. Уран сайхны зүйрлэлт чимэг тодотголууд нь хэл талаасаа буюу хэлбэр – хэлзүйн бүтцийн талаасаа:

- а. “зүйрлэлт чимэг тодотгол, дан нэр”+“тодотгуулагч (нэр үг)”
- б. “зүйрлэлт чимэг тодотгол, нэрийн холбоо”+“тодотгуулагч (нэр үг)”
- в. “зүйрлэлт чимэг тодотгол, өгүүлбэр”+“тодотгуулагч (нэр үг)”
- г. “зүйрлэлт чимэг тодотгол, цогцолбор”+“тодотгуулагч (нэр үг) гэсэн

бүтэц загвартай байна.

1.5. Амьдчилалт (хүншүүлэлт) чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

Юуны өмнө, амьдчилал (одушевление- personification)-ын тухай уран зохиол судлалд хэрхэн авч үзэж буй талаар товч дурдъя.

Эрдэмтэн Д.Галбаатар: “Юмшуулал, хүншүүлэл гэх зэргээр нэрлэх нь бий. Хүн ба юмсад байдаг шинжүүдийг өөр бодис юмсад шилжүүлэн амьтай мэтээр бичих аргыг амьдчилал гэнэ.”⁹² гэж тэмдэглэсэн бол,

Эрдэмтэн Ш.Гаадамба: “Амьд юманд байгаа шинж чанарыг төстэй байдлаар нь амьгүй бодист шилжүүлэн аваачиж дүрслэх уран дүрслэлийн хэрэглүүрийг амьшуулал (одушевление) гэнэ.”⁹³ хэмээн тодорхойлжээ.

Ийнхүү амьдчилал бол уран зохиолд уран дүр дүрслэл бүтээх арга хэрэглүүр болох талаасаа манай судлаачдын анхаарлыг татаж байсан. Харин, түүнийг өгүүлэгчийн үнэлэмж, хүний танин мэдэхүй, сэтгэлгээний хөгжлийн явцын үр дүн болох талаас нь шинжилсэн судалгаа одоо хир үгүй байна. Амьдчилал нь дүрслэх ур маягийн үүрэгтэй, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлсэн “хэлний нэгж” болж байдаг онцлогтой.

1.5.1 Монгол уран сайхны эхэд байгаль ертөнц, хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл, тэдгээрт өгсөн эерэг үнэлэмж амьдчилал бүхий чимэг тодотголоор илэрдэг. Хүнээс байгальтай харьцах харилцааны явцад байгаль бидэнд гоо сайхны мэдрэмж таашаалыг төрүүлдэг бөгөөд байгалийн үзэгдлийн амьдчилал, хүншүүлээс өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн олон янз өнгө аяс илэрч байна. Тухайлбал,

Догшин ноён хутагт Данзанравжаа “Галбын магтаал” шүлэгтээ:

Эелдэг цасан тэргүүнтэй

Элдэв цэцгийн цамцтай

Эрээн зүлгэн хормойтой

Эрдэм төгс орон бий гэж нутаг орныхоо уул ус, ургамал байгалийн сүр жавхлан, өнгө үзэмжийг машид урнаар дүрсэлсэн бол, энэхүү уран дүрслэлийг манай ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэн “Монгол нутаг” шүлэгтээ бүтээлчээр баяжуулан авахдаа:

⁹²Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэртомъёоны тайлбар толь,Токио.,2002.
16-р тал.

⁹³Гаадамба Ш., Утга зохиолын онолын үндэс, Уб.,1989.137-р тал.

Цагаан цасан малгайтай

Ногоон модон хүрэмтэй

Хөх усан хормойтой

Баян хангай уул минь гэжээ.” хэмээн профессор Л.Хүрэлбаатар “Огторгуйн цагаан гарьд-1” (147-р тал) бүтээлдээ дурджээ. Энд байгалийн өнгө үзэмжийг урнаар дүрслэхийн зэрэгцээ өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн шүтэн бишрэх өнгө аясыг илтгэжээ.

...Үндэс хөрсөө хөрвөөн тулгатай гал шилгээж

Үүдэн хоймор хөндөөгүй номхон^{тодотгогч} буурал тал минь^{тодотгуулагч}

(Д.Цэнджав, “Малахын тал”)

...Өлмийд минь өөхийгөө дэвссэн^{тодотгогч} их тал^{тодотгуулагч} явах тусам уужран, гэнэт өмнө минь эр бараан унага цахилан гараад ирлээ, бурхан минь!

(С.Пүрэв, “Тал”)

гэж тал нутаг нь хүн зон олондоо хайр энэрлийг үзүүлж, ээлтэй, өмөг түшигтэй байдаг хэмээн ухаарч, амьдчилан магтахын зэрэгцээ,

... Нар нартай чулууд нь

Дуулгын дүрсэнд тоглосон^{тодотгогч}

Намар намрын өвс нь

Нумын дүрсэнд тоглосон^{тодотгогч}

Монголын их хээр тал^{тодотгуулагч}

(Б.Лхагвасүрэн, “Монголын их хээр тал”)

хэмээн тал нутгийнхаа гоо сайхныг чимэглэн тодотгож, бахархан өгүүлжээ.

...Буурал эртний домог мөнхөд оршсон хаяа захгүй говьдоо ширээ хүрэн тэмээд тэнгэрээ өргөн тэшилдэж, цагаан зээрийн сүрэг цахилж нэг байж дэгдэх нь Дулаан Богд уул өөрөө хол замын биднийг дагаад ачаалах нь уу гэлтэй их говийнхоо энгэрээр өндөлзөнө.^{тодотгогч} Ийм л^{тодосгогч} сайхан өгөөмөр^{тодотгогч} амгалан^{тодотгогч} нутаг^{тодотгуулагч} даа.

(С.Пүрэв, “Дулаан Богд Дулаан”)

...Ай хөөрхий, өвчүүн дээрээ тоглуулж өсгөсөн^{тодотгогч} өлгий их нутаг минь^{тодотгуулагч} өмнө зүгт байдаг аа. Хатан булагт минь хавар аль хэдийн ирчихсэн шинийн нэгний өглөө сумаа тойроод мөрөө гаргах шинэ хүний тоо нэмэгдэж л байгаа даа.

(Г.Мөнхцэцэг, “Миний Хатанбулаг эх орноо манадаг”)

гэх мэт хүнд байдаг сайхан зан чанарыг илэрхийлсэн утгатай тэмдэг үгсээр сав ертөнцийн зүйл (нутаг, уул, тал)-ыг амьдчилан чимэглэж тодотгосноор, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн өөриймсөж дотноссон, эрхэмлэн дээдэлсэн өнгө аясыг илэрхийлсэн уран дүрслэл болжээ.

...Гэгээ гэгээн дундаас

Гэрэлтэн харагддаг *омголон*^{тодотгогч} **уул**^{тодотгуулагч}

Гэгээнтэн олон бурхдаас

Гэрэвшиж эмээдэггүй *амгалан*^{тодотгогч} **уул**^{тодотгуулагч} ...

(Х.Лхасүрэн, “Цагаан уулын гэгээ”)

гэж уул хангайнхаа сүрлэг сайхан шинж байдлыг,

...*Галуун дуунаар уйлсан*^{тодотгогч}

Намхан намхан **уулс минь ээ**^{тодотгуулагч}

(Б.Лхагвасүрэн, “Өвгөдийн нутаг”)

гэж эх нутгийнх нь уул толгод нь өрөвч, уян зөөлөн санагддагийг,

Салаа замын холд ч оргил нь харагдах хайрхан

Сайны ерөөл талбиж, хүсэл тэтгэсэн **уул**. (Б.Энхтуяа, “Монгол уул”)

(*сайны ерөөл талбиж, хүсэл тэтгэсэн*^{тодотгогч} ← **уул**^{тодотгуулагч}) гэж уул хангайнхаа өмөг түшигтэй шинж байдлыг “амьдчилалт чимэг тодотгол өгүүлбэр”-ээр дүрслэн илэрхийлж, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн хүндэтгэн дээдэлсэн өнгө аясыг илтгэжээ.

....*Үүрийн таван жингээр*

Сараа саатуулж мөнгөрсөн^{тодотгогч}

Үдшийн бүрий тасартал

Нараа наадуулж алтарсан^{тодотгогч}

Зулай цагаан **Алтайгаа**,^{тодотгуулагч}

Зүүдэлж сэрдэг нь юуных вэ? (З.Гүнсэн, “Зулай цагаан Алтай”)

...*Униарт хөх ногоон тал дээр мөнгөн угалз мэтгэсэн* танил **нуга, тохойг** харж суулаа.... Удахгүй ингээд сална. Хэзээ буцаж ирэхийг бүү мэд шүү дээ, Хэрлэн сайхан мөрөн минь. Нялхынхаа сэвлэг үсийг төрсөн нутаг **Хэрлэндээ, ээждээ** үлдээе. (С.Эрдэнэ, “Хэрлэнгийн охин”)

...*Цэнхэр дууны зэрэглээнд*

Зэрэглээ нь лугшсан^{тодотгогч}

Амьд говь^{тодотгуулагч}

(Б.Лхагвасүрэн, “Говь”)

Янагийн сайхан харц шиг

Яргуй нүдлэн мишээж^{тодотгогч}

Ханшийн ногоо нярайлсан^{тодотгогч}

Хаврын **тал**^{тодотгуулагч} нялхарна.

(Д.Пүрэвдорж, “Дөрвөн цагийн тал”) гэсэн амьдчилалт чимэг тодотголоор уул ус, нутаг орныхоо байгалийн сайхныг дүрслэн, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан, бахархан дээдэлсэн өнгө аясыг илтгэжээ. Дараах уран сайхны эхэд,

Эхийн харцаар мишээсэн^{тодотгогч}

Эрдэнэсийн **наранд**^{тодотгуулагч} бид дуртай

(Т.Насанбуян, “Гэгээн наран”)

Шижир туяа цацруулан мишээсэн^{тодотгогч}

Шингэх **наран**^{тодотгуулагч} юутай гоёхон бэ.

(Ш.Шажинбат, “Цэнгэлтэй үдэш”)

хэмээн амьдчилан (хүншүүлэн) тодотгосон нь хүн зонд илч гэрлийг бэлэглэгч “нар”-ыг үзэн баясаж, бишрэн магтах сэтгэгдлээ илэрхийлсэн уран дүрслэл болжээ.

Монгол хүн чулууг дээдэлж, эрдэнийн чулуун хөөрөг зөрүүлж, амар мэндээ мэдэлцэж, алмааз, хаш, оюу, номин, шүр, сувд, тана, мана тэргүүт эрдэнийн чулуугаар гоёж чимж, чулууны хатан чанар, эрдэм увдисаар төрийн хар хүний эрх ямба, зэрэг дэвийг ялган дэсэлж, эрдэнийн очир чулуун одонгоор чулуу мэт хатан зориг, бие сэтгэлийн бөх бат, тэсвэр тэвчээр үзүүлсэн хатан зоригтны байгуулсан гавьяа, бүтээсэн үйл, баатарласан явдлыг соёрхон шагнаж, бас эрдэнийн чулууны эд шид, эрдэм чадлаар элдэв муу эмгэг өвчнийг анагааж ирснийг үзэхэд чулууны утга учир үлэмж олон талтай ажээ.

Манай ард түмний соёл, сэтгэлгээний энэхүү онцлог нь уран сайхны эхийн найруулга дахь чимэг тодотголоор дамжин илэрч байна.

...Хангал морьдын туурайн дор ёолоогүй

Халил өндрийн үүлэн дунд унтаагүй

Хаврын цэцэг нөмөрт нь ургахад хатуурхаагүй

Харанхуй цасан шуурга, цас бороонд зөөлрөөгүй

Хээрийн нар, салхи ууж насалсан

Жирийн саарал **чулуу**^{тодотгуулагч} галтай байдаг аа.

(Д.Банзрагч, “Галтай чулуу”)

гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь зэрэгцсэн олон чимэг тодотгол өгүүлбэрээр,

Болжмор олж суувал

Жавар хайлмаар

Бор цэцэгс элбэвэл

Нулимс унагамаар

Цацлын сүү дусвал

Цангаа нь гармаар

Хүний нутгаас наахнаа

Хөдөлшгүй зогсох ёстой^{тодотгогч} **хилийн чулуу**^{тодотгуулагч}

(До. Цэнджав, “Хилийн чулуу”)

... Өвөөг өөд болоход захисны нь дагуу чулуут энгэрт нутаглуулж, дэлэм хэртэй мөөш толгойд нь заллаа. Нутгийн чулуу нь цас бороотой халтартан уйлж, өвөөгийн минь шарил дээр билүүн нулимс дусаадаг юм. Өвөө минь “өөрийгөө элээж, бусдыг ирлэсээр дуусдаг”^{тодотгогч} **Өнжүүлийн цэнхэр билүү**^{тодотгуулагч} шиг үгүйлэгдэхгүй мөртлөө барагдахгүй тустай эгэл нэгэн хорвоо байж дээ.

(Ж. Лхагва, “Билүүний дууль”)

...Сараар илбүүлээд дуулаагүй

Салхиар зодуулаад уйлаагүй ч

Нулимс унаган намайг зүүдэлдэг

Нутгийн минь **чулуу**, хөөрхий.

(Б.Догмид, “Нутгийн чулуу”)

чимэг тодотгол нийлмэл өгүүлбэрээр,

...Салхинд алгадуулж хал суусан

Наранд цонуулж хага үсэрсэн

Зуун янзын араншинтай

Зуун өөр хол ойрын **чулуу**

Зуун өөр хал хайрын **чулуу** (Б.Лхагвасүрэн, “Зуун голын чулуу”)

чимэг тодотгол нийлэмжээр ийнхүү чулууг амьдчилж, хүншүүлэн чимэглэн тодотгож, чулууг алдаршуулан магтаж, хүн байгалийн харилцан шүтэлцээг чулуугаар илэрхийлж, чулууны эрдэм чадлыг хүн хүндээ танин мэдүүлж

ирсэн нь чулууны тухай домог зүйн сэтгэлгээ, төрж өссөн нутгаа хайрлан хамгаалах, шүтэн дээдлэх үзэл болон өргөжсөнийх билээ.

Түүнчлэн сэр сэр хийсэн салхитай бур бур хийсэн хуртай Бумбын сайхан орныг үлгэр туульсдаа дүрсэлж, дөрвөн зүг найман зовхисын агаар-салхийг шүтэн, таван зүйлийн мал сүргээ адгуулан маллаж ирсэн монголчуудын хувьд “салхи” хийгээд “салхилах”-ыг тун олон янзаар шинжиж, утга соёлын зүйлдээ тун өвөрмөцөөр дүрсэлж, эрдэм ухааныг уламжилж иржээ. Тухайлбал, Лувсандондов хэмээх халхын шүлэгч бээр, ...Зөвхөн салхины хэдэн янз өнгийг гаргахдаа “Нарийн гайхамшигт салхин хавар нь бадарч байхад, “Сэнслэгт сэрүүн салхин” намар нь хөдөлж, “Сэрүүн тэгш салхин” өвөл нь дэгдэж, хаварт нь “Найртай амьсгал дэлгэрч байхад”, өвөлд нь “Сэргэлэн амьсгал түгээд”...гэх мэтээр нэг санаанаас нөгөөг холбон, “Уул усны магтаал”-ууддаа дүрсэлсэн байдаг гэж профессор Л.Хүрэлбаатар “Огторгуйн цагаан гарьд-I” бүтээлдээ (233-р тал) дурджээ. Тэгвэл, орчин цагийн утга зохиолд, салхийг зулай илж таалах зун цагийн зөөлөн сэвшээ гэж, намар цагийн намираа хонгор салхи гэж, өвөл цагийн сахал цантам жавар салхин гэж, хавар цагийн гүйгүүл цэнхэр салхи гэж ялган хэлэлцэж ирсэн байдаг.

Монгол улсын ардын уран зохиолч Д. Пүрэвдорж,

Суусрын гүйдэл **салхин**

Шанхаар илбэн наадахад ...гэж,

дорнын их яруу найрагч Б.Явуухулан,

Туулайн гүйдэл шиг **салхинд**

Туулын шугуй найгана...гэж, яруу найрагч Нацагийн Даваадаш,

Хөл нүцгэн **салхи**

Үнэгэн шогшоо зайдлаад

Хөдөө хөх цайдам

Ингэн буйлаанд санаа алдана... гэж,яруу найрагч Ч.Содномдорж,

Эмнэг цэнхэр **салхинд**

Эрхэлж исгэрч өслөө дөө.

Энгүүн Сутайн сэвшээ нь


Иссэн айргийн амттай даа.

гэх мэтээр салхины хөдөлгөөн, амьдрал араншинг тун гярхай ажиглаж, давтагдашгүй уран санаагаар хэлсэн нь дөрвөн улирлын амьдралтай, тал нутгийн нүүдэлчдийн өвөрмөц үнэлэмжийн илэрхийлэл юм.

Манай зохиолч найрагчид салхийг “Монголын үнэртэй **салхи**” (Ш.Гүрбазар), “Өнө холын дуртхалын сэжүүр дэрвүүлэх пансан цэнхэр **салхи**” (Б.Лхагвасүрэн), “Сэвшээ хонгор **салхи**” (Д.Отгонсүрэн) хэмээн чимэглэн тодотгож магтахын сацуу “Шогшоо бор **салхин** бут бутанд бүдэчсээр, шоргоолж шиг чимээгүй, тэр л хавьдаа нойрсов”. (Э.Хархүү), “Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён **салхи** гунигтайяа хэсүүчилж, нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн, эрин зуунд илгээнэ.” (Д.Намсрай), “Отгонтэнгэрийн цэцэгсийн сайхан үнэрийг Дорнодын талд хонь хариулж яваа бүсгүйд хүргэгч гүйгүүл цэнхэр **салхин**...” ...(Т.Галсан) гэх мэтээр утга шилжүүлэн нэрлэж, монгол бэлгэдэх ёсны хүрээнд амьдчилан чимэглэж тодотгосон зэрэг нь салхи шинжээч тал нутгийн монгол хүний сэтгэлгээ, монгол үнэлэмж болон үлдсэн байна.

Нэгтгэн харвал,

Загвар №12



Дээрх жишээнүүдийн чимэг тодотголыг ажиглахад:

1. Монгол уран сайхны эхийн найруулгад “амьдчилалт чимэг тодотгол нь урнаар дүрслэх ур маяг болохоос гадна өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илтгэх үүрэгтэй байна.
2. Хэлэхүй, хэрэглээ, утга талаас харвал:
Байдал, чанар, шинжийн утгатай дүрслэлт чимэг тодотголоор эх нутгийнхаа өвөрмөц сайхан байгалийг магтан дуулахын сацуу өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн уяран баяссан, хүндэтгэн дээдэлсэн, өөриймсөж дотноссон өнгө аясыг илэрхийлж байна.
3. Монгол уран сайхны эхийн найруулгад амьдчилалт чимэг тодотголоор дамжин үндэстний соёл, сэтгэлгээний онцлог илэрнэ.

1.6. Хэтрүүлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмж илэрсэн нь

Ихэсгэл (hyperbole) ба багасгал (litetotes) нь уран хэтрүүллийн эсрэгцсэн хос арга юм. Уран зохиол судлалд “ихэсгэл-hyperbole” –ийг дүрслэх ур маяг хэмээн үзэж, дараах байдлаар тодорхойлж иржээ.

Дандины “Зохист аялгууны толь”-д ихэсгэлийг “гайхамшгийн чимэг” гэж нэрлэсэн байдаг. “Уран дүрслэлийн ихэсгэлийн арга бол энэ зохиолын гайхамшгийн чимэгт гардаг юм. Ингэхдээ дөрвөн аргаар харуулдаг жамтай билээ.

1. Тэрхүү сайшаагдах юм нь орчлонгийн ямар ч зүйлээс хэтэрсэн давуу сайхан байх
2. Түүний хэтэрхий байдалд эргэлзэхгүй байх
3. Хэтэрсэн сайхан нь илэрхий нотлогдохуйц байх
4. Гайхмаар, хачирхмаар, сайхан байдалтай байх ёстой гэж дөрвөн зүйл заадаг”⁹⁴ хэмээн тайлбарласан бол,

Эрдэмтэн Ш.Гаадамба: “Уран зохиолд юмын онцлог тал, чанар шинжийг гойд товойлгох зорилгоор үнэн байдалд байдгаас нь хэт их болгох чиглэлээр үгийг утга шилжүүлэн хэрэглэхийг ихэсгэл гэнэ.”⁹⁵

Эрдэмтэн С.Дулам, Ц.Хасбаатар нар: “Яруу сайхны сэтгэгдэл төрүүлэхийн үүднээс юм үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж төрхийг уран сайхнаар ихэсгэн дүрслэхийг хэтрүүлэл гэнэ.”⁹⁶

Эрдэмтэн Д.Галбаатар: “Уран сайхны дүр, дүрслэгдэхүүний яруу сайхныг нээх зорилгоор юмс, үзэгдлийн шинж төрх, байр байдлыг байгаагаас ихэсгэн томруулж, хүч нэмэгдүүлэн сүрлэг болгож дүрслэх арга юм.”⁹⁷

Эрдэмтэн Ц.Сүхбаатар: “Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос нь хэт ихэсгэн давуулсан буюу бууруулсан найруулгын ур маягийг хэлнэ. Хэтрүүллийг бодит бололцооны талаас нь авч үзэхэд, биелэгдэх нь эргэлзээтэй буюу биелэгдэх бололцоогүй байдалтай

⁹⁴ Гаадан Х., Зохист аялгуун толин дахь адилтгал зүйрлэл, Уб., 1986. 15-16-р тал.

⁹⁵ Гаадамба Ш., Утга зохиолын онолын үндэс, Уб., 1989. 130-р тал.

⁹⁶ Дулам С., Хасбаатар Ц., Уран зохиолын онолын үүд, Уб., 1980. 157-р тал.

⁹⁷ Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэртөмъёоны тайлбар толь, Токио. 2002. 16-р тал.

байна. Үүнийг оновчтой хэрэглэснээр дүрслэл уран яруу болж, хүчтэй сэтгэгдэл төрүүлнэ.

Арван зургаатай агай Шавдалыг

Авч ирсэн нь ямар дүрээр байна вэ гэвэл:

Цаашаа харахад нь

Цаад далайн жараахай тоологдом

Наашаа харахад нь

Наад далайн жараахай тоологдом

Цуснаас улаан хацартай

Цаснаас цагаан санчигтай

“Жангар”

Зэлмийн шимж асгасан цус, тэдний суусан орчны газрыг намаг болгожээ.

“Монголын нууц товчоо”⁹⁸

Эрдэмтэн Г.Галбаяр: “Яруу сайхны сэтгэгдэл төрүүлэхийн үүднээс юмс үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж төрхийг уран сайхнаар хэтрүүлэн давуулж дүрслэхийг ихэсгэл гэнэ.”⁹⁹ хэмээн тус тус тодорхойлжээ.

Ийнхүү ихэсгэлийг уран зохиолд уран дүр дүрслэл бүтээх арга хэрэглүүр, дүрслэх ур маяг болох талаас нь голлон судалж иржээ. Харин өгүүлэгчийн үнэлэмж, хүний танин мэдэхүйн үр дүн, үндэстний соёл, сэтгэлгээний илэрхийлэл болох талаас нь шинжилсэн судалгаа одоо хир үгүй байна.

1.6.1 Монгол уран сайхны эхийн жишээ баримтаас ажиглахад, ихэсгэл (хэтрүүлэл) бүхий чимэг тодотголоор уран сайхны дүр дүрслэлийг тодруулахын зэрэгцээ өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлж байна. Тодруулбал, тухайн дүр буюу үйлдэгчийн гадаад болон дотоод мөн чанар, шинжийг тодотгон, гайхан биширч, хачирхмаар сэтгэгдэл төрүүлэхээр өвөрмөц чимэг тодотгол туульсын зохиолын хэл найруулгаас уламжилжээ. Тухайлбал,

...Наашаа харахад

Наад далайн жараахайг тоолом

Цаашаа харахад

Цаад далайн жараахайг тоолом

⁹⁸ Сүхбаатар Ц., Монгол хэлний найруулгазүй, УБ., 2007.322 -р тал.

⁹⁹ Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн лекц, УБ., 2002.94-р тал.

Цаснаас цагаан царайтай

Цуснаас улаан хацартай

Зэгснээс туяхан биетэй

Зэгзгэр дагина байдаг гэнэ. (Т.Галсан, "Монгол Жангар")

гэх зэргээр хатдын өнгө үзэсгэлэн, гоо сайхныг ихэд сайшаан магтсан, уран сэтгэмжийн дүр дүрслэл, хийсвэрлэл ихтэй дэлгэрэнгүй зэрэгцсэн чимэг тодотгол өгүүлбэрээр өгүүлэгчийн эерэг үнэлэмж тодорч байдаг бол,

...Дал эгэм хоёрт нь

Далан арслангийн ид

Бүрэн шинжтэй

Эгэм дал хоёрт нь

Ерэн есөн ирвэсийн тэнхээ

Бүрдсэн хэвтэй

Бараан хөх **баатар** ...**Жангар**

...Тавлаад суухаараа

Тавин хоёр хүний зайд суудаг

Тахийгаад суухаараа

Хорин таван хүний зайд суудаг

Гүзээн Гүмбэ баатар

(Т.Галсан, "Монгол Жангар") гэх

зэргээр баатрын хүдэр чийрэг бие бялдар, бяр хүч, зориг самбаа, эрдэм чадал зэрэг нь орчлонгийн хамаг зүйлээс илүү давуу хэмээн чимэглэн тодотгосноор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан, гайхан биширсэн өнгө аяс илэрчээ. Эрчүүд нь тулаанч, баатарлаг байх нь нүүдэлчдийн сайхны ойлголтын гол төсөөлөл байсан бөгөөд хүчирхэг, эр бяр төгс, зүрх зоригтой, том биетэй, эрдэм чадал агуу, онцгой чадвартай байх нь гол үнэлэмж болж байжээ.

Тэгвэл, Монголын орчин үеийн уран зохиол дахь ихэсгэл бүхий чимэг тодотголын жишээ баримтаас авч үзье.

Уургаа тулаад адуундаа мордохдоо

Уулсаа халхалсан^{тодотгогч} ханхар **аав**^{тодотгуулагч}

(Л.Гаваасүрэн, "Аав")

Энд “ихэсгэл бүхий чимэг тодотгол өгүүлбэр” нь “хүдэр чийрэг” гэсэн утгатай бөгөөд өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан хүндэтгэсэн өнгө аясыг илэрхийлсэн байхад,

...Хөх тэнгэр өргөн

Тооноон мөрлөсөн^{тодотгогч} **эр хүн**^{тодотгуулагч} (Ш.Дулмаа, “Эр хүн”)

Ихэсгэл бүхий чимэг тодотгол өгүүлбэр нь “өрх гэрийн ноён нуруу, түшиг тулгуур” гэсэн утгатай бөгөөд өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бахархан хүндэтгэсэн өнгө аяс илтгэж байна.

Үзвэл, нас хорин гурав дөрөв хир, *нүүртээ цогтой, нүдэндээ галтай*,^{тодотгогч} шавхийсэн **хар хүү**^{тодотгуулагч} байна.

(Д.Нацагдорж, “Үзэгдээгүй юм”)

“сэргэлэн цовоо” гэсэн утга бүхий ихэсгэл бүхий чимэг тодотгол нийлэмжээр өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан өнгө аясыг гаргасан бол, Нэг эмгэн ганц хүүхэнтэй юмсанжээ. Хүүхэн нь *цаснаас цагаан царайтай, уснаас хар нүдтэй* сайхан **хүүхэн** байжээ. (Ц.Дамдинсүрэн, “Эмгэн”)

Хасын царайд нь туяа татаад

Хайрын талимаанд нь Туул мяралзаад

Алхсан газраас нь сарнай дэлгэрмээр

Аашийн сайханд нь саран гэрэлтмээр

Бүсгүйчүүл, бүсгүйчүүл

(Ш.Сүрэнжав, “Бүсгүйчүүл”)

...Наашаа хараад инээхээр нь намар дуусч байтлаа хавар болчихов уу даа энэ чинь гэж хүмүүс гайхам,^{тодотгогч} *цаашаа хараад инээхээр нь цас орж байтлаа цэцэг дэлгэрчихэв үү дээ гэж хүмүүс эргэлзэм*,^{тодотгогч} *тийм цацарсан, дулаахан гэрэлтэй*^{тодотгогч} сайхан **бүсгүй**^{тодотгуулагч} ... (Л.Өлзийтөгс, “Сохор”) “бүсгүй” хүний гоо сайхныг бишрэн магтсан утгатай “ихэсгэл бүхий чимэг тодотгол цогцолбор”-оор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан, гайхан биширсэн өнгө аясыг илтгэжээ.

1.6.2 Багасгал (litetotes) грек хэлний энгийн жижиг гэсэн үгнээс гаралтай дүрслэлийн уран яруу хэрэглүүр. Уран зохиолын онолын бүтээлүүдэд “багасгал”-ыг хэрхэн тодорхойлж ирснийг товч авч үзвэл,

Эрдэмтэн Д.Галбаатарын тодорхойлсноор: "Яруу сайхан сэтгэгдэл төрүүлэх үүднээс юм үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдал, төрхийг байгаа байдлаас нь уран сайхны аргаар багасган жижигрүүлж дүрслэх аргыг багасгал гэнэ. Багасгал нь хэтрүүллийн нэг хэлбэр болно"¹⁰⁰

Эрдэмтэн Г.Галбаяр: "Багасгал нь ихэсгэлийн эсрэг юмс үзэгдэл, үйл явдлын шинж байдлыг ихэсгэн хэтрүүлэх биш, багасган хэтрүүлсэн уран сайхны дүрслэлийн арга хэрэглүүр юм."¹⁰¹ хэмээн тус тус тодорхойлжээ.

Уран зохиол судлалд багасгалыг уран дүр дүрслэл бүтээх арга хэрэглүүр, дүрслэх ур маяг хэмээн тодорхойлж ирсэн байна. Багасгал нь уран дүр дүрслэл бүтээх ур маяг бөгөөд өгүүлэгчийн үнэлэмж, үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илэрхийлэх "хэлний нэгж" юм.

Тухайлбал,

...- Аан гэж хүү нь дуугарна.

Ангир ижийн хөх эвэлнэ.

Хуруун чинээ^{тодотгогч} үрийн нь^{тодотгуулагч}

Хонхны дуу үл тасарна. (Б.Лхагвасүрэн, "Уянгын тойрог")

...Тохойн чинээ^{тодотгогч} биетэй^{тодотгуулагч}

Ханцуйн чинээ^{тодотгогч} дээлтэй^{тодотгуулагч}

Бээлийн чинээ^{тодотгогч} малгайтай^{тодотгуулагч}

Балчир нялх дүүгийн минь^{тодотгуулагч}...

(Ц.Дамдинсүрэн, "Хоёр настай Ро")

Эрхийн чинээ^{тодотгогч} алаг хөөрхөн үр юугаан^{тодотгуулагч}

Элэг зүрхэндээ наадууланхан тэвэрч

Энэ ертөнцийн жаргал тийш тэмүүлэгч

Эхийг хайрлах уянгын бадаг төрдөөг!

(Д.Пүрэвдорж, "Эхийн тухай сэтгэгдэл")

Тохойн чинээ^{тодотгогч} үрийнхээ^{тодотгуулагч} шөнийн уйлахыг сонсож

Төрсөн эцгийндээ авчирсан зовлон баяр хоёрыг

Тоо ёсоор нь амсаж өөрөө мэдэх гэсэн юм, би.

(Б.Явуухулан, "Алаг дэлхийд төрсөн минь учиртай")


¹⁰⁰Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэртомъёоны тайлбар толь, Токио., 2002. 137-р тал.

¹⁰¹Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн лекц, Уб., 2002.95-р тал.

...Охины нас бага, хувцас муу, ажил их болж, хүйтэн халуунд нүднийхээ нулимсыг өдөр бүр цувруулж, *шагайн чинээ*^{тодотгогч} бор *гараараа*^{тодотгуулагч} нүдээ нухалж явна. (Ц.Дамдинсүрэн, “Гологдсон хүүхэн”)

Эргэж харвал, *тохойн чинээ*^{тодотгогч} **жаал охин**^{тодотгуулагч} *болжморын даль шиг*^{тодотгогч} *бяцхан алган дээрээ*^{тодотгуулагч} шороо тоосыг нь арилгаж амжаагүй хэдэн цахиур тавьжээ. Өвгөний өнөөх гомдол бухимдал дорхноо сарниж, настай хүнд баймгүй адуун цагаан шүдээ яралзуулан инээж... (Д.Төрбат, “Могойн чуулган”) гэх мэтээр багасган, адилтган чимэглэсэн нь үр хүүхдээ энэрэх хайрлах сэтгэлийн илэрхийлэл, өхөөрдөн энхрийлсэн өнгө аяс юм.

Монгол уран сайхны эхийн найруулгад хэтрүүлэлт чимэг тодотгол нь урнаар дүрслэх ур маяг болохоос гадна өгүүлэгчийн эерэг үнэлэмж, үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илтгэх үүргээр орно.



Дэд бүлэг: Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь (Монгол уран сайхны эхийн жишээн дээр)

2.1. Үнэлэмж, сөрөг үнэлэмжийн тухайд

Ер нь аливаа юм үзэгдэл олон талтай, олон янзын шинж байдалтай байж, түүнийг аль талаас нь авч үзсэнээс шалтгаалан эерэг, сөрөг үнэлэмжтэй болдог нь танин мэдэхүйн зүй тогтолт үзэгдэл юм.

“Сөрөг үнэлэмж”-ийн тухайд хэлшинжлэлийн бүтээлүүдэд хэрхэн тодорхойлж ирснийг авч үзвэл:

Эрдэмтэн П.Бямбасан: “-Дуу/-дүү/, -втор/-втэр,-втор/ нь үгсийн хоорондын харьцаа, орон цагийн харьцаа заахгүй, тухайн тэмдэг нэрээр илэрч байгаа шинж тэмдгийг өгүүлэгч этгээд тийм ч хангалттай бус гэж үзэж байгааг илэрхийлсэн утгын нэмэлт өнгийг оруулдаг байна. -Дуу/-дүү/, -втор /-втэр,-втор/ морфемоор илэрч байгаа утгын өнгө нь өгүүлэгч этгээдийн хэлний хэрэгцээнд өртөж байгаа тухайн шинж чанарыг агуулсан юмын шинж тэмдгийн хэр хэмжээг өгүүлэгч этгээд хэрхэн үзэж байгааг харуулж байна. Энэ нь өгүүлэгч этгээд бодот байдалд хандаж байгаа хандлага харьцаа юм”.¹⁰²

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир: “Монгол хэлний энэхүү -хан, -хэн, -хон, -хөн бүтээврийн байр, утга, үүрэг, хэрэглээг ажиглахад тэмдэг нэр+хан⁴, дүрслэх ба дуурайх үг+хан⁴, жинхэнэ нэр+хан⁴, хам нөхцөл үйл+хан⁴, тооны нэр+хан⁴, орон цагийн нэр+хан⁴,...гэсэн байрлалтай, гол төлөв хэлэх өгүүлэхүйн түвшинд үг ба өгүүлбэрийн утгыг эрчимжүүлсэн, багасгасан, өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөний эерэг үнэлэмжийг илтгэн, хайрлан өхөөрдсөн, бахархан дотночилсон, сөрөг үнэлэмжийг илтгэн чамласан, хязгаарласан зэрэг өнгө аясыг илтгэдэг зүй тогтолтой нь ажиглагдав.”¹⁰³ хэмээн тус тус тайлбарлажээ.

Эрдэмтэн Ж.Баянсан: “Аливаа хүн ертөнцийн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг таньж мэдэх болгондоо түүнд ямар нэг үнэлэмж өгдөг нь зайлшгүй юм. Энэ үнэлэмж нь эерэг сөрөг гэсэн ерөнхий хоёр талтай байх

¹⁰²Бямбасан П.,Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг,УБ.,1975.69-р тал.

¹⁰³Пүрэв-Очир Б.,Үг,өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ, УБ.,2011.63-р тал.

боловч эерэг сөрөг тал бүр нь дотроо ашигтай-ашиггүй, зохистой-зохисгүй, таатай-таагүй гэх зэрэг дэд эсрэгцэлтэй байх болно.”¹⁰⁴

Эрдэмтэн О.С.Ахманова: “Үнэлэмж (оценка-evaluation) нь өгүүлэгчийн бодол эргэцүүлэл, түүнийг сайшаан зөвших ба үл сайшаан, үл ойшоосон үзэл, хандлага” гэж тодорхойлжээ.”¹⁰⁵

Эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан: “Өгүүлэмжийн агуулга нь тухайн өгүүлэгчийн сэтгэлд тааламжгүй, зохисгүй шинжтэй байгааг энэхүү хэв маягийн баймж утга илэрхийлнэ. Өгүүлэгчийн сөрөг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утгыг үүрэг-утгазүй, хэрэглээний талаас нь доорх байдлаар ялган ангилж болно.”¹⁰⁶ гээд гуниглах утга, татгалзах утга, тавлах утга, зэмлэн муушаах утга, хараах утга, үзэн ядах утга хэмээн ангилжээ.

“Үнэлэмж”, “сөрөг үнэлэмж”-ийн тухай ойлголтыг уран найруулгын тодотголын утгатай холбон судалсан нь ховор байна.

Хүн хүрээлэн буй юмс үзэгдэл, үйл явдлын мөн чанар, холбоо харьцааг тусган авахдаа тэдгээрт дотоод хандлагаа илэрхийлж, үүнтэй хамт хувь хүний үнэлэмж илэрч байдаг.

Байгаль, нийгэм, хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл, хүн ба юмст өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмжийн олон янз өнгө аяс нь дүрслэлт чимэг тодотголоор илэрдэг гэж үзэж болно.

Монгол уран сайхны эхийн найруулга дахь дүрслэх ур маяг бүхий чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрснийг дараах байдлаар ангилан авч үзэж байна.

- Чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь
- Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь
- Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь
- Амьдчилалт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

¹⁰⁴ Баянсан Ж., Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002. 45-р тал.

¹⁰⁵ Ахманова О.С., Словарь лингвистических терминов, М., 1966. с. 305.

¹⁰⁶ Мөнх-Амгалан Ю., Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб., 1998. 228-238-р тал.

2.2. Чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

Ямарваа өгүүлбэр, цогцолбор эхийн найруулгад янз бүрийн тодотголыг хэрэглэх, түүний онцлог, утга үүрэг нь эх зохиогчийн бичих туурвих туршлага, бодот байдлыг мэдрэх мэдрэмж, тухайн эхийн өгүүлэмжийн шугам, эхийн утгын, хэлбэрийн мэдээллийн бүтэц, эх сэдвийн хэвшинж зэргээс үлэмж шалтгаалдаг. Ялангуяа янз бүрийн утга, бүтэцтэй дүрслэлт чимэг тодотголыг хэрэглэх нь уран сайхны тэр тусмаа хүүрнэмж ба эргэцүүлэмж эх, түүний нэгдмэл цогц чанартай онцгой хамааралтай юм.

Түүнчлэн утга судлалын талаасаа, эх бичвэрт ямар үг, ямар үгтэй холбогдож, тодотгогч-тодотгуулагч харьцаанд орох нь хэлний ба хэлний бус орчин, хам нөхцөл, өгүүлэгчийн үнэлэмж, дотоод яриа, дүрслэх ба яруу хэрэглүүрийг хэрхэн ашиглах аргатай холбоотой. Тухайлбал, уран сайхны чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илэрхийлэх онцлог, уламжлал нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийг илэрхийлэх онцлог, уламжлалаас арай өөр байна. Монгол уран сайхны эхийн баримтаас харахад, тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор илрэх өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг:

- Хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүдэд өгсөн өгүүлэгчийн үнэлэмж
- Аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэлд өгсөн өгүүлэгчийн үнэлэмж гэж бүлэглэн авч үзэх боломжтой байна.

2.2.1 Монгол уран сайхны эхэд хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанар, тэдгээрийн цаг хугацаа-орон зайн дотор орших хувьсал, өөрчлөлт зэрэгт өгүүлэгчээс өгч байгаа сөрөг үнэлэмж нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай чимэг тодотголоор дамжин, монгол хэлний шаталсан тогтолцоот нэгж тус бүрээр илэрдэг зүй тогтолтой байна.

Тухайлж, бидний судалгаанд авсан ихэвчлэн эрэгцүүлэмж ба хүүрнэмж эхийн доторх тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд, түүнд өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмж илэрхийлсэн байдлыг ажваас, дараах хэд хэдэн хэвшинжийн утга, үүрэг бүхий чимэг тодотгол байна гэж товчоолон үзэж болмоор санагдана. Үүнд,

➤ Сөрөг үнэлэмжийн харуусан гунигласан өнгө аястай чимэг тодотгол

Өрөм хутгасан намрын тараг шиг

Өег нармай сэтгэлээ бялхам заравч, үр хоосон

Өлзий харам, *шаналант бор*^{тодотгогч} **өдрүүд**^{тодотгуулагч} ..

(Д.Урианхай, “Эгэл бор өдрүүд”)

Галбингаа шувууны өндөг

Хальсан дотроо донгоддог юм гэсэн

Гаслантай^{тодотгогч} **хорвоогийнхны**^{тодотгуулагч} үйлийг

Гайхаж алмайртал дуулдаг юм гэсэн...

(Ч.Дагвадорж, “Зуу хоног ч ургаагүй цэцэг минь”)

...*Уйтан*^{тодотгогч} **амьдралд**^{тодотгуулагч} өвдөх гэж гэж ирж буйд чинь эмгэнэе.

(О.Дашбалбар, “Төрж буй хүнд эмгэнэл илэрхийлсэн шүлэг”)

...Ямархан *хатуу*^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч} билээ дээ. Хямран тэмцсээр, алалдан тулахыг хэн ч зогсоож чадсангүй. Өнөөх л итгэл сүжгийн хүчээр олныг эрхшээлээ гэсэн шашин бурхан ч тус болсонгүй. ...Ай, юутай хуурамч хорвоо билээ.

(С.Эрдэнэ, “Занабазар”)

...Дайраад гардаг зовлон

Санаанд аргадаг

Сүүдэртэй

Ирэх буцахын **хорвоо**...

(Г.Уянга, “Ижий”)

...Зүдэг **орчлонгийн** дундуур тэнүүчилсээр байнам.

Зүүдэн сэрүүний завсар энэлсээр байнам.

(С.Дулам, “Хэдэн муу шүлэг”)

Дээрх уран сайхны эхүүдэд “шаналант, гаслантай, хатуу, сүүдэртэй, зүдэг” гэсэн шинж байдлыг заасан утгатай үгүүдийг өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн чимэг тодотголын үүргээр ашигласан байна.

Яруу найрагч Б.Ичинхорлоо “Эх нутаг” шүлэгтээ: “тэс хөлдүү-модод, зовлонт-эх нутаг, элэгдмэл-саран, хувхай-мөчир, хилэгнэл харууслын-дуу” гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай чимэг тодотголуудаар тухайн нийгэм, цаг үеийн зөрчилт байдлыг дүрслэн илэрхийлсэн байдаг.

Тэс хөлдүү моддын нөмөрт

Даль хумин болжмор чичирч

Зовлонт эх нутгийн тухай

Золгүй шүлэгч гиюүрэн дуулна.

... Хуучин танил шиг элэгдмэл саран

Хувхай мөчирт гэрлээ унагаж

Хилээнэл харууслын дуу

Хэрээ мэт айсуй.

(Б.Ичинхорлоо, “Эх нутаг”)

Энэ дүрслэлд өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн гуниглан харууссан өнгө аяс илэрчээ.

➤ Сөрөг үнэлэмжийн жигшин, зэвүүцсэн өнгө аястай чимэг тодотгол
Шулмын^{тодотгогч} энэ хорвоог^{тодотгуулагч} шуурч яваад туулна, би.

(О.Дашбалбар, “Төрж буй хүнд эмгэнэл илэрхийлсэн шүлэг”)

...Өргөст цэвдэг замбуулин дахь

Өдрийн одон чамайгаа гэсээр...

(Р.Чойном, “Амрагтаа бичих захиа”)

...Ай, Хишгээ ямар азгүй билээ. Төрсөн ганц үрийнхээ өмнө, хадам ээж, эр нөхөр, аав, хойт ээжийнхээ өмнө ямар их ичгүүрт унана вэ. Аяа, эх хүн гэгч хэвлийдээ байгаа үрийг үзэн ядах гэж байх уу даа. Түүний оронд энэ нүгэлт^{тодотгогч} амьдралыг, ^{тодотгуулагч} үхээрийн хар ^{тодотгогч} дайныг^{тодотгуулагч} зүхэлтэй.

(Д.Норов, “Мөнхийн дуудлага”) гэх мэт.

Чивэлт^{тодотгогч} хорвоод^{тодотгуулагч} хүн хүнтэйгээ

Муудах яасан ч дуртай юм бэ дээ.

Чинжүү хольсон усаар зайлсан юм шиг

Үг нь яасан ч шорвог юм бэ дээ.

(Ш.Сүрэнжав, “Хүн хүнийхээ мууд дуртай юм уу даа”)

(А,Б) бүлэглэлд авч үзэж байгаа хэдэн зүйл чимэг тодотголыг ажиглахад, хэл талаасаа “тэмдэг үг+нэр үг” (хорвоо) гэсэн загвар бүхий чанар шинжийн утгатай тодотголууд байна. Хэлэхүй ба хэрэглээ талаас харвал “гаслантай, сүүдэртэй, уйтан, шулмын, нүгэлт, өргөст, цэвдэг, хуурамч, хатуу” гэх мэт сөрөг байдалтай үнэлэмж илэрхийлсэн чанар шинжийн утгатай чимэг үгээр тодотгон найруулснаар хүний амьдралын үй түмэн үзэгдэл, хэрэг явдлын мөн чанарыг таньж мэдсэний үр дүнд илэрч буй өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг тодруулжээ.

Монгол уран сайхны эхэд тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд, түүнд өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмжийг илэрхийлэхдээ,

Амрагласны эцэст дайсан бологч

Албин хэнээт^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч} ...

Ханилсны эцэст салалцах

Хавьгүй гоомой^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч} ...

(Д.Равжаа, “Багшаа шүтэхийг сургасан сургаал”)

Гуйл цухуйсан^{тодотгогч} **хорвоо дээр**^{тодотгуулагч}

Гуйж буугаагүй юмсан. (С.Дулам, “Ирээдүйн тухай гуниг”)

Аврал харам^{тодотгогч} **хорвоод**^{тодотгуулагч} зориуд газардсаных

Алга дарам газарч бол, хамаагүй

Жаргалын үр зууж л газардана даа.

(Д.Урианхай, “Цээжин орноо урихуй”)

Эдгээр жишээний чимэг тодотгол нь “сүнс нь зайлсан, албин хэнээт, хавьгүй гоомой, харалган сохор, аврал харам” гэх мэт хэлц нэгж, нийлмэл бүтэцтэйгээр илэрч, хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанарт өгүүлэгч этгээдээс өгч байгаа сөрөг үнэлэмжийн харууссан, шүүмжилсэн өнгө аясыг илэрхийлж байгаа бол,

Үзлийн муу өрнөсөн^{тодотгогч} ийм **хачин цагт**^{тодотгуулагч}

Үнэн шударга өгүүлэгч хүн цагаан хэрээ

Үнэн ариун явдалтан нь муушаалын орон

Аяа, маш уйтгартай орон юм аа.

(Д.Равжаа, “Арга башрын цогц”)

Гэмийн далай дэлбэрсэн^{тодотгогч}

Гэрэлгүй балай **эдүгээ цагт**^{тодотгуулагч}

...Өөрсдийн явдлаа үзэхэд

Үнэн голоос уйтгарлана. (Д.Равжаа, “Ахуй байдлаа гашуудсан нь”)

хэмээн өгүүлэгч, тухайн цаг үеийн хүнд хэцүү, зөрчилт байдлыг “үзлийн муу өрнөсөн-цаг”, “хөнөөх аюул хөмөрсөн-ахуй цаг”, “гэмийн далай дэлбэрсэн-эдүгээ цагт” гэх зэргээр тодотготгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг

тодотгол өгүүлбэрээр дүрслэн, сөрөг үнэлэмжийн шүүмжилсэн өнгө аясыг гаргажээ.

Үүний зэрэгцээ “өнгөт орчлон, өгөөмөр ертөнц, бүүвэйн дуутай орчлон”-гийн хүний амьдралд басхүү “муу-муухай, уйтгар-гунигтай, хагацал-зовлонтой” түмэн янзын хэрэг явдал тохиолдож, тэр нь аливаа хүнд цөхрөл хийгээд бухимдал төрүүлж байдгийг:

Туршин туршин бусдын гэмийг отогч^{тодотгогч}

Туйлбаргүй атаагаар ертөгч^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч}

(Д.Равжаа, “Ертөнц авгайн жам хэмээх оршвой”)

...Сүжрээд сүжрээд барамгүй^{тодотгогч}

Сүүмэлзсэнхэн **хорвоо**^{тодотгуулагч}

Сүслээд сүслээд нэмэргүй^{тодотгогч}

Хуурамчхан **хорвоо!**^{тодотгуулагч}

...Сохор зоосонд үйсэн^{тодотгогч}

Солиотой ч **орчлон**^{тодотгуулагч} юм уу даа

(Ш.Дулмаа, “Монголын эмгэнэл”)

...Адгийн “өмхий хөвөл” өвс хүртэл

Арав хориороо бүүрлэж ургадаг^{тодотгогч}

Амьдралын^{тодотгуулагч} ёс тийм аж.

(Р.Чойном, “Инээдэг хүмүүс”)

...Өндөр модон дээр шаазгай шагширна. Сайхан шагшрахад үнэн худал юуны хамаатай. Угаасаа үнэн гэж байхгүй болсон^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч}.

(С.Пүрэв, “Өндөр модон дээр шаазгай шагширна”)

Үхэх төрөхийн хооронд хагацал зовлон салдаггүй^{тодотгогч} **хорвоод**^{тодотгуулагч}

бид төрсөн биш үү?

(С.Эрдэнэ, “Нарангарвуу”)

Хүний нүүр ч бүтэн харж болохгүй ...Аятайхан хэд алхах аргагүй, яасан заяа нь хаячихсан^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч} вэ? Сэтгэлд дандаа муу хүн бодогдож,чихэнд дандаа хараал хэрүүл сонстоно.

(З.Дорж, “Эрдэнэ засгийн унага”)

гэж өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илтгэсэн чимэг тодотгол өгүүлбэрээр,

Гуйлгачин нь гуйлгачиндаа эрэлхэх

Гуталтай нь гуталгүйдээ дээрэлхэх

Гурав иддэг нь хоёр иддэгтээ ихэрхэх^{тодотгогч}

Гунигтайхан ч **хорвоо**^{тодотгуулагч} **бол доо.**

(С.Дулам, "Гунигтайхан ч хорвоо")

Наран саран гэтэл

Сүүдэрт орж хиртдэг

Навч цэцэг гэтэл

Хяруунд норж хөлддөг

Ховч шаазгай шагширч

Хэрээнд тал засдаг^{тодотгогч}


*Амаргүйхэн **орчлонд***^{тодотгуулагч}

Амьдарч явна даа, би.

(Ш.Сүрэнжав, "Амаргүйхэн орчлон")

хэмээн сөрөг үнэлэмж бүхий чимэг тодотгол цогцолбороор өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн цөхрөн харууссан, зэвүүцэн шүүмжилсэн өнгө аясыг илэрхийлжээ.

(1. мэдэгдэхүүн, 2. хэлэгдэхүүн, 3. хэлэхүүн, 4. мэдэхүүн) Загвар№14



Эрдэмтэн С.Дулам: "Хар өнгө" бол монгол утга соёлд домог зүй, бөө мөргөлийн зүүн зүгийн дөчин дөрвөн тэнгэрийн өнгө зүс, түүнтэй холбоотой муу үйлийн өнгө болох учир буй. Хэдийвээр "харыг" эерүүлэн "бараан" хэмээх хүндэтгэл буй боловч "хар бараан" хэмээх хослол нь бүхэлдээ ертөнцийн нэгэн үзэгдэл-гэрэл гэгээний ерөндөг, харанхуйн төлөөлөл болж буудаг. Энэ нь эн тэргүүнээ байгалийн сүр хүчний гарцаагүй илэрхийлэл, ертөнцийн

мөхөл сүйрэл, түүний ёр тэмдэг болдог”¹⁰⁷ хэмээн дүгнэжээ. Тэгвэл, монгол уран сайхны эхийн найруулгад тодотгогч-тодотгуулагч харьцаатай дүрслэлт чимэг тодотголд “хар” хэмээх чимэг үг нь хүч нэмэгдүүлсэн чимэг тодотголын үүргээр орж, өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн олон янз өнгө аясыг илэрхийлж байна. Тухайлбал,

Баймгай хар^{тодотгогч} **хорвоод нь**^{тодотгуулагч}, хөөрхий

Байдаг бүгд худал шиг

Байзнас гээд бодохноо

Өөрийн бие ч хуурмаг шиг (Д. Урианхай, “Гунихуйн гэгээ”)

...Ховст бараан^{тодотгогч} **хорвоод**^{тодотгуулагч}

Хоногийн зовлон тасрахгүй л

Хойшоо, урагшаа саравчлаад

Гэр дотор харанхуй л...

(Д. Урианхай, “Шанхын уулнаа намрын өдөр гуниглахуй”)

Эргийн мухар, ангалын ёроол руу

Эргээд гарахааргүй унах шиг

Итгэл гашлам хар^{тодотгогч} **өдрүүд**^{тодотгуулагч}

Ирмэх зуур шил шилээ дарна.

(Д.Урианхай, “Орчлонд найрагчийн заяанд “завилсных”)

...Ай, Хишгээ ямар азгүй билээ. Төрсөн ганц үрийнхээ өмнө, хадам ээж, эр нөхөр, аав, хойт ээжийнхээ өмнө ямар их ичгүүрт унана вэ. Аяа, эх хүн гэгч хэвлийдээ байгаа үрийг үзэн ядах гэж байх уу даа. Түүний оронд энэ нүгэлт амьдралыг, *үхээрийн хар*^{тодотгогч} **дайныг**^{тодотгуулагч} зүхэлтэй.

(Д.Норов, “Мөнхийн дуудлага”)

хэмээн амьдралын орчил дахь “хүнд бэрх”, “зовлон зүдгүүртэй” хэрэг явдал, түүнээс үүдсэн өгүүлэгчийн ертөнцийг үзэх үзэл, сөрөг үнэлэмжийг “ийм тийм хар” гэж тодотгон илэрхийлж байна.

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир: “Монгол хэлний “бор” хэмээх үг, түүний бэлгэдлийн утга хэрэглээний давтамж нь уран сайхны эхийн хүрээнд л үлэмж өвөрмөц олон талтай ажээ. Манай зохиолч найрагчид, уран сайхны эхийн найруулгад яагаад “бор даага”, “бор ходоод”, “миний муу бор хүү”, “бор охин”,

¹⁰⁷ Дулам С., Монгол бэлгэдэлзүй, Уб., 2000.15-р тал.

“бор толгод”, “бор гэр” гэх мэтээр хэрэглэж маш олон бэлгэдэл илэрхийлж, өвөрмөц сонин үнэлэмж гаргаж, сэтгэлийн хөдөлгөөнийг дамжуулдаг нь нөгөө талаасаа, сэтгэц хэлшинжлэлийн үндэстэй юм.”¹⁰⁸ гэж дүгнэсэн байдаг.

Ер нь, монгол уран сайхны эхийн найруулгад тодотгогч-тодотгуулагч харьцаатай дүрслэлт чимэг тодотголын “бор” хэмээх чимэг үг нь “бор толгод”, “бор тал”, “миний муу бор хүү” гэх мэтээр (өгүүлэгчийн) зэрэг үнэлэмжийн өөриймсөж, дотноссон өнгө аясыг илэрхийлэхийн зэрэгцээ хүч нэмэгдүүлсэн тодотгогчийн үүргээр орж, сөрөг үнэлэмжийн олон янз өнгө аясыг тодруулж байдгийг дараах баримтаас харж болно.

...Эцсэн шар хөллөсөн тэрэгний дугуй шиг
Энхэн донхон дайвалзан, залхуутай эргэх
Эгэл жир, *гунигт бор өдрүүд*

...Өрөм хутгасан намрын тараг шиг
Өөг нармай сэтгэлээ бялхам зарав ч, үр хоосон
Өлзий харам, *шаналант бор өдрүүд...*

(Д.Урианхай, “Эгэл бор өдрүүд”)

Шаварт бор орчлонгийн хоногууд
Шаналантай адилхныг яалтай.

(Д.Урианхай, “Авралын дээд дотоод чанад”)


“... Хан дарс мэт үнэнчийг замбуулингаас олсонгүй
Халхын хөх тэнгэр мэт тунгалаг биеийг тэвэрсэнгүй
Ассан зүрхэнд минь халуун нулимс дусна чинээ зүүдэлсэнгүй”
Хорин гурван насны минь *уйт бор үдшүүдийн*
Ийм мөрүүдийг зүрхэнд минь дусаасан юм.

(Ц.Бавуудорж, “Содгэрэл”)

гэх мэт жишээний чимэг тодотголд сөрөг үнэлэмжийн цөхрөн, харууссан өнгө аясыг өгүүлэгчийн үгээр дамжуулан өвөрмөцөөр илэрхийлжээ.

“Бор, хар, бараан” гэх мэт өнгийн бэлгэдэл үгсийг сөрөг үнэлэмж илэрхийлсэн үгстэй зэрэгцүүлэн найруулж, чимэглэн тодотгосон нь өнгөөр бэлгэдэн хийсвэрлэх арга, монгол сэтгэлгээний онцлог, түүний уламжлал шинэчлэлтэй холбоотой юм.

¹⁰⁸ Пүрэв-Очир Б., Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй, УБ., 2005. 145-р тал.



Тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголоор хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдлүүд, түүнд өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн байдлыг ажиглавал,

...*Алагтай булагтай*^{тодотгогч} **хорвоогийн**^{тодотгуулагч}

Амьтантай, цэцэгтэй төөргөндөө

Хүмүүн заяандаа төрүүлсэн

Ээжийгээ хайрлаж яваарай.

(Ц.Чимиддорж, “Ээжийгээ хайрлаж яваарай”)

... Аяа, монгол гэгч ертөнцийн нэгэн тасархай, монголын удам угсаа, улс гүрэн тогтнон нэрээ нэрлүүлтэл мөн ч олон эрин үе улиран өнгөрч, хүний хөлс цусыг шингээсэн өргөн уудам бөгөөд чулуу *шиг хатуу, өд шиг зөөлөн санагдагч*^{тодотгогч} **газар нутаг**^{тодотгуулагч} билээ л. (С.Эрдэнэ, “Занабазар”)

Хараал ерөөл хоёр урсаж байх^{тодотгогч} **орчлон**^{тодотгуулагч}

Харанхуй гэрэл хоёр тэмцэлдэж байх^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч}

Хар цагаан хоёр сүлэлдэн орших^{тодотгогч} **амьдрал**^{тодотгуулагч}

(Ч.Пүрэвдорж, “Ончрол” хэмээх бүлэг шүлгээс)

гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотгол нь эсрэгцсэн утгатай хоршоо үгээр илэрсэн бөгөөд харшууллын эхний үг нь сөрөг үнэлэмжийг илтгэсэн байгаа бол,

...*Үнэнтэй худалтай*^{тодотгогч} **замилангийн**^{тодотгуулагч}

Өдөртэй шөнөтэй чагтгандаа

Үрээн л гэсээр элдэг шүү

Ээжийгээ хайрлаж яваарай.

(Ц.Чимиддорж, “Ээжийгээ хайрлаж яваарай”)

... Дээртэй доортой^{тодотгогч} амьдралд^{тодотгуулагч} өгсөж уруудаж үзсэн ч
Дээвэр дороон жаргалтай элэг бүтэн явлаа.

(Ш.Дулмаа, “Эмтрээ нь үгүй хайр”)

... Ерөөл хараалтай^{тодотгогч} орчлонгийн^{тодотгуулагч} худал хийгээд үнэн
Ерийн ба ер бусыг цэгнэсэн төгс их яруу найраг.

(Т.Сэр-Од, “Яруу найраг”)

гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь чимэг тодотголд хоршоо үгийн эхнийх нь эерэг үнэлэмжийн утгатай байна. Эдгээр нь эсрэг утгатай үгсийг харшуулан найруулсан хураангуй ба дэлгэрэнгүй чимэг тодотголоор сөрөг үнэлэмжийн аргагүй эрхэнд эвлэрсэн, сэтгэл дундуур байгаа өнгө аясыг илэрхийлсэн (дундаж үнэлэмж) гэж хэлж болохоор сонирхолтой жишээ баримтууд юм.

2.1.2. Аль нэг тодорхой хүн ба юм үзэгдэл, тэдгээрт өгүүлэгчийн зүгээс өгч буй сөрөг үнэлэмж нь уран сайхны эхийн найруулгад тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай дүрслэлт чимэг тодотголоор илэрдэг.

Монгол үндэстний соёл сэтгэлгээ, ёс заншилд “монгол хүний эрхэмлэх ёс”, “эх хүний эрхэмлэх ёс”, “эцэг хүний эрхэмлэх ёс” -ийг чухалчлан үзэж, үр хүүхдээ сурган хүмүүжүүлж ирсэн уламжлал бий. Энэхүү эрхэмлэх ёс, соёл сэтгэлгээнээс гажсан зохисгүй үйлийг “гутамшигтай, муу үйл” гэж үздэг, “гутамшигтай, зохисгүй үйл” хийсэн хүнийг “муу хүн” хэмээн үнэлж цэгнэдэг.

Монгол соёл сэтгэлгээнд эр хүнийг уужим ухаантай, хатан зоригтой, бат журамтай, өрх гэрийн түшиг, үр хүүхдийн сүр сүлд хэмээн, эм хүнийг өнгөнд цэвэр, үйлэнд уран, үргэлж цэмцгэр, үрд энэрэлтэй, ханьдаа түшигтэй, настанд ерөөлтэй хэмээн хүндлэн бахархаж ирсэн эерэг үнэлэмжийн жишиг хэмжүүр эртнээс уламжилж ирсэн. Үүний зэрэгцээ эр хүн бор дарсанд шунах, болчимгүй үгэнд автах, болох болохгүй хэргийг сэдэх, үр хүүхдээ хараах, үнэн ханийг гомдоох, үйлийн хэцүүгээс шантрахыг, эм хүн эр бусдыг сэтгэх, атаа жөтөө өвөрлөх, харамч байх, зохилдохгүй үйл үйлдэхийг цээрлэх учиртай. Энэхүү уламжлалт соёл сэтгэлгээ монгол уран сайхны эхийн найруулгад тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай дүрслэлт чимэг тодотголд шингэсэн байдаг.

Хүний (дүрийн) ёс суртахуун, ааш араншингийн “сул тал” буюу “сүүдэртэй” талыг дүрслэн чимэглэснээр сөрөг үнэлэмжийн чамлан голсон, зэвүүцэн дургүйцсэн өнгө аяс илэрч байна. Тухайлбал,

<p>Голсон өнгө аястай: Энэ үгийг сонсуутаа Эзэн Жангарыг харуутаа <i>Зүрхэндээ бүжинтэй</i> ^{тодотгогч} эрчүүд ^{тодотгуулагч} Зүгээ буруулан дутаав гэлээ л (Т.Галсан, “Монгол Жангар”)</p>	<p>Голсон өнгө аястай: Түүнийг байтугай хүнийг хэд дахин нугалаад зангидчих ов зальтай хашир амьтан аргаа боловсруулчихаад хүлээж байсан болохоор <i>богино жолоотой</i> ^{тодотгогч} эмэгтэй хүн ^{тодотгуулагч} яах вэ дээ гэж дотроо бодно. (С.Лочин, “Сэтгэлийн өнгө”)</p>
<p><i>...Эр хүний үнэр тамир суугаагүй</i> ^{тодотгогч} Бормаам ^{тодотгуулагч} алдуурсан бүс, нулимс хоёртоо үүртэн, алсад харагдах олон адуу руу амгай мултлангуут шогших мориныхоо хойноос гүйлээ. (Б.Догмид, “Томоогүй нас”)</p>	<p>...Цэрэндулам эгч болох ноомой даруу байдлаараа тэс өөр, <i>урд хормойгоо чирсэн</i> ^{тодотгогч} махлаг шар хүүхэн ^{тодотгуулагч} ... (С.Эрдэнэ, “Өдрийн од”)</p>
<p><i>Битээ санаатай</i> ^{тодотгогч} Цэдээг ^{тодотгуулагч} Ямар сайндаа л нутгийнхан нь Бэлтрэг гэж хочлох вэ дээ. (Д.Пүрэвдорж, “Хялар хатан”)</p>	<p>Өөртэй нь адилхан цондог толгойтой хэдэн хүүхэд, урд <i>хормойгоо гишгэлсэн</i> ^{тодотгогч} хүүхний ^{тодотгуулагч} царай гэнэ гэнэ харагдах янзтайд бодохгүйсэн гэж биеэ албадан шахжээ. (С.Надмид, “Хар нүдэн”)</p>
<p>Хүн гэж сонин юмаа. Борхүү ийм болчих гэж. Ёстой өрмийн өт шиг гялалзуур, гал бадарсан царайтай золбоотой эр байж билээ. Хөөрхөн ч барилдчихдаг байсан. Очиж очиж энэ муу <i>хөдөлж цөхсөн</i> ^{тодотгогч} хар авгайтай ^{тодотгуулагч} суучих гэж. Юунд нь болдог байна аа. Эр хүний хүрд нь нэг буруу эргэхлээр хамаг сүлдийг нь аваад явчихдаг гэсэн. (Ц.Чимиддорж, “Айлчин”)</p>	

Уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголд эр хүний аймхай, хүчгүй, сул дорой байдлыг ийнхүү сөргөөр үнэлж байгаа нь эрэгтэй хүний хүч чадлыг нийгэм соёлын хүрээнд эмэгтэйчүүдийнхээс илүү нарийн тодоор үнэлдэгтэй өөрөөр хэлбэл эрэгтэй хүний үнэлгээнд хүч гэх ойлголт их чухал байдагтай холбоотой ажээ.¹⁰⁹

¹⁰⁹ Маслова В.А., Введение в когнитивную лингвистику, М., 2008.с.127.

Хүний (дүрийн) ёс суртахуун, ааш араншингийн “сул тал” буюу “сүүдэртэй” талыг сөрөг үнэлэмж бүхий чимэг тодотгол өгүүлбэрээр дүрслэн чимэглэснээр сөрөг үнэлэмжийн чамлан голсон, зэвүүцэн дургүйцсэн өнгө аяс илэрч байна. Тухайлбал,

<p>Чамлан голсон өнгө аястай:</p> <p>Тиймээ, би танхай, энэ довон дээр багтаж шингэхгүй^{тодотгогч} муу хүүтэй^{тодотгуулагч} нь үнэн. Гээд яахав дээ. Төрсөн үр шүү дээ гэж өнгөрснийг эргэцүүлнэ.</p> <p>(Ц.Чимиддорж, “Тэнгэрт хальсан тоос”)</p>	<p>Чамлан голсон өнгө аястай:</p> <p>Төдий удсангүй нөгөө хүн хүрч ирсэн нь хавийн нутгаар ад үзэгдэж, аавын цээж хоч зүүсэн^{тодотгогч} Базаржав^{тодотгуулагч} байсанд баахан урам хугарав.</p> <p>(С.Дашдооров, “Говийн өндөр”)</p>
<p>Шүүмжилсэн өнгө аястай:</p> <p>Дээгүүр харж цээж ханхалздаг^{тодотгогч} тэр залууг^{тодотгуулагч} “Дэгтэй амьтан болохгүй гэж” улс ярина.</p> <p>(Ц.Гайтав, “Хөдөлмөр сүлд”)</p>	<p>Зэвүүцэн, дургүйцсэн өнгө аястай:</p> <p>...Үнэнийг хэлэхэд авах хураахыг утсан чинээ улаан амиараа солихоос буцдаггүй^{тодотгогч} энэ авилгач эрд^{тодотгуулагч} залуу нас, хорвоогийн өнгө хүч хоёрыг ялгах ухаан байхгүй болохоор...</p> <p>(Ш.Шажинбат, “Элс цас”)</p>

Хүний (дүрийн) ёс суртахуун, ааш араншингийн “сул тал” буюу “сүүдэртэй” талыг чимэг тодотгол цогцолбороор дүрслэн тодотгосноор өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн чамлан голсон, зэвүүцэн дургүйцсэн өнгө аяс илэрч байна.

Харууссан өнгө аястай:

Энэ хаашаа хазгай гишгэх нь вэ? Үүнийг яавал хорон үгээр мохоож, уур уцаарыг хүргэх вэ? гээд үргэлж юмны өө сэв харсан хүн олны дотор байдаг. Тийм хүмүүсийн нэг нь Дагва. (С.Лочин, “Сэтгэлийн өнгө”)

Голсон өнгө аястай:

...Суу залиар сулхан

Сурсан эрдмээр дульхан

Байлаа гээд илүүдэх нь бараг

Үгүй гээд дутагдах нь бараг

Ийм л хүн энд явж байна. (Ц.Дамдинсүрэн, “Буурал ээж минь”)

Шүүмжилсэн өнгө аястай:

*Бяруу болоогүй байж бухын явдлаар
таахайн алхаж*

*Хуруу нэмэхээсээ
хошуу нэмэх донтой болж
Жороо морь, чулуун соруулаар
панз үсэргэсэн*

Жолоо татдаггүй танхай нэг **залуу** байлаа.

(Ц.Гайтав, “Хөдөлмөр сүлд”)

Монгол сэтгэлгээгээр хүний сэтгэлийн толь нь нүд, хүний сэтгэлийг шинжинэ гэвэл нүдийг шинжинэ гэдэг. Иймд тухайн дүрийн зан байдал, мөс чанар, сэтгэл санаа буюу дотоод шинж, байдлын “бараан”, “сүүдэр”-тэй талыг уран сайхны дүрслэлт чимэг тодотголоор илэрхийлэхэд “нүд” гэсэн “тодотгуулагч үг” давтамж ихтэй бөгөөд өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн хийсвэр ба бодтой олон янз чимэг тодотгол үгийг захирдаг болох нь ажиглагдлаа. Тухайлбал,

➤ Тогтворгүй, зальжин зан чанарыг;

Гүймхий, ^{тодотгогч} жоотгор **нүдээрээ** ^{тодотгуулагч} юм бүхнийг эргүүлж тойруулаад хүн олон цугларсан газар бол нэг нэгээр ажиглан, зөөлөн хүний харааг хальтруулан, хатуу хүний нүднээс өөрөө хальтран гөлөлзөх бөгөөд явахдаа хүртэл зүгээр явахгүй, хүний урд хойно орж, хөлд орооцолдон огт хэрэггүй юман дээр агдаганан инээнэ. (С.Эрдэнэ, “Өдрийн од”)

➤ Дээрэнгүй, хайрлах нинжин сэтгэлгүй зан чанарыг ;

Согтуу тайжийн тачаангуй нүд Цэнд хүүхнээс салахаа больж, Төмөрийг байн байн **өлөн чонын хурц** ^{тодотгогч} **нүдээр** ^{тодотгогч} ширтэж байлаа.

(Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”)

Нөгөө бөлцгөр зовхит шадар улаан хамгаалагч шигээ амьсгаа нь дээр, цээж нь оволзоод ч байх шиг, юу ч атугай И-гийн *усан* нүд цусан зүрхтэйгээ холбоотой болохыг өнөөдөр тэрхүү *хөмөн хуурай* ^{тодотгогч} **нүдний** ^{тодотгуулагч} харц хэрхэвч нуун далдалж чадахгүй өгүүлж байх болой.

(Д.Маам, “Гишгэх газаргүй хөл”)

Мод түшин зогсох

Сүүдэр шиг тэр залуугийн

Могойн хороор дүүрсэн^{тодотгогч}

Харцанд^{тодотгуулагч} бүү өрт

Түүний нүд увдистай

Түйвээх салхины шидтэй.

(Л.Өлзийтөгс)

➤ Уур омогтой, ширүүн дориун зан байдлыг:

Чамд би хайртай гэж хэллээ.

...Намайг тоосонгүй ээ!

Одод хуйлартал шилбүүрдэн

Жавартай^{тодотгогч} харцаа^{тодотгуулагч} хулжааж

Огт намайг анзаарсангүй ээ!

(Б.Лхагвасүрэн, "Уянгын тойрог")

гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай чимэг тодотголуудаас харагдаж байна.

Хүний гадаад дүр төрхөөр нь дамжуулан зан чанар гэх мэт дотоод шинжийг нь тоочин дүрслэх хэл сэтгэлгээ соёлын онцлог илэрч байгаа нь харагдаж буй бөгөөд дэлхийн бусад хэлнээ ч “нүд харц”-ыг тодорхойлоход иймэрхүү байдлаар адилтган зүйрлэдгийг хэлний соёл судлалын бүтээлд тэмдэглэжээ.

Эдгээрийг нэгтгэн харвал,

Загвар№16



Дээрх жишээнүүдийн чимэг тодотголыг ажиглахад:

1. Эхийн нэгжийн шаталсан тогтолцоонд тулгуурлан харвал, өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрхийлсэн чимэг тодотголын илрэх хэмжээ урт нь

“чимэг тодотгол-үг” , “чимэг тодотгол-нийлэмж үг”, “чимэг тодотгол-өгүүлбэр”, “ чимэг тодотгол-цогцолбор” гэх мэт янз бүр байна. Дэлгэрэнгүй чимэг тодотгол нь гол төлөв “чимэг тодотгол+хүч нэмэгдүүлсэн чимэг тодотгол” гэсэн бүтэцтэй байна. Энэ нь өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн өнгө аясыг илүү тодотгох үүрэгтэй юм.

2. Чимэг тодотгол нь уран яруу дүрслэл зохиох найруулгын ур маяг болохын зэрэгцээ өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн олон янз өнгө аясыг илтгэж байна.

а. харуусан цөхөрсөн өнгө аястай

б. Чамлан голсон өнгө аястай

в. Зэвүүцэн дургүйцсэн өнгө аястай

г. Шүүмжлэн эсэргүүцсэн өнгө аястай

3. Уран сайхны чимэг тодотголоор дамжин монгол зан заншил, соёл сэтгэлгээний онцлог илэрч байдаг онцлогтой.

2.3. Адилтгалт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

Аливаа үнэлэмжийн жишиг хэмжүүр нь харьцууллаас үүснэ. Ямар нэг үзэгдэл, шинж чанарын адилтгал, зүйрлэлийн үндэс нь тухайн ард түмний эдийн болон оюуны соёл, сэтгэлгээний онцлогтой салшгүй холбоотой.

2.3.1. Монгол уран сайхны эхийн найруулгад дүрийн зан байдал буюу дотоод шинж байдлыг тодотгон дүрсэлж, сөрөг үнэлэмжийг илэрхийлэхдээ “амьтаншуулж” адилтгаж ирсэн уламжлал байна.

Монгол үлгэр домогт гардаг хүн дүрстэй, муухай амьтан, арван таван толгойтой атгаалжин хар мангас, (чөтгөр) дүрслэгддэг. Үүнээс “харгис догшин, хайрлах нинжин сэтгэлгүй” хүнийг “мангас”-тай адилтгах үнэлэмж, жишиг хэмжүүр үүссэн байж болох талтай бөгөөд энэ нь монгол уран сайхны эхийн найруулгад тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай адилтгалт дүрслэх ур маягаар илэрч байна.

Хүний (дүрийн) ёс суртахуун, ааш араншингийн “сүүдэртэй” талыг тодотгон гаргахдаа хоч нэрийн шинжтэй уран тодотгол үгээр адилтган чимэглэж,

сөрөг үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн, шүүмжилсэн өнгө аясыг илэрхийлдэг байна. Тухайлбал,

...Алж идэж гэж энэрэхгүй

Адаг мангас^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч} (авгай)

...Цөхрөлтгүй шамдуулах

Чөтгөр хөлт^{тодотгогч} **ертөнц**^{тодотгуулагч} (авгай)

(Д.Равжаа, “Ертөнц авгайн жам”)

..Нийтийн л жишиг, хувьсгалын эсэргүү хорлон сүйтгэгч, германы тагнуулын хэрэгт тулгасан хэрэг. Нэг өдөр *мангас*^{тодотгогч} **Дорж**^{тодотгуулагч} шатаад л байна. Тэгэхээр нь ийм хэрэггүй юманд уурлаад байх юм бол зүрх чинь тэсэхгүй шүү гэж хэлсэнд хүүе гэхийн завгүй үсэрч ирээд алгадчихсан чинь тархи дүүрч, чих хэдэн өдөр дүнгэнэж билээ. Түүнээс хойш зүүн талын чих хатуу болсон шүү.

(Х.Зандраабайдий, “Заяа дутсан бурхад”)

Залуудаа нэлээн ч шуугиулж, шавийн нэртэй бичээч байгаад *мангаа*^{тодотгогч} **Доо**^{тодотгуулагч} явсны нь одоо үзээд хэн таних билээ.

(Б.Ринчин, “Мангаа Доогийн эцсийн зүүд”)

...Ороолон нэрийг хийдийн гэсгүйгээс авч хожмоо үнэхээр энэ нэрэндээ зохицсон хар үйлтэн болжээ. Хорвоогийн жамаар нуруу бөгтийн, нүдэнд нь цайвар хүрээ тогтсон тэр *ороолон*^{тодотгогч} **Балдир**^{тодотгуулагч} чингэж хийх юмаа олж ядан, зугаалагч нарыг дагуулан ирж, Өвгөн хайрханыг анх сүйдлэв.

(Д.Гармаа, “Уулс өвгөрөх цаг”)

...Хаана гээснээ мэдэж байгаа бол та нарын өмнө нүүрээ ингэж улалзуулж зогсохгүй шүү дээ. *Чөтгөр*^{тодотгогч} **Сономынхоос**^{тодотгуулагч} наашаа хөх хөвд болгоныг онгичвол олдох л байх даа. (До Цэнджав, “Чонын алтан шагай”) хэмээн адилтган чимэглэж, хочлон нэрлэснээр өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн өнгө аяс илэрчээ.

“Нохойн явдал нь хүний явдлаас эрс гажуу учраас монголчууд хүний муу явдлыг нохойтой адилтгаж, нохой хүн, нохойн зан, яс булаалдсан нохой мэт, нохой хэрэг, нохойн мөрөөр орох, нохойн наадам, нохойн хороо, нохой гахайдаа хүрэх гэх мэтээр хэлсэн хэлц цөөнгүй байдаг. Энэ бол монголчуудын ухахуун буюу сэтгэлгээний тогтсон хэвшинж, мөн уг явдлыг

үзэх тогтсон хэмжүүрийг илтгэж байна.”¹¹⁰ Монгол хэлэнд “нохой” эзэндээ үнэнч, хүний хань гэсэн эерэг үнэлэмж байдгийн зэрэгцээ ядуу дорой бас муу муухайн шинжийг нохойн явдлаар адилтган илэрхийлдэг сөрөг үнэлэмж бий. Үүнийг дараах уран сайхны эхийн баримтаас харж болно.

Сүн амбанг хороосон *нохой*^{тодотгогч} **Жааяа**^{тодотгуулагч} гэдэгтэйгээ Сономдовдонг хундага тавихгүй архи ууж, хутга тавихгүй мах идэж суухад Базар тэднийхээр оржээ. (Д.Маам, “Газар шороо”)

Энэ цаанаа ийм учиртай “*Адгийн новш*” буюу тэрхүү “*Бэлтрэг*”^{тодотгогч} **Жамъянгийн**^{тодотгуулагч} ганц чаддаг юм гэвэл ямар ч бүжгийг даанч сурамгай хийж, охид хүүхнүүдийн дээлийн ташааны шилбийг тасартал нь улаан булангийн нэг булангаас нөгөө булан хүртэл буруу зөвгүй эргэж олныг алмайруулна. (До.Цэнджав, “Хөх жавар”)

Тийрэн Дорлиг ч ажилгүй, арчаагүй амьтан. Гэхдээ нутгийн юм яахав. Өлссөн цагтаа үе сүүлнээс солиод идэг дээ гэж санахад цээж дотор цэлмэн тайтгарч, үхэхэд гомдолгүй мэт бодогджээ. (Д.Төрбат, “Зул задрах цаг”)

гэх мэтчилэн хэрцгий догшин зан авиртай хүнийг “мангас, чөтгөр, ороолон, тийрэн” -тэй, хүнд муу санадаг, хар муу санаатай хүнийг “нохой”-той адилтган дүрсэлж хочлон нэрлэснээс сөрөг үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн өнгө аяс тодорхой харагдаж байна.

Эдгээрийг нэгтгэж харвал:

Загвар№17



¹¹⁰ Базаррагчаа М., Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай, Уб., 2003. 15-р тал.

2.4. Зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

Зүйрлэл нь тухайн хэлээр харилцагч үндэстний соёлынх нь өвөрмөц онцлог, сэтгэлгээнийх нь өвөрмөц илэрхийлэл байдаг.

Монгол уран сайхны эхийн баримтаас үзэхэд тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь зүйрлэлт чимэг тодотголоор :

А. “Эгэлгүй” зүйлийг “Эрхэм” зүйлтэй

Б. “Эрхэм” зүйлийг “Эрхэм” зүйлтэй

В. “Эгэл” зүйлийг “Эрхэм” зүйлтэй

Г. “Эрхэм” зүйлийг “Эгэл зүйлтэй”

зүйрлэн, өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн эрхэмлэн нандигнасан, омогшиж бардамнасан, уяран баяссан өнгө аясыг илэрхийлдэг бол тодотгогч-тодотгуулагчийн харцаан дахь зүйрлэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн өнгө аясыг илтгэх нь арай өөр онцлогтой байна.

2.4.1. Монголчууд эрт дээр үеэс малыг амжиргааны эх үндэс болгож ирсэн учир малынхаа ааш араншингийн байдалтай хүний зан байдлыг зүйрлэн, “хонь шиг номхон”, “тэмээнийхээ нүд шиг дөлгөөхөн”, “үхэр шиг тэнэг”, яргуй хөөсөн ямаа шиг” гэх мэт монгол үнэлэмжийн жишиг хэмжүүр бий болжээ. Энэхүү монгол үнэлэмжийн өвөрмөц жишиг хэмжүүр нь уран сайхны эхэд “тодотгогч – тодотгуулагч”-ийн харьцаан дахь зүйрлэлт чимэг тодотголоор илэрнэ.

Иймээс уран сайхны эхийн найруулгад дүрийн зан чанар буюу дотоод шинж байдлыг урнаар дүрслэхдээ мал, амьтны ааш араншин, байдал шинжтэй жишиг зүйрлэн, тодотгон чимэглэснээр өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илэрхийлж ирсэн уламжлал байна.

Тухайлбал,

- Малын ааш араншин, байр байдалтай жишин харьцуулсан зүйрлэлт чимэг тодотгол

Над шиг ийм тураалдаа хүрсэн^{тодотгогч} адуу шиг^{тодотгогч} эр ч дээ^{тодотгуулагч}
ихсийн хүрээлэн дотор орж яваад сэтгэл зоригийн тэнхээгүй болохоороо хэнд ч хэрэгтэй үйлийг бүтээж чадахгүй бололтой. (Ж.Лхагва, “Аянга”)

Хөдөөлсөн бух шиг^{тодотгогч} муйхар^{тодотгогч} хар юмнаас (Чулуун)^{тодотгуулагч}
чимээ өгчихдөг золбин нохой айлд арай илүү тустай гэж бодно.

(Ц.Чимиддорж, “Тэнгэрт хальсан тоос”)

...Мал эмчилнэ гэж энэ тэр гэж хэнээрхэж, хаврын борлон шиг^{тодотгогч}
царай^{тодотгуулагч} гаргачихаад л тэнээд явах ямар хэрэг байдаг юм гэж
бодогдох ч үе байлаа.

(П.Лувсанцэрэн, “Хөдөөгийн дуун”)

хэмээн “тураалдаа хүрсэн адуу шиг-эр”, “хөдөөлсөн бух шиг муйхар-хар юм
(Чулуун)”, “хаврын борлон шиг-царай” “ гэсэн тодотгогч-тодотгуулагчийн
харьцаан дахь зүйрлэлт чимэг тодотголоор сөрөг үнэлэмжийн чамлан
голсон өнгө аясыг илэрхийлжээ.

➤ Амьтны ааш араншин, байр байдалтай жишин харьцуулсан зүйрлэлт
чимэг тодотгол

Монгол хүн “муур” –ын төрлийн амьтныг шүтдэггүй, иймээс “муур, шилүүс,
ирвэс” -тэй жишсэн зүйрлэлт чимэг тодотгол нь их төлөв сөрөг үнэлэмжийг
илэрхийлж байна. Жишээ нь:

...Чи чинь яаж галзуурч яваа нь энэ вэ? гээд хэзээ хэзээгүй үсрэхэд бэлэн
болсон муур шиг^{тодотгогч} нүдээ^{тодотгуулагч} гялалзуулан, дуу нь тасхийв. Улаан
дүнсний танил үнэр гэрээр дүүрч, татаж дуусаагүй тамхиа цохилууртаа
ууртай тогшин, дахин нэрж аяглах нь их л цухалдаж байгаа бололтой.

(Б.Дариймаа, “Оройтож буцсан шувуу”)

Хууз сахалд баригдсан хүйтэн царайтай тэр хүн эрэг дээр харайн гарч,
завиа татангуут шилүүсний нүдэрхүү^{тодотгогч} зэвүүн шар нүдээр^{тодотгуулагч}
тоомсоргүй харлаа.

(С.Эрдэнэ, “Хөх хулгана жил”)

Хөөрхий хүүгийн хошуу хөлдөх нь ээ

Хөлдүү, муу хүмүүсийн хөлд үрэгдэх нь ээ

Бүдүүн эр, эрвэс шиг^{тодотгогч} эхнэртэйгээ^{тодотгуулагч} машинаа ухрааж

Битгий замд саад бол, зайлаад өгөөч гэж уурсав.

(Д.Цэнджав, “Хөлдүү хүмүүс”)

гэх мэтчилэн дүрийн (хүний) “ууртай догшин” зан байдал, “зохисгүй их гоёл
чимэг” хэрэглэсэн гадаад байдал зэргийг үл таашаан, зэвүүцэн дургүйцсэн
өнгө аясыг илэрхийлжээ.

Монгол сэтгэлгээнд чоно бол хийморьлог, хүчтэй амьтан гэсэн үзэл
байдаг бөгөөд аян замд явж байхдаа чонотой таарвал олз омогтой явна

хэмээн бэлгэшээдэг. Гэвч, чоныг муу санаатай хар сэжиг ихтэй, хор хөнөөлтэй амьтан гэж ярилцдаг бөгөөд хар муу санаатай, уур ихтэй догшин зантай хүнийг “чоно”, “нохой” -той зүйрлэдэг.

Бас, “нохой” эзэндээ үнэнч, хүний хань гэсэн эерэг үнэлэмж байдгийн зэрэгцээ ядуу дорой бас муу муухайн шинжийг нохойн явдлаар зүйрлэн илэрхийлдэг сөрөг үнэлэмж бий. Үүнийг дараах уран сайхны эхийн баримтаар тодруулъя.

Зовлон жаргал хоёроо ялгахаа байчихсан

Дээлийн өнгөч *нохой мэт*^{тодотгогч} **ноёдыг**^{тодотгуулагч} үзэж унаж тусах

(Д.Равжаа, “Хавар цагийн зугаа”)

...Ер чонотой, бас *чоно шиг*^{тодотгогч} **хүнтэй**^{тодотгуулагч} хорвоод ийм л өвгөд түшигтэй болохыг совингоороо гадарлана. (Д.Төрбат, “Могойн чуулган”)

Уур нь хүрсэн дигбаранз мэт хэрээ мэдэхгүй сүйлэгнэх

Золбин нохой шиг^{тодотгогч} **хүн ч**^{тодотгуулагч} байх юм.

(Р.Чойном, “Залуу нас минь маргааш дуусна”)

“чоно шиг-хүн” гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай зүйрлэлт чимэг тодотголоор “хэрцгий догшин” зан байдлыг, “золбин нохой шиг-хүн” гэсэн тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай зүйрлэлт чимэг тодотголоор “бялдууч, зусарч” зан байдлыг үл таашаасан, шүүмжилсэн өнгө аястай сөрөг үнэлэмжийг тус тус илэрхийлсэн байна.

Монголчууд уул усыг эзэнтэй, догшин лус савдагтай гэж үзэж, түүнийг дээдлэн хүндэлдэг заншилтай. Лусын орон, лусын эзэн, лусын амьтан гэхчлэн ярилцдаг бөгөөд лусын амьтны хамгийн том төлөөлөл нь монгол үндэстний хувьд “могой” байж болох талтай. “Лусын хорлол”-д өртөх, “лус догшруулах”-аас болгоомжилж, могойтой таарвал хүндэтгэлтэй хандаж, тусгай ёс үйлддэг ба могойг нэрээр нь хэлэхээс цээрлэн “урт хайрхан”, “урт хорхой” гэж эерүүлэн хэлдэг. Монголчуудын могойд хандах хандлагад ийнхүү хүндэтгэл, болгоомжлол, айдас жийрхэл хосолж байдаг ажээ. Бас “мууг дагавал могойн хорлол” гэсэн сургаал үг байхын зэрэгцээ муу санаатай, цэвдэг сэтгэлтэй хүнийг “могой”-той зүйрлэн, сөрөг үнэлэмж илэрхийлдгийг уран сайхны зүйрлэлт чимэг тодотголоос харж болно. Тухайлбал,

...Гэвч тэр хиа үг ч хэлж чадахгүй, хүний нүүр өөд ч харж болохгүй *хорт могой шиг*^{тодотгогч} **ийм амьтан (Балбар)**^{тодотгуулагч} орчлон дээр яагаад өөрөө амьд явж болдог юм бэ? гэж бодохоос элэг зүрх минь өмрөн шатах мэт болж, өвдөг чичрээд газар гишгэж ч болохгүй байлаа. (Ж.Лхагва, “Аянга”)

2.4.2. Түүнчлэн монгол аж төрөх ёс, амьдралын хэв маягийн өвөрмөц онцлогоос үүдэж тухайн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар нөхцөл байдал зэргийг үнэлэх жишиг хэмжүүр бий болсон байдаг. Энэхүү жишиг хэмжүүр нь мөн л харьцууллаас үүснэ.

Монгол уран сайхны эхийн найруулгад тухайн дүрийн (хүний) үзэгдэх тал буюу гадаад байдлын “муу, муухай, зохисгүй”-г уран сайхны зүйрлэлт чимэг тодотголоор дүрслэн илэрхийлэхдээ:

...*Борц шиг*^{тодотгогч} *туранхай*

хар юм^{тодотгуулагч} байдаг байсан.

Бондойж таргалаад

Луглагар эр болсон байна. (Ц.Гайтав, “Хөдөлмөр сүлд”)

...Надаас авах юм гэж юү байхав. Адайр зан, *адсага шиг*^{тодотгогч} **хөх царай**,^{тодотгуулагч} хавчиг хар толгой. (Ц.Чимиддорж, “Тэнгэрт хальсан тоос”)

...*Олон жил ажилд нухлагдсан хөдөс шиг*^{тодотгогч} бор **хүүхэн**^{тодотгуулагч} хонь малаа туугаад л ургах нартай гарч, шингэх нартай ирнэ.

(Н.Сүхбат, “Ирж буцахын хорвоо”)


...Бэр болох охин маань охид охидын дундаас анхнаасаа нэг л өөр харагдаад байсан юм. *Адсага шиг*^{тодотгогч} **ааш араншинтай**,^{тодотгуулагч} юм л бол уур уцаар болж байх дуртай хүн юм. (Б.Бааст, “Хөх Дорж”)

...*Хатсан үдээр мэт*^{тодотгогч}

Хорчгор бор өвгөнийг^{тодотгуулагч}

Харуут л элэг барьж болох мэт.. (Ч. Пүрэвдорж, “Өвгөн ба хэл”)

гэх мэт “борц шиг”, “адсага шиг”, “хөдөс шиг”, “хаврын борлон шиг”, “үдээр шиг” гэсэн зүйрлэлт чимэг тодотголоор сөрөг үнэлэмжийн чамласан, голсон өнгө аясыг илтгэсэн зэрэг нь монгол ахуй, мал аж ахуйн гарвалтай зөвхөн манай үндэстний ертөнцийг хэмжиж буйн үр дүн, ертөнцийг ойлгохуй буюу гоозүйн жишиг хэмжүүр гэж үзэж болно.



2.4.3. Нийгэм, хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл, тэдгээрт өгсөн өгүүлэгчийн сөрөг үнэлэмж нь зүйрлэлт чимэг тодотголоор дамжин илэрдэг.

Тухайлбал,

Элгэн дотроо хайрлаж явдаг хорвоо

Нүнжиг жудгаа юунд надаас харамлана?!

Нүүрс хөө шиг^{тодотгогч} *хар* **өдрүүд**^{тодотгуулагч} л цээж тортоглоно.

(Д.Урианхай, “Цээжин орноо урихуй...”)

... *Хараал мэт*^{тодотгогч} **амьдрал дунд**^{тодотгуулагч} ерөөл мэт амьдарч

Хайрын бурхан мэт цэцгэн дунд заларч

Халуун залуу насаа гоо охидод өргөж

Хаврын горхитой шивнэлдэн, усыг нь амсаж явлаа...

(О.Дашбалбар, “Хүүдээ хэлэх үг”)

...*Эцсэн шар хөллөсөн тэрэгний дугуй шиг*

Энхэн донхон дайвалзан, залхуутай эргэх^{тодотгогч}

Эгэл жир, *гунигт бор* **өдрүүд**^{тодотгуулагч}

(Д.Урианхай, “Эгэл бор өдрүүд”)

хэмээн зүйрлэлт чимэг тодотгол, зүйрлэлт чимэг тодотгол өгүүлбэрээр амьдралын мөн чанарыг таньж мэдээд, гунигтай, шаналантай байдлаас үүдсэн өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн бол,

...*Золбин гөлөг мэт*^{тодотгогч}

Эрх чөлөө минь^{тодотгуулагч}

Зодуур үзсэн зовлогот


Гөлөн гөлөн нүдэт минь...

(З.Түмэнжаргал, “Золбин гөлөг мэт эрх чөлөө”)

хэмээн тухайн нийгэм, цаг үеийн өөрчлөлтөд “хөл, толгойгоо олохоо” больсон зарим нэг зөрчилт байдлыг “золбин гөлөг”-тэй зүйрлэсэн нь өвөрмөц дүрслэл болжээ.

Үүнийг загварчлан харуулбал,

Загвар №19



Дээрх жишээнүүдийн чимэг тодотголыг ажиглахад:

1. Хэлэхүй, хэрэглээ, утга талаас харвал, хүний араншин, төрх байдлын зохисгүй, бараан тал, мөнхийн сүүдрийг
 - А. Малын зан байдалтай
 - Б. Амьтны зан байдалтай
 - В. Юмсын чанар байдалтай зүйрлэн тодотгосноор өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн чамлан голсон, зэвүүцэн дургүйцсэн өнгө аясыг илтгэдэг.
2. Монгол уран сайхны эхийн найруулгад зүйрлэлт чимэг тодотгол нь урнаар дүрслэх ур маяг болохоос гадна монгол ахуй, монгол зан заншил, соёл сэтгэлгээнээс урган гарсан үнэлэмж, жишиг хэмжүүрийн өвөрмөц илэрхийлэл болж байдаг. Энэ нь монгол хүний танин мэдэхүйн онцлогтой салшгүй уялдаатай юм.

2.4. Амьдчилалт (хүншүүлэлт) чимэг тодотголоор өгүүлэгчийн сөрөг үнэлэмж илэрсэн нь

Хүний амьдралд оршиж, бас орчиж байгаа элдэв юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг таньж мэдээд, түүнийг үнэлсэн байдал, үнэлэмжийнх нь жишиг хэмжүүр нь амьдчилалт (хүншүүлэлт) чимэг тодотголоор дамжин илэрдэг.

Монгол уран сайхны эхэд хүний амьдралын үй түмэн үзэгдлийн мөн чанар, тэдгээрийн цаг хугацаа-орон зайн дотор орших хувьсал, өөрчлөлт

зэрэгт өгүүлэгч этгээдээс өгч байгаа сөрөг үнэлэмж нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай амьдчилалт (хүншүүлэл) чимэг тодотголоор дамжин илрэх зүй тогтолтой байна.

Өгүүлэгч, хувийн гярхай ажиглалт, амьдралын туршлага дээрээ тулгуурлаж, өөрийн эргэцүүлэл, бодол санаа, сэтгэлийн дотоод ертөнцийг зовоож шаналгаж байгаа зүйлүүдийг орчинтой хуваалцаж, учрыг тунгааж, энэ талаар үнэлэлт дүгнэлт өгч, тодорхойлохыг эрмэлздэг ажээ.

Нийгэм, хүний амьдралын гэм сүүдэртэй тал, хүмүүсийн ёс суртахууны зохисгүй муу муухай шинж байдлыг шүүмжлэн өгүүлэхдээ уран сайхны эхийн найруулгад амьдчилалт чимэг тодотголоор дүрсэлж, өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн өнгө аясыг илэрхийлсэн байдаг. Үүний тод жишээ нь Ноён хутагт Данзанравжаагийн “Ертөнц авгайн жам” хэмээх шүлэг юм. Уг шүлэгт:

Ихчүүдийг нэрэлхүүлсэн
Алиа зант ертөнц
Багачуудыг бачимдуулсан
Багагүй алиа ертөнц
Унтаж гэж барагдахгүй
Ухаангүй нойрмог ертөнц
Алж идэж гэж энэрэхгүй

Адаг мангас ертөнц ... хэмээн дүрсэлсэн нь өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн, шүүмжлэн эсэргүүцсэн өнгө аясыг илэрхийлжээ. Орчин үеийн уран зохиолын жишээ баримтаас авч үзвэл, ...Ямархан хатуу хорвоо билээ дээ. Хямран тэмцсээр, алалдан тулахыг хэн ч зогсоож чадсангүй. Өнөөх л итгэл сүжгийн хүчээр олныг эрхшээлээ гэсэн шашин бурхан ч тус болсонгүй...**Ай, юутай хуурамч**^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч} билээ. (С.Эрдэнэ, “Занабазар”)

...Нээрэн шүү, бид хоёрын сэтгэл үнэнч байсанд итгээрэй! **Нэрэлхүү**^{тодотгогч} **хорвоод**^{тодотгуулагч} бид гурав хожуу учирсандаа л үйлтэйг ойлгоорой!

(Ч.Дагвадорж, “Чамайг би их өрөвддөг юм аа”)

...Зовлон жаргалаар ханаа дугуйлсан **дулдуйч**^{тодотгогч} буурал **хорвоогийн**^{тодотгуулагч} араншин тавьтрыг аргадаж, уужим ухаанаар зодон, хожмын санаагаа тавирааж явдаг энэ хүмүүн манай дэлхий ганцхан гэдгийг мэддэг. (С.Пүрэв, “Аниргүйн цэнхэр аяз”)

хүний амьдарлын орчил дахь шударга бус хэрэг явдлыг тодотгон дүрсэлж, өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн шүүмжлэн эсэргүүцсэн өнгө аясыг илтгэсэн бол,

Сондорт дарагдсан охид

Солгой хоолойтой ч од болдог

Сохор зоосонд үйсэн

Солиотой ч ^{тодотгогч} **орчлон** ^{тодотгуулагч} юм уу даа.

(Ш.Дулмаа, "Монголын эмгэнэл")

Бишрэлийг бурхнаар хуурч

Бие үгүйг чөтгөрөөр хуурч

Аяа, чи өршөөлгүй ^{тодотгогч} **хорвоо** ^{тодотгуулагч}

(Д.Гармаа, "Аяа, хоосон хорвоо")

Инээе гэхэд эмгэнэл, эмгэнээ гэхэд инээд

Ичгүүр үгүй нүцгэн ^{тодотгогч} **хорвоод** ^{тодотгуулагч} төрсөн бид!

(О.Дашбалбар, "Нам гүм аниргүйг хүсэвч")

хэмээн амьдарлын орчил дахь ёс бус, муу муухай хэрэг явдалд өгүүлэгчийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байгаагаа амьдчилалт чимэг тодотголоор илэрхийлжээ. Хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл, түүнд өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмжийн өнгө аясыг илэрхийлэхдээ, хүний мөс чанар, зан байдлын "муу муухай, зохисгүй"-г илтгэсэн утгатай үгсээр амьдчилан чимэглэн тодотгож найруулсан нь давтамж ихтэй тохиолдож байгаа билээ.

Тодотгогч-тодотгуулагчийн харьцаатай амьдчилалт (хүншүүлэлт) чимэг тодотголын утга үүрэг хэрэглээг ажиглахад "тэмдэг үг+нэр үг" (хорвоо) гэсэн бүтэцтэй, гол төлөв хэлэх өгүүлэхийн төвшинд өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн гашуудан харамссан, гомдож цөхөрсөн зэрэг өнгө аясыг илтгэсэн бол,

...Ороо бусгаа ааштай ^{тодотгогч} **орчлон хорвоо** ^{тодотгуулагч} хэцүү

Огоорч мартаж болохгүй ариун үнэн хатуу.

(О.Дашбалбар, "Лимбэний эгшиг")

...Худалч, хулгайч зусарч, бялдуучууд нь өөдлөөд, үнэнч шударга, ажилсаг зоригтой нь уруудаж, сайн нь үхэж, муу нь үлддэг ийм ^{тодотгогч} **хорвоод** ^{тодотгуулагч} агсам тавихад яадаг байна. Сэтгэлдээ хүртэл агсам тавиад,

мордоод арилж өгнө дөө. Их сайн даа л үхдэг юм байгаа биз, илүү яадаг юм
бэ, харалган сохор^{тодотгогч} **хорвоо**.^{тодотгуулагч}

(З.Дорж, “Эрдэнэ засгийн унага”)

Үйлийн үртэй^{тодотгогч} **хорвоогийн**^{тодотгуулагч} шар наранд хөтлүүлсэн

Өтөлж яваа миний насны цагираг дээр учирсан

(Ж.Раднаадаргиа, “Нууцхан сэтгэлийн өчил”)

гэх мэт шууд бус нэрлэлтийн тогтвортой нийлэмжээр өгүүлэгчийн сөрөг
үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн өнгө аясыг илтгэжээ.

Үүний зэрэгцээ,

...Дарлал зовлонгоор жирэмсэлсэн^{тодотгогч} **монгол орны**^{тодотгуулагч} тал бүрээс
зэвсэгтэй, зэвсэггүй, морьтой явган хүмүүс цугларан, эх орон ард түмэндээ
эрх чөлөө, тусгаар тогтнолыг олгох болд илдийг давтаж эхлэв.

(Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”)

гэж тухайн нийгэм цаг үеийн зөрчилт байдлыг дүрслэн тодотгож, өгүүлэгчийн
сөрөг үнэлэмжийн харуусан шүүмжилсэн өнгө аясыг,

...Толгойтой болгон мөнгөнд үхэж

Торготой нэг нь хоргой зүүдлэх^{тодотгогч} **орчлон**^{тодотгуулагч}

(Т.Очирхүү, “Миний муу сайн найзууд”)

...Өнгөтэй залуу явахад өөриймсөг дотно **хорвоо**

Өвгөрч хөгшрөөд ирэхээр өшиглөж орхидог^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч}

Одтой залуу явахад ойртож янаглах **хорвоо**

Орог буурал болоход ойлгуулж түлхэх^{тодотгогч} **хорвоо**^{тодотгуулагч}

(О.Дашбалбар, “Хорвоо”)

гэх мэт амьдчилалт чимэг тодотгол өгүүлбэрээр хүний амьдралын орчил дахь
зөрчилт үзэгдлийг өгүүлэгчийн зүгээс буруушаан шүүмжилсэн өнгө аясыг,

...Зовлонд бялуурсан^{тодотгогч} **ертемций**^{тодотгуулагч}

Золсон нулимсанд дургүй байхад ... (Б.Лхагвасүрэн, “Ингэн хөөс”)

...Нүгэлдээ хохсон^{тодотгогч} энэ **хорвоод**^{тодотгуулагч} тэр харцнаас ариун юм гэж
байна уу даа. Ариун чигээрээ байгаасай гэсэндээ л Даш ийнхүү шаналж
явсан юм даа.

(Д.Норов, “Сэрвэгэр хадны зэрэглээ”)

гэсэн амьдчилалт чимэг тодотгол өгүүлбэрээр амьдралын орчил дахь
түгээмэл үзэгдэлд өгүүлэгчийн зүгээс өгсөн сөрөг үнэлэмжийн зэвүүцэн
дургүйцсэн өнгө аясыг,

Хүйтэн сарны

Хөмсөг нь цантай ширвэх

Хундан үүлсийн

Хэвлий нь хуртай дунших^{тодотгогч}

Яасан жиндүү **орчлон**^{тодотгуулагч} бэ? (С.Ууганбаяр, “Жиндүү орчлон”)

гэж өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн гуниглан харууссан өнгө аясыг тус тус илэрхийлсэн байдаг.

Өгүүлэгч, тухайн цаг үеийнхээ зөрчилт нөхцөл байдлыг тод томруунаар зурж үзүүлэхдээ өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн зэвүүцэн дургүйцсэн, цөхрөн харууссан, шүүмжлэн эсэргүүцсэн өнгө аястай амьдчилалт чимэг тодотгол цогцолборыг дүрслэх ур маяг болгожээ.

1.мэдэгдэхүүн, 2.хэлэгдэхүүн, 3.мэдэхүүн, 4.хэлэхүүний талаас нэгтгэн загварчилвал: Загвар№20



гэсэн утга-бүтэц-үүрэг-хэрэглээ гэсэн харьцаа хамаарал харагдаж байна.

3. Дүгнэлт

Хоёр бүлэг бүхий “Дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн үнэлэмж илэрснийг судалсан нь” сэдвээр судалгааны ажил хийгээд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Дүрслэлт чимэг тодотгол нь тухайн зохиолчийн уран сайхны сэтгэлгээний илэрхийлэл, уран яруу найруулах ур маяг болохын зэрэгцээ өгүүлэгчийн эерэг ба сөрөг үнэлэмжийн олон янз өнгө аясыг илэрхийлж байна.
2. Уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголоор өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн бардамнаж омогшсон, хүндэтгэн дээдэлсэн, сайшаан магтсан, гайхан биширсэн, өөриймсөж дотноссон, өхөөрдөж энхрийлсэн зэрэг олон янз өнгө аяс, өгүүлэгчийн сөрөг үнэлэмжийн цөхрөн харууссан, чамлан голсон, зэвүүцэн дургүйцсэн, шүүмжлэн эсэргүүцсэн зэрэг олон янз өнгө аяс илэрдэг.
3. Байгаль ертөнц, хүний амьдралын орчил дахь түгээмэл үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг монгол хэл-соёлт үндэстэн таньж мэдээд, түүнийг үнэлсэн байдал, үнэлэмжийн жишиг хэмжүүр нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь дүрслэлт чимэг тодотголоор илэрч байна.
4. Дүрслэлт чимэг тодотгол нь нүүдэлчин монголчуудын байгаль дэлхий, уул ус, нутаг орноо анхдагчийн хэмжээнд өргөмжлөн, шүтэн бишрэх соёл сэтгэлгээ, гэр бүл, хүмүүсийн хоорондын харилцааны эрхэмлэн хүндэтгэх ёс заншил, уламжлалт аж төрөх ёс, малч арга ухаан, соёл сэтгэлгээний онцлогийг илэрхийлж байдаг.
5. Уран сайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголыг эхийн нэгжүүдийн шаталсан тогтолцоонд тулгуурлан харахад дүрслэлт чимэг тодотгол-дан нэр үг, дүрслэлт чимэг тодотгол-нэрийн холбоо болон хэл, хэлэхүйн төгс нэгж дүрслэлт чимэг тодотгол-өгүүлбэр, дүрслэлт чимэг тодотгол-цогцолбор гэсэн нэгж бүрд хамаатай байна.
6. Дүрслэх ур маягийн төрлүүдээс чимэг, адилтгал, зүйрлэл, амьдчилал, хэтрүүлэл нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаанд суурилан илэрнэ.

4. АННОТАЦИЯ ДИССЕРТАЦИИ НА ТЕМУ “ИССЛЕДОВАНИЕ ВЫРАЖЕНИЯ ОЦЕНКИ ГОВОРЯЩЕГО ЧЕРЕЗ ОБРАЗНОЕ ОПРЕДЕЛЕНИЕ” (НА ПРИМЕРАХ ИЗ МОНГОЛЬСКОГО ХУДОЖЕСТВЕННОГО ТЕКСТА)

Актуальность исследования темы:

Современная лингвистика, культурология, литературоведение, а также философское мышление в настоящее время большое внимание стали обращать дискурсивному анализу текста, который является “ядром” письменной культуры. Многообразие длинных и коротких определений, используемых на уровне художественного текста, стилистические функции и богатые оттенки детерминантов, их семантика представляют собой интереснейшую тему, надлежащую специальному исследованию. Рассмотрение взаимоотношений между определяющими и определяемыми, их типов, семантических особенностей, а также валентности в тесной взаимоувязке с различными видами тропов в монгольском языке, национальной культурой и национальным мышлением монголов, с оценкой говорящего имеет большое значение для современной лингвистики, стилистики, словотворчества, синтаксиса и текстологии.

В последние десятилетия в науке о языке появились такие новые направления, как лингвокультурология, когнитивная лингвистика, лингвистика речи и т.д., которые во главу угла прежде всего ставят семантические и прагматические стороны языка, что, в свою очередь, обусловило важность изучения статичности и динамичности самого языка.

Цель исследовательской работы:

В настоящее время весьма важным и интересным объектом для изучения является исследование того, как человечество вообще, и отдельно взятая нация – носитель конкретной культуры, в частности, познаёт и оценивает универсальные явления, те или иные процессы, различные события и их признаки, которые происходят в природе и в человеческой жизни, что именно является критерием данной оценки, какими при этом методами и единицами оперируют.

Целью нашей исследовательской работы являются исследование и интерпретация с опорой на тот или иной стиль художественного текста особенностей национальной культуры и мышления, результатов национального мышления и оценки говорящего, выражающихся через образные определения, имеющие соотношение “определяющее+определяемое”.

Задачи исследовательской работы:

1. Интерпретация с опорой на материалы из художественного текста того, что познание и понимание окружающего мира, особенности национальной культуры и национального мышления выражаются через образные определения;
2. Изучение с опорой на художественный текст возможностей выражения различных оттенков положительной и отрицательной оценки говорящего через образные определения, имеющие соотношение “определяющее+определяемое”.
3. Изучение на уровне художественного текста типов образных определений, их семантико-стилистических функций и особенностей видов управления;
4. Рассмотрение тропов, употребляемых в качестве определения, их типов, функций и употребления с позиций картины мира-языка-речи-коммуникации;
5. Рассмотрение объёма образно-художественных определений на уровне иерархической системы предложения и текста в монгольском языке;

Новизна исследовательской работы:

Практика показывает, что грамматическое определение в монгольском языке довольно широко исследовано в плане его формально-грамматической стороны, однако его стилистическая образность какому-либо изучению почти не подвергнута.

Новизна исследовательской работы видится нами в том, что в ней семантика, функции, типы и особенности образных определений,

используемых в в монгольском художественном тексте со специфической функциональной нагрузкой, впервые рассмотрены в комплексном виде, охватывающем семантику языка, форму языка, стилистику и прагматику языка в целом в рамках картины мира-языка-речи-коммуникации и предпринимается попытка охарактеризовать образные определения как единицу текста, которая призвана выражать специфику национального мышления и познания национальной культуры, а также ту или иную оценку самого говорящего.

В первой главе исследовательской работы рассматривается выражение экспрессивной оценки говорящего в монгольском художественном тексте через образные определения, при этом с опорой на виды изобразительного мастерства образные определения классифицируются нами на подвиды, в результате чего экспрессивные оценки говорящего сгруппированы на оценки, данные:

- окружающему миру;
- универсальным явлениям, характерным человеческой жизни;
- тому или иному конкретному человеку, вещи или явлению.

Во второй главе диссертации рассматривается выражение неэкспрессивной оценки говорящего в монгольском художественном тексте через образные определения, при этом с опорой на виды изобразительного мастерства образные определения классифицируются нами на подвиды, в результате чего неэкспрессивные оценки говорящего сгруппированы на оценки, данные:

- универсальным явлениям, характерным человеческой жизни;
- тому или иному конкретному человеку, вещи или явлению.
-

В результате проведенного исследования диссертант приходит к следующим выводам:

1. Образное определение является выражением художественного мышления данного писателя и средством его изящного стиля, наряду

с этим оно выражает различные оттенки экспрессивной и неэкспрессивной оценки со стороны автора.

2. Посредством образных определений в художественном тексте передаются такие различные оттенки экспрессивной оценки говорящего, как гордость и преклонение, уважение и почтительность, одобрение и восхваление, изумление и восхищение, отношение по-свойски, ласка и нежность, а также такие различные оттенки неэкспрессивной оценки, как отчаяние и досада, недовольство и пренебрежение, отвращение и ненависть, критика и сопротивление и т.д.
3. Познание носителем монгольского языка и монгольской культуры универсальных явлений, событий в окружающем мире, в человеческой жизни и их признаков, их оценка, критерии данной оценки выражаются через образные определения, находящиеся в соотношении “определяющее+определяемое”.
4. Образное определение выражает все нюансы и оттенки специфических особенностей национального мышления и национальной культуры, традиционного кочевого образа жизни монголов-кочевников, которые превыше всего ставят окружающую природу, свой родной край с его горами и реками, преклоняясь перед ними как перед святыней, с особой предпочтительностью уважительно относятся к старшим, стремятся к добрым и миролюбивым отношениям между людьми.
5. Если образные определения в художественном тексте рассматривать в иерархической системе единиц текста, то им характерна структура типа: образное определение- словоформа-существительное, образное определение-словосочетание, образное определение-предложение, образное определение-высказывание.
6. Из всех видов изящного изображения в соотношении “определяющее+определяемое” могут находиться эпитет, сравнение, метафора, одушевление /очеловечивание/ и гипербола.

5. Номзүй

Эш татсан судалгааны ном, нэг сэдэвт зохиол, өгүүлэл

Нэг. Монгол хэлээр:

1. Алтансүвд М., Уран зохиол дахь зүйрлэл, ХИС, Хэл, соёл, соёл хоорондын харилцаа, Олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын материалын эмхтгэл. УБ., 2009.
2. Базаррагчаа М., Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр, УБ., 1993.
3. Базаррагчаа М., Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай, УБ., 2003.
4. Базаррагчаа М., Монгол хэлний өгүүлбэр судлал, УБ., 2005.
5. Бадамдорж Д., Монгол хэлний утга судлалын үндэс, УБ., 1998.
6. Бадамдорж Д., Монгол хэлний үгийн сангийн утгазүй, УБ., 2006.
7. Баянсан Ж., Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, УБ., 2002.
8. Баянсан Ж., Эхээ үзэх монгол сэтгэлгээний онцлог, МУИС, МХСС, Монгол судлал, Эрдэм шинжилгээний бичиг, УБ., 1998.
9. Баянсан Ж., Хэл, соёлын хамаарлын асуудалд, МУИС-ийн Монгол судлалын Эрдэм шинжилгээний бичиг, УБ., 2004.
10. Бямбасан П., Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгийн аймаг, УБ., 1975.
11. Барайшир Ш., Өгүүлбэрийн гишүүн, УБ., 1980.
12. Баатартогтох Ц., Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал, Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ., 2000.
13. Вандуй Э., Өгүүлбэрийн дэд гишүүн тодотголын тухай, УБ., 1958.
14. Гаадан Х., Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл, УБ., 1986.
15. Гаадамба Ш., Утга зохиолын онолын товч, УБ., 1958.
16. Гаадамба Ш., Утга зохиолын онолын үндэс, УБ., 1989.
17. Галбаатар Д., Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь, Токио., 2002.
18. Галбаяр Г., Уран зохиол шинжлэлийн үүд, УБ., 2003.
19. Даваасүрэн Б., Орчин цагийн монгол хэлний жинхэнэ нэрийн хүншүүлсэн утга, УБ., 2009.
20. Гомбосүрэн Ц., Философи, УБ., 2008
21. Дорждагва Т., Соёл судлал, УБ., 2010.

22. Дулам С., Хасбаатар Ц., Уран зохиолын онолын үүд, Уб.,1980.
23. Дулам С., Монгол бэлгэдэлзүй, Уб., 2000.
24. Дулам С., Монгол бэлгэдэлзүй, II, Уб., 2007.
25. Зэгиймаа Ч., Прагматик хэлшинжлэл, Уб., 2010.
26. Жамъянгарав С., Цаглахуй санааны найлзуур мод, (Хүрэлбаатар.Л)
Уб., 2011.
27. Мөнх-Амгалан Ю., Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб., 1998.
28. Нансалмаа Н., Хэлшинжлэлийн судалгааны аргазүй, Уб., 2011.
29. Нансалмаа Н., Үгийн сан судлал, Уб., 2005.
30. Нансалмаа Н., Үг: утга,хэрэглээ, Уб., 2011.
31. Отгонсүрэн Д., Монгол хэлний найруулгазүй, Уб.,1975.
32. Отгонсүрэн Д., Монгол хэлний үгийн сангийн найруулгазүй, Уб.,1997.
33. Отгонсүрэн Д., Монгол хэлний хэлзүйн найруулгын өгүүллүүд, Уб.,1996.
34. Одонтуяа Л., Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог,
докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Уб.,2004.
35. Өнөрбаян Ц., Орчин цагийн монгол хэлний үгзүй, Уб., 2004.
36. Пүрэв-Очир Б., Монгол хэлний эх задлалын асуудлууд, Уб.,2002.
37. Пүрэв-Очир Б., Үг, өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл
хэрэглээ, 8 дугаар дэвтэр, Уб.,2011.
38. Пүрэв-Очир Б., Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй, 4 дүгээр дэвтэр, Уб.,
2005.
39. Пүрэв-Очир Б.,Гулираанз З.,Монгол хэлний өгүүлбэрзүйн онол-
практикийн зарим асуудал, Уб.,1993.
- 40.Пүрэв-Очир Б., Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн-
зохиолч, Уб.,2008.
- 41.Пүрэвжанцан А.,Үгийн утга шилжих тухайд,МУИС,МХСС, Монгол
судлал, Эрдэм шинжилгээний бичиг, Уб.,1999.
42. Равдан Э., Бүтэц хэлшинжлэл, Уб.,1998.
- 43.Радугин А. А., Гоозүй,(орчуулсан Алтанзаяа Н., Энхцогт Н.,) Уб., 2011.
44. Сүхбаатар Ц., Монгол хэлний найруулгазүй, Уб., 2007.
- 45.Сүхбаатар Ц., Найруулгазүйн нэртомъёоны тайлбар толь, Уб., 2003.
- 46.Сүхбаатар Ц., Орчин цагийн монгол хэлний найруулгазүй, Уб.,1988.
- 47.Сүхбаатар Ц., Найруулан бичих арга ухаан, Уб.,1993.

48. Сүхбаатар Ц., Эхийн найруулгазүй, тэргүүн дэвтэр, УБ., 2001.
49. Тогтуун Э., МУИС, МХСС, Монгол судлал, Эрдэм шинжилгээний бичиг,
УБ., 2010.
50. Төмөрбаатар Ж., Гоозүйн үндсэн категорууд, УБ., 1998.
51. Төмөрцэрэн Ж., Монгол хэлний үгийн сангийн судлал, УБ., 2001.
52. Төмөрхуяг Б., Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив
хэлшинжлэлийн үүднээс судалсан нь, УБ., 2011.
53. Ууганбаяр М., Метоним, метафор хэмээх ойлголт ба эхийг унших ерөнхий
загварын нэгэн жишээ, МУИС, МХСС, Монгол судлал, Эрдэм шинжилгээний
бичиг, УБ., 2007.
54. Хүрэлбаатар Л., Огторгуйн цагаан гарьд, УБ., 1996.
55. Хүрэлбаатар Л., Эсэруагийн эгшиг дуун, УБ., 1999.
56. Хүрэлбаатар Л., Цаглахуй санааны найлзуур мод, УБ., 2011.
57. Цэрэнчимэд Л., Уран сайхны эхийн найруулгад илэрсэн онцлог,
хэрэглээ, УБ., 2010.
58. Чулуундорж Б., Орос хэлний утгазүйн тайлбар бичиг, УБ., 1985.
59. Чулуундорж Б., Когниц: Сэтгэл судлал-хэлшинжлэл-мэдлэгийн онол,
УБ., 2001.
60. Энхбаяр С., Утга зохиолын онол, УБ., 2011.

Хоёр. Орос хэлээр:

1. Ахманова О.С., Словарь лингвистических терминов, М., 1966.
2. Артюнова Н.Д., Языковая метафора: (Синтаксис и лексика), Лингвистика и поэтика, М., 1979.
3. Бертегаев Т.А., Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении простое предложение, М., 1964.
4. Баранов А.Н., Караулов Ю.Н., Русская политических метафора, Материалы к словарю, М., 1991.
5. Ерасов Б.С., Социальная культурология, М., 1998.
6. Канке В.А., Философия, УБ., 2001.
7. Лакофф Дж., Джонсон М., Метафоры которыми мы живем, // Теория метафоры, М., 1990.
8. Маслова В.А., Введение в когнитивную лингвистику, М., 2008.

9. Ожегов С.И., Словарь русского языка, М., 1975.
10. Папина А.Ф., Текст его единицы и глобальные категории, М., 2004.
11. Равдан Э., Сопоставительная стилистика русской и монгольской художественной речи, часть 1, Уб., 1994.
12. Ричардс А., Философия риторики // Теория метофоры., Прогресс, М., 1990.
13. Розенталь Д.Э., Голуб И.Б., Секреты стилистики, М., 1999.
14. Розенталь Д.Э., Практическая стилистика русского языка, М., 1968.
15. Розенталь Д.Э., Теленкова Л.А., Словарь-справочник лингвистических терминов, М., 1976.
16. Тимофеев Л.И., Основы теории литературы, М., 1976.
17. Ярцева В.А., Большой энциклопедический словарь языкознания, М., 1998.